Цагдаагийн байгууллага, алба хаагчийн хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн”, Гучин наймдугаар зүйлийн 2 дэх хэсгийн 7 дахь заалт “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх”³⁴, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйл “Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна”, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Агентлаг нь Засгийн үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.”, Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах, хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.”³⁵ гэж тус тус зааснаар тодорхойлогдоно.

Цагдаагийн институтэд хүмүүсийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах, эрүүгийн хуулийг сахиулах, эрүүгийн мөрдөн байцаалт, замын хөдөлгөөнийг зохицуулах, олон нийтийн газрын хяналт болон олон нийтийг хамгаалах үүргүүд багтана. Нэр томьёо нь улс, улсад өөр байдаг боловч барууны ихэнх цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон илрүүлэх үүрэгтэй байдаг.³⁶

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь бүхэлдээ нийтийн сайн сайханд үйлчлэхэд чиглэх ба чиг үүргийг нь нэлээд өвөрмөц байдлаар авч үздэг онцлогтой. Тухайлбал, гэмт хэрэгтэй тэмцэх хууль хяналтын системд болон хууль сахин хамгаалах хүрээн дэх нийтийн үйлчилгээний системийн салшгүй хэсэг бөгөөд иргэд, олон нийтэд үйлчлэх үүргийг хүлээдэг.³⁷ Мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах бөгөөд бусад хууль тогтоомж болон олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу эрх мэдлээ бусад улсад мөн эдлэх эрхтэй.

Үйл ажиллагаа явуулахдаа төрийн болон засаг захиргаа, олон нийтийн, хувийн хэвшлийн байгууллага, ард иргэд, гадаад орны болон олон улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажилладаг байна. Тухайлбал, Зүүн, зүүн өмнөд европын Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх бүс нутгийн санаачилга (Southeast European Cooperative Initiative, SECI), Олон улсын миграцын бодлого боловсруулах төв (International Centre for Migration Policy Development, ICMPD), Олон улсын цагаачлалын байгууллага (International Organization for Migration, IOM), Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага (International Criminal Police Organization ICPO-INTERPOL) гэх мэт олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэн орж хамтран ажиллаж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг цагдаагийн төв байгууллага хэрэгжүүлэхдээ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэг³⁸-т заасны дагуу хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон Монгол Улсын сайдын шийдвэрийг биелүүлэх ажлыг чиг үүргийн хүрээнд зохион байгуулж, биелэлтийг хангаж ажилладаг.

Өнөөгийн нийгмийн харилцаа нь аливаа байгууллагаас шинэлэг хандлага, ажлын шинэ арга барилыг шаардаж байна. Монголын цагдаагийн байгууллага нэгэн адил өөрийн бодлого, үйл ажиллагаандаа өөрчлөлт шинэчлэл хийж дэс дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа ба цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд ойртуулах, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байгууллагын стратеги бодлого, түүнийг амьдралд хэрэгжүүлдэг дээд болон дунд шатны удирдах ажилтнууд цагдаагийн бие бүрэлдэхүүний идэвхтэй, санаачилгатай оролцоо зайлшгүй чухал болжээ.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд захиргааны үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх ажлыг эхлүүлж, үүний үр дүнд

³⁴ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

³⁵ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

³⁶ Nicolas Delamare. Traité de la Police (Treatise on the Police), 1705.

³⁷ Цогтоо. Ш, Захиргааны эрх зүй. Тусгай анги. Уб., МУИС. 2015. 126 дахь тал.

³⁸ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. Уб., 2004. №75.

захиргааны эрх зүйн салбарт хамаарах 250 орчим хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнээс “Цагдаагийн албаны тухай” хууль батлагдсанаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндэс бүрдэж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг төрөлжүүлж өгсөн байна.

Нийгмийн хэв журмыг хууль тогтоомж, зан заншил, ёс суртахууны шаардлагын алинаар нь ч тогтоосон байж болох боловч цагдаагийн байгууллага, алба хаагч нь зөвхөн хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг хуульд заасан хүч, арга, хэрэгслийг ашиглан сахиулах үүрэгтэй.³⁹

Мөн Цагдаагийн албаны тухай хууль⁴⁰-ийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн” гэж тус тус тодорхойлсон байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны зүй тогтол, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актууд чухал байр суурь эзэлдэг төдийгүй, Цагдаагийн байгууллагын алба хаагч нар нь өдөр тутмын үйл ажиллагаандаа эрх зүйн актуудыг хэвшмэл болгож ашиглах шаардлагатай байдаг. Цагдаагийн алба хаагчийн үнэнч шударга байдал, хууль хэрэгжүүлэх чадамжаас шалтгаалан нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хэрэгжилтэд олон нийт шүүмжлэлтэй ханддаг нь ойлгомжтой байна.

Үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиг үүрэг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэгд тооцогддог. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын тогтолцоо нийгмийн хөгжлийг даган хувьсан өөрчлөгдөж байсан ч тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үүргээр ангилан зохион байгуулах байдал зонхилж байна.

Онолын зохих түвшин, цагдаагийн байгууллагын чиг үүргийн өнөөгийн практик хэрэгжилтийн зарим судалгаанд тулгуурлан авч үзвэл Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг, зорилтыг практикт хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үндсэн шинж, агуулга, эрх зүйн мөн чанараар өөр хоорондоо холбоотой захиргааны бүлэг, нэг төрлийн үйлдлийн гадаад илрэл гэж судлаач хувьд үзэж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн хэлбэрийг агуулга, зорилгын чиглэл, илэрхийлэгдэх аргаар нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Эрх зүйн хэлбэрийн агуулгаар нь зөвхөн дотоод харилцаанд хэм хэмжээ бүтээх, эрх зүйг хэрэглэх гэсэн 2 хэсэгт хуваана.

Цагдаагийн байгууллагад эрх зүйн хэм хэмжээ бүтээх хэлбэрийг байгууллага, алба хаагч бүр ашигладаггүй, цагдаагийн удирдах төв байгууллага (цагдаагийн ерөнхий газар), хууль тогтоомжийг зөвөөр хэрэглэх тухай заавар удирдамж гаргах, эрх хэмжээнийхээ дотор ажлынхаа журмыг тогтоох замаар хэм хэмжээ бүтээдэг. Эрх зүйг хэрэглэх нь цагдаагийн байгууллагын аль ч үйл ажиллагааны үндсэн хэлбэр мөн. Энэ нь хууль зүйн ач холбогдол бүхий ямар нэгэн хэрэг, асуудлыг эрх зүйн хэм хэмжээг баримтлан шийдвэрлэх тодорхой үйлдлээр илэрнэ. Цагдаагийн байгууллагын эрх зүйг хэрэглэх үйл ажиллагаа нь тодорхой асуудал, хэргийг эрх зүйн чухам ямар хэм хэмжээний дагуу явуулахыг тогтоох: тухайн нөхцөл байдалд тохирохуйц зохих хэм хэмжээг дотроос нь эрж олж, сонгон авах (гэхдээ хуулийн хүчинтэй эсэх, түүнийг хэрэглэх цаг хугацаа, үйлчлэх хүрээ зэргийг магадлан шалгах) уг хэмжээний агуулга, санааг тодотгон тайлбарлах: Улмаар тухайн асуудал, хэргийн шийдвэр гаргах: түүнийгээ хэрэгжүүлэх (биелүүлэх) явдлыг өөртөө багтаана. Цагдаагийн алба хаагчийн үндсэн үүргийн хэрэгжилт, ажил хэргийн үр дүн гүйцэтгэлийн хяналт шалгалт зэрэг цагдаагийн үйл ажиллагаанд эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж хийгдэх бусад үйлдэл нь мөн энд хамаарна. Шийдвэрлэж буй асуудал, хэргийн шинж байдал, эрх зүйн хэм хэмжээний онцлогоос

³⁹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. 400. Уб., 2022.

⁴⁰ Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл. 2020. №9.

хамааран эрх зүйг хэрэглэх хэлбэрийг дотор нь захиран тушаах буюу зохицуулах, хууль хэрэгжүүлэх гэсэн 2 хэсэгт хувааж болно.

Зохицуулах (зохицуулан журамлах) хэлбэрийг зохион байгуулах, удирдан захирах шинжтэй тодорхой асуудал, хэргийг шийдвэрлэх, тухайлбал албан тушаалд томилох, цагдаагийн алба хаагчид үүрэг, даалгавар, заалт чиглэл өгөх зэрэг болон хүний эрх, эрх чөлөө, оролцогч бусад субъектийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан хангах зэрэг захиргааны үйл ажиллагаанд гол төлөв ашиглана.

Хууль хэрэгжүүлэх хэлбэр нь нэг талаас хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхол, халдашгүй дархан байдлын хууль тогтоомжийн дагуу хангах: нөгөө талаас захиргааны эрх зүйн болон хууль зүйн үүргээ биелүүлээгүй этгээдэд шаардлагатай бол төрийн албадлага хэрэглэх үүргээр илэрнэ. Өргөн утгаар нь хэлбэл энэ хэлбэрийг цагдаагийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ холбоотой эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байгаа нийгмийн харилцааг хамгаалахад хэрэглэнэ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйг хэрэглэх аргыг зорилгын чиглэлээр нь дотоод гадаад гэж ангилах ба дотоод аргад удирдлага орон тоог оновчтой зохицуулах, албан хэрэг хөтлөх, дотоод шатны байгууллага, алба ажилтнуудыг шууд удирдлагаар хангах түүнчлэн боловсон хүчин, материал-техникийн болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны бусад хангалтын асуудлыг шийдвэрлэх зэрэг ажиллагаа хамаарна. Гадаад аргад нь цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч эрх бүхий субъектээс гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэм журам хамгаалах үүрэг зорилтын биелэлтийг хангах явдлаар илэрнэ.

Цагдаагийн байгууллагын эрх зүйг хэрэглэх үйл ажиллагааны үр дүнтэй нэлээд түгээмэл хэлбэр нь нэг бүрчилсэн акт, баримт бичиг үйлдэх явдал юм. Энэ нь уг асуудал, хэргийг шийдвэрлэх үедээ эрх зүйг хэрэглэх ажиллагаагаа нягт нямбай, товч тодорхой үйлдэл, үйл явдлын болсон байдлаар нь бэхжүүлэх замаар хийгдэнэ. Үүний зэрэгцээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагаандаа ам тушаал, даалгавар, захирамж, заалт өгөх замаар “Үгээр илэрхийлэх хэлбэрийг өргөн ашиглана”. Энэ нь асуудлыг шуурхай шийдвэрлэх практик ажиллагаанд өдөр тутам байнга хэрэглэгддэг онцгой хэлбэр юм.⁴¹

Харин ЦБҮАЖК-ын гуравдугаар бүлгийн Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагаа код 300-329 зүйлд: Гэмт хэрэг илрүүлэхэд орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах; гэрэл зураг, дуу авиа, дүрс бичлэг хийж, ашиглах; гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд полиграф ашиглах; банк, банк бус санхүүгийн байгууллагаас мэдээлэл авах; эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээлэл авах, тусгай тэмдэглэл хийлгэх; гэмт бүлэглэлийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах; мөрдөн шалгах ажиллагааны мэргэжлийн зөвлөл, түүний үйл ажиллагааны чиглэл; гүйцэтгэх ажил явуулах; хялбаршуулсан хэрэг бүртгэлт явуулах; сонгуульд нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах зөвшөөрөл хүсэх, төрийн зарим албан хаагчийн талаар заавал мэдэгдэх; мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой хэргийг шалгах, баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах; эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн туслалцаа үзүүлэх; гэмт хэргийн холбогдогчийг шилжүүлэх ажиллагаа; Монгол Улсаас гарахыг түр түдгэлзүүлэх; хүүхдийн эрхийг хангах; бэлгэсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаарх авах арга хэмжээ; түүх соёлын дурсгалт зүйлийг гадаад улсаас эргүүлэн авчрах; ял эдэлж буй ялтныг шилжүүлэн авах; эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг гаргуулан авах; сэтгэцийн өвчтэй хүний үйлдсэн гэмт хэргийг шалгах; түдгэлзүүлсэн хэрэгт хийх ажиллагаа; эрүүгийн хэрэг, материалыг дугаарлах; уулзалт байцаалтын хэсгийн үйл ажиллагаа; ой, хээрийн түймрийн тухай мэдээлэл түүнийг шалгах; гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх; эрүүгийн хэргийн танилцуулга бичих; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт хяналт тавих; хураан авсан, битүүмжилсэн эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах⁴² зэрэг чиг үүргийг

⁴¹ Долгорсүрэн. Ж, Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. Уб., 2000. 176-178 дахь тал.

⁴² ЦБҮАЖК. Уб., 2022. Код 300-329.

хэрэгжүүлэхээр заажээ. Энэхүү ЦБҮАЖК-с үзэхэд цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх ажил явуулах эрхтэй байгааг харуулж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйл⁴³-д зааснаар гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд мөрдөн шалгах нууц ажиллагааг цагдаагийн байгууллага бие даан явуулна. ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, түүний орон нутаг хариуцсан газар, хэлтэс, нэгж эрхлэн явуулахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль ёсны ашиг сонирхолд учирч болох хор хохирлыг урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийн санаа бодлыг цаг тухайд нь олж илчлэн гэмт хэрэг төгс үйлдэгдэхээс нь өмнө татгалзуулах, урьдчилан сэргийлж, таслан зогсоох, нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг бүрэн шуурхай илрүүлэх, түүнчлэн гэмт хэргийн байдал, эд мөрийн болон бусад нотлох баримт, гэмт этгээдийн нуугдаж орогнож байгаа газрыг тогтооход голлон үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын хүрээ хязгаар эрх зүйн зохицуулалтын хувьд доорх байдлаар тогтоогдож байна.

Үүнд: Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн төрлүүдээс гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах, хуулиар харьяалуулсан гэм хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, шаардлагатай тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, тусгай техник, арга хэрэгсэл ашиглах, халхавчийн байгууллага, нууц гүйцэтгэх болон туслагч, туслах ажилтныг ажиллуулахаар гүйцэтгэх ажлын тухай хуулиар хуульчилсан байдаг.

Цагдаагийн байгууллагын Гүйцэтгэх ажил эрхлэх эрх зүйн зохицуулалтын гол эх сурвалж нь Гүйцэтгэх ажлын тухай хууль юм. Энэ хуулиар гүйцэтгэх ажил явуулах ерөнхий нөхцөл, үндэслэл, хүрээ, түүнийг эрхлэх төрийн байгууллага, ажилтны үйл ажиллагааны зарчим, эрх үүргийг тодорхойлж, тэдгээрт тавих хяналттай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан буюу гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд “Гүйцэтгэх ажлын тухай хууль”-д заасан гүйцэтгэх ажлын арга хэмжээ явуулах; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “Мөрдөн шалгах нууц ажиллагаа” явуулах эрхтэй байдаг.

Үүнээс үзэхэд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, нотлох үйл ажиллагаанд шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийг сүлжээ, дүн шинжилгээний ердийн болон тусгай арга, аргачлалыг цаг алдалгүй хурдан шуурхай тасралтгүй нэвтрүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Цагдаагийн байгууллага нь гэмт хэргийг илрүүлэх, нотлох үйл ажиллагаанд шинжлэх ухааны үндэслэлтэй арга тактик, техник хэрэгслийг ашиглахдаа дараах зарчмыг удирдлага болгох ёстой байдаг. Үүнд:

А. Хуульд нийцсэн байх;

Б. Хувь хүн, нийгэм, төрийн эрх хэмжээ, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн байх;

В. Шинжлэх ухааны үндэслэлтэй байх;

Г. Үр ашигтай байх гэсэн зарчмыг баримтална. Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад гүйцэтгэх ажлын процесс ойлголт чухал ач холбогдолтой байна.

Дүгнэлт. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалт, үндсэн шинжээрээ өөр хоорондоо ялгагдах олон төрөлтэй бөгөөд цагдаагийн байгууллагын өмнө тавигдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын арга, хэлбэрийн өвөрмөц онцлогтойгоо нөхцөлдсөн нягт холбоотой, харилцан уялдаатай хийгддэг цогц ажиллагаа.

⁴³ Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл. 2020. №9.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны олон төрөлт байдлаас хамааран алба хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах эрх зүйн орчин хийгээд удирдлага зохион байгуулалтын өөрчлөлт хийх цаг нэгэнт бий болжээ.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, сургах, чадавхжуулах бодлогыг урт хугацаагаар төлөвлөн хэрэгжүүлэх нь чухал асуудал бөгөөд цагдаагийн алба хаагчдыг давтан сургах, мэргэшүүлэх, олон улсын байгууллагад сургах, бусад орны туршлагыг судлах, чадавхжуулах чиглэлийн үйл ажиллагааг тогтмол шат дараатай хийх шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль// Төрийн мэдээлэл. Уб., 1992. №2
2. Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал. // Төрийн мэдээлэл. Уб., 2010.
3. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. Уб., 2004. №75.
4. Цагдаагийн албаны тухай хууль. // Төрийн мэдээлэл. 2020. №9.
5. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. Уб., 2022.
6. Цогтоо. Ш, Захиргааны эрх зүй. Тусгай анги. Уб., МУИС. 2015.
7. Баянмөнх. Б, Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. Уб., 2018.
8. Ахмедов А.Г. Оперативно-розыскное обеспечение раскрытия убийств по найму. СПб. 2001.
9. Мягмарцэрэн. Д, Оперативно-розыскная профилактика преступлений подразделениями криминальной полиции Монголии. СПб. 2006.
10. Баатархүү. И, Мөрдөн шалгах ажилагааг гүйцэтгэх ажлын мэдээллээр хангах арга зүй. Уб., 2024.
11. Nicolas Delamare. Traité de la Police (Treatise on the Police), 1705.

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АРГА БАРИЛ БА АЛБА ХААГЧИЙН
АЖЛЫН БҮТЭЭМЖИД НӨЛӨӨЛӨХ НЬ**
THE INFLUENCE OF POLICE MANAGEMENT METHODS AND OFFICER PRODUCTIVITY

Г.Уранбат

ДХИС-ын Цагдаагийн сургуулийн

Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,

цагдаагийн дэд хурандаа

G. Uranbat

Police School of the University of Internal Affairs

Senior lecturer of the Department of Police Law,

police lieutenant colonel

Хураангуй: Удирдлагын арга барил нь байгууллагын зорилгод хүрэхэд чиглэсэн удирдагчийн хандлага, стратеги, шийдвэр гаргах, ажлын урсгалыг удирдах аргачлал юм.⁴⁴ Энэ нь байгууллагын үр ашигтай ажиллагааг хангах, ажилтнуудын үр бүтээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёл, ахиц дэвшлийг хангахад чиглэгдэнэ.

Энэхүү илтгэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын ажилтан, алба хаагчийн ажлын байрандаа сэтгэл ханамжтай үүрэг гүйцэтгэх, ажлын бүтээмж гаргахад нэгжийн дарга, удирдлагын эерэг арга барил хэрхэн нөлөөлж буйг гаргаж ирэхийг зорьлоо.

Abstract: A management style is a leader's approach, strategy, decision-making, and work flow management to achieve organizational goals. It is aimed at ensuring the efficient operation of the organization, increasing the productivity of employees, and ensuring the culture and progress of the organization.

This report aims to bring out how the positive approach of the head of the unit and management affects the satisfaction of the employees and officers of the police organization in charge of the territory and the productivity of their work.

Түлхүүр үг: Удирдлага, нэгжийн дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, удирдах арга барил, ажлын бүтээмж

Keywords: Management, unit chiefs, regional police organizations, methods, work productivity

Үндсэн хэсэг Орчин цагийн цагдаагийн байгууллага үүсч хөгжөөд даруй 102 жилийг ардаа үдсэн, буурал түүхтэй байгууллагынхаа ирээдүйн хөгжилд дэм болох, алба хаагч, ажилтны ажилдаа хандах хандлага зөв төлөвших, эерэг уур амьсгал дунд, ажлын өндөр бүтээмж гаргаж ажиллах зэрэгт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн дарга нарын үүрэг чухал юм гэдгийг энэхүү илтгэлээрээ гаргаж ирэхийг зорьсон.

Дэлхий нийтэд удирдлага гэдэг нь байгууллагын зорилго, үүрэг, үйл ажиллагаа зэргийг төлөвлөх, зохион байгуулах, удирдах, хянах, болон гүйцэтгэх процессуудыг хэрэгжүүлэгч үйл явц гэж тодорхойлогддог.⁴⁵ Удирдлагын тухай эрдэмтдийн үзэл баримтлал янз бүрийн чиглэл, онолын хүрээнд өргөн хүрээтэй судлагдсан байдаг ба тэдний үзэл баримтлал нь удирдлагын үүрэг, үүсэл, чиг хандлага, загваруудыг агуулдаг бөгөөд дараах онолуудыг чухал гэж үзэж байна. Үүнд:

1. Классик удирдлагын онол: Классик удирдлагын онол нь 19-р зууны эцсээр гарч ирсэн бөгөөд удирдлагыг зохион байгуулах, төлөвлөх, удирдах болон хянах гэсэн үндсэн үүргүүдийг тодорхойлдог. Анхны эрдэмтдийн нэг нь Фредерик Тейлор байсан бөгөөд тэрээр "Шилдэг практик" буюу хамгийн үр дүнтэй арга техникийг тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааг илүү үр ашигтай болгож болно гэж үзжээ. Тейлорын хувьд удирдлага нь зөвхөн ажлын процессыг хянах, зохицуулах явдал байсан гэж үздэг.⁴⁶

⁴⁴ Доржжав,Д Сонгодог жишээн дээр удирдахууд суралцах нь-УБ.,2022.41 дэх тал

⁴⁵ mmarket.mn//Татаж үзсэн: 19.11.2024

⁴⁶ www.slideshare.net// Татаж үзсэн: 19.11.2024

2. Хүний нөөцийн удирдлага: (Human Relations Theory) энэ онол нь Мэри Паркер Фоллетт болон Элтон Мэйо нарын судалгаагаар хөгжиж, байгууллагын удирдлагад хүний нөөц, ажилчдын сэтгэл ханамж, соёл, харилцааны чухал үүрэгтэй гэдгийг онцолжээ. Тэдний үзэж буйгаар, удирдлага нь зөвхөн үүрэг даалгавар өгөх төдий биш, харин хамтын ажиллагаа, сэтгэл зүй, мэдрэмжийг урамшуулж, хүндэтгэлтэй харилцаж, ажилчдыг хөгжүүлэхтэй холбоотой онол юм.

3. Байгууллагын зан төлөвийн онолын үндэслэгч нь Ester Barnard зэрэг эрдэмтэд байгууллагын доторх зан төлөвийн хэвшлийг судалж, удирдлага нь байгууллагын зорилгод нийцсэн шийдвэр гаргахдаа ажилтнуудын зан төлөвийг анхаарах хэрэгтэй гэж үзсэн. Түүний үзэл баримтлал нь удирдлагын үйл ажиллагаанд "коммуникаци" болон "урам зориг" гэх хоёр гол ойлголтыг нэмсэн юм.

4. Менежментийн онолын үндэслэгч нь Хенри Файоль болон Макс Вебер нар билээ. Тэд менежментийн онолын анхдагчид бөгөөд удирдлагын үндсэн 5 үүргийг төлөвлөлт, зохион байгуулалт, удирдлага, зохицуулалт, хяналт гэж тодорхойлж, Файоль мөн удирдлагын 14 зарчим буюу удирдлагын зөвлөмжийг гаргаж, хамгийн чухал нь "нэгдмэл удирдлага", "ажлын хуваарилалт"-ын зарчим юм гэж тодорхойлсон байдаг.

5. Системийн онолын үндэслэгч нь эрдэмтэн Лудвиг фон Берталанфи юм. Тэрээр удирдлагыг бүтцийн олон хүчин зүйлсийн хоорондох харилцан үйлчлэл гэж үзэж, байгууллагыг нэгтгэсэн систем болгон авч үздэг. Системийн онол нь байгууллагын бүх хэсгүүдийг уялдуулан удирдах шаардлагатай байдлыг харуулдаг.

6. Загварчлалын болон стратегийн удирдлагын онолыг үндэслэгчид нь Майкл Портер болон Хенри Минцберг нар юм. Тэд стратегийн удирдлагын талаар судалж, удирдлагын тодорхой үүрэг нь байгууллагын гадаад болон дотоод орчинд нийцсэн урт хугацааны стратеги боловсруулах явдал юм гэж үздэг. Минцбергийн "стратеги нь тухайн үеийн нөхцөл байдалд таарсан байж, улам бүр хөгжих ёстой" гэсэн үзэл нь удирдлагын амжилтын үндэс болдог.

7. Орчин үеийн удирдлагын онол нь мэдээллийн технологи, инноваци, байгууллагын уян хатан байдал, багаар ажиллах чадвар зэргийг чухалчилдаг. Мөн удирдлага нь зөвхөн эсрэг талын гүйцэтгэгч биш, харин өөрчлөлт, хөгжлийг удирдах ур чадвар шаарддаг.

Эдгээр онолуудад тулгуурлан удирдлага гэдэг ойлголтыг томъёолвол: удирдлага гэдэг нь зөвхөн шийдвэр гаргах процесс биш, харин хүмүүсийг нэгтгэн удирдах, зорилгоо биелүүлэхэд тэднийг хөдөлгөх, урамшуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.⁴⁷ Эрдэмтдийн үзэл баримтлал нь энэ үүрэг, үйл явцыг янз бүрийн өнцгөөс харж, удирдлагын ажлыг үр ашигтай, хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой гэдгийг баталж байна.

Удирдлагын арга барил нь нэгж дээр үүрэг гүйцэтгэж буй алба хаагчийн ажлын бүтээмжид эерэг болон сөрөг байдлаар нөлөөлж байдаг. Удирдлагын арга барилыг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Захиргааны арга барил (Autocratic Leadership): Удирдагч нь бүх шийдвэрийг ганцаараа гаргана. Ажилчдыг зөвхөн зааварчилгаа даган ажиллахыг шаардана. Энэ арга барил нь хурдан шийдвэр гаргах болон онцгой нөхцөлд ашигтай байдаг ч ажилчдын санаачилга, бүтээлч сэтгэлгээг хязгаарлах магадлалтай.

Арга барилын соёлд суурилсан удирдлага (Democratic/Participative Leadership): Удирдагч шийдвэр гаргахдаа багийн гишүүдийн санал бодлыг сонсож, тэдний оролцоог хүлээн авдаг. Ажилчдын санаачилга, бие даасан байдал, багийн харилцаа илүү чухалд тооцогддог. Энэ нь бүтээмжийг нэмэгдүүлж, ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлдэг ч заримдаа шийдвэр гаргах процесс удааширч болзошгүй.

Гаргалгаа шийдвэрлэх арга барил (Laissez-Faire Leadership): Удирдагч бага оролцоотой, ажилчдад өндөр түвшний эрх чөлөө олгох арга барил. Ажилчид өөрсдийнхөө хэмнэлээр ажиллах боломжтой. Энэ арга барил нь өндөр боловсролтой, өөрийнхөө ажилд итгэлтэй багийн гишүүдтэй

⁴⁷ Цолмон Ц. Удирдахуйн үндэс ба даргын ажил-УБ., 1996.24 дэх тал

хамтран ажиллахад үр дүнтэй байх боловч заримдаа зохион байгуулалтын дутагдал, чиглэлгүй байдал үүсэж болзошгүйг анхаарах шаардлагатай болдог.

Хамтын ажиллагааны арга барил (Transformational Leadership): Удирдагч нь өөрчлөлт хийх, шинэ санаа оруулахад чиглэгдсэн хүчтэй удирдлага юм. Тэрбээр өөрийн ажилчдыг урамшуулах, илүү өндөр зорилготой байх, өөрчлөлтөд нийцсэн сэтгэлгээ болон хандлагыг бий болгоход анхаардаг. Энэ нь багийн гишүүдийг урамшуулах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилготой боловч заримдаа бүтэц, стратегийн талаар мэдлэггүй байдлын улмаас саад болж болно.

Менежментийн арга барил (Transactional Leadership): Удирдагч нь хүлээгдэж буй гүйцэтгэлийн үр дүнд шагнал, торгууль өгөх замаар ажилчдыг удирддаг. Энэ арга барил нь тодорхой зорилтууд болон үр дүнд суурилсан ажлын орчинд үр дүнтэй байдаг, гэхдээ бүтээлч байдал болон урт хугацааны хөгжлийг хангахад хязгаарлалттай байдаг.⁴⁸

Эдгээр арга барил нь тус бүрийн давуу болон сул талуудтай бөгөөд удирдагчид байгууллагын нөхцөл, ажилчдын зан чанар, бизнесийн шаардлагад үндэслэн хамгийн тохиромжтой хандлагаа сонгодог. Удирдлагын арга барил нь тогтмол шинэчлэгдэж байдаг тул удирдагчид өөрийн арга барилаа сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх хэрэгтэй юм.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн даргын удирдлагын арга барил нь алба хаагчдын ажлын бүтээмжид чухал нөлөө үзүүлдэг.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн дарга нь алба хаагчдын ажлын үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд удирдлагын арга барилаа сайн төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Хэрвээ нэгжийн дарга тогтвортой, шударга, нээлттэй, бүх талын асуудалд үнэн зөв ханддаг бол алба хаагчид өөрсдийн үүрэг хариуцлагыг өндөр түвшинд биелүүлж, үр дүнтэй ажиллах нь улам бүр нэмэгдэнэ. Алба хаагчид хариуцлага, шударга байдлыг мэдэрч, өөрсдийн үйл ажиллагаандаа сэтгэлтэй хандах, алба хаагчидтайгаа санал солилцох, зөвлөгөө өгөх зэрэг нь ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.

Мөн нэгжийн дарга алба хаагчидтай үр дүнтэй харилцаа холбоо тогтоох хэрэгтэй. Хэрвээ харилцаа холбоо сайн байвал цагдаагийн алба хаагчдын мэдлэг, чадвар, туршлага сайжирч, хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа илүү үр бүтээмжтэй болдог.

Нутаг дэвсгэрт ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд дарга нь цаг алдалгүй шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх чадвартай байх шаардлагатай. Хэрвээ дарга шийдэмгий, хурдан хугацаанд асуудлыг шийддэг бол энэ нь алба хаагчдын ажлын ачааллыг хөнгөвчлөөд зогсохгүй, бүхэл бүтэн байгууллагын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг.

Цагдаагийн байгууллага нь бүлгийн ажиллагаа шаарддаг салбар тул дарга нь багийг удирдах, эв нэгдэлтэй, хамтран ажиллах уур амьсгалыг бүрдүүлэх хэрэгтэй. Хамтдаа нэгэн зорилго руу чиглэсэн үйл ажиллагааг удирдах нь алба хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй байдаг.

Цагдаагийн байгууллагын удирдлага нь алба хаагчдын мэдлэг, ур чадварыг байнга хөгжүүлэхэд анхаарах ёстой. Сургалт, олон нийтийн сэтгэл зүй, хууль эрх зүй зэрэг чиглэлээр алба хаагчдыг тасралтгүй хөгжүүлснээр тэдний бүтээмж өсдөг.

Мөн дээр удирдлагын арга барилаас гадна нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн дарга ажилдаа ирээд алба хаагчидтайгаа эелдэг сайхан мэндчилэхээс тухайн алба хаагчийн ажлын бүтээмж, сэтгэл санаа гээд олон зүйл шалтгаалдаг гэж би боддог. Нэгжийн даргатайгаа таарсан даруйдаа амар мэндээ мэдэлцэж, тухайн өдрийн ажилд нь амжилт хүсэх нь ямар ч хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардахгүй атлаа тухайн ажилтанд сэтгэл зүйн хувьд таатай мэдрэмж төрүүлэхээс гадна ажилдаа хандах хандлага, ажлын үр бүтээмжид эерэгээр нөлөөлдөг гэдгийг судалгаагаар гаргаж ирэхийг зорьсон.

Нэгжийн дарга нь байгууллагын гишүүдийн ажиллах орчин, сэтгэл санаа, бүтээмжид шууд нөлөө үзүүлдэг чухал үүрэгтэй хүн гэдэгтэй хэн бүхэн санал нийлэх байх. Тиймээс нэгжийн дарга удирдлагадаа буруу арга барил ашиглавал, энэ нь багийн гишүүдийн ажил, бүтээмж, харилцаа,

⁴⁸ Эрдэнэчулуун Д. Удирдахуйн сэтгэл судлал-Уб.,2013.18 дахь тал

байгууллагын үр дүнд сөргөөр нөлөөлж болно. Нэгжийн даргын удирдлагын буруу арга барилыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1.Нэгжийн дарга бүх зүйлд хэт их анхаарал хандуулж, багийн гишүүдэд өөрийн санаа, шийдвэрийг хүчээр тулгах буюу хэт хяналт тавих. Энэ нь ажилчдын бие даасан байдал, санаачлагыг боогдуулж, үр дүнтэй ажиллах боломжийг хязгаарладаг.

2.Мэдээлэл хуваалцах чадвар сул байх буюу Коммуникацийн дутагдал. дарга мэдээллээ цаг тухайд нь хуваалцаж, нээлттэй харилцаж чаддаггүй бол, ажилчид алдаатай шийдвэр гаргах, зөрчилдөөн үүсгэх магадлалтай. Үр дүнтэй харилцан ойлголцол, мэдээлэл солилцоо нь удирдлагын чухал хэсэг юм.

3.Хувь хүний харилцаанд хэт анхаарах буюу удирдлагандаа ажиллаж буй алба хаагчдын хувийн асуудалд хэт оролцох, эсвэл хувийн сонирхолтойгоо холбоотой шийдвэр гаргах нь ажилчдын хүндлэл, итгэл үнэмшлийг алдагдуулдаг.⁴⁹

4.Өрсөлдөөнөөс илүү хамтын ажиллагааг дэмжихгүй байх нь хамт олны илтгэл, үнэмшлийг сулруулж, хамтран ажиллах чадварыг бууруулдаг.

Шийдвэр гаргалт хийхдээ хэт эрх мэдэлтэй байх, түргэн, бодлогогүй хандах, Бусдыг буруутгах, хариуцлага хүлээлгэхгүй байх зэрэг нь удирдлагын буруу арга барилыг илэрхийлдэг бол хамгийн чухал зүйл бол алба хаагчидтайгаа мэндлэхгүй байх нь хамгийн бүдүүлэг, удирдлагын хамгийн буруу хандлага төдийгүй алба хаагчдын ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлж, цаашлаад байгууллагын зорилгод хүрэх боломж багасдаг хүчин зүйл юм. Нутан дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн дарга нарын харилцаа, хандлагад үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлагын дээрх буруу арга барил түүн дотроо алба хаагчидтайгаа мэндчилэн харилцааны эерэн уур амьсгалыг хэрхэн бүрдүүлж байгаад дүн шинжилгээ хийх зорилгоор 156 цагдаагийн алба хаагчдаас судалгаа авлаа.

График №1 Насны байдал



График №2 Алба хаагчдын хүйс



Энэ удаагийн судалгаанд хамрагдсан алба хаагчдыг насны хувьд авч үзвэл: 36 буюу 23 хувь нь 22-28 насны, 48 буюу 30.7 хувь нь 29-35 насны, 29 буюу 18.5 хувь нь 36-40 насны, 23 буюу 14.7 хувь нь 41-50 насны, 20 буюу 12.8 хувь нь 51-ээс дээш насны, 6 буюу 2 хувь нь 45-49 насны алба хаагчид хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 124 буюу 79.4 хувь нь эрэгтэй, 32 буюу 20.5 хувь нь эмэгтэй алба хаагч байсан байна.

График №03 Алба хаагчдын боловсрол



График №04 Алба хаагчдын ажил эрхлэлтийн байдал



⁴⁹ Ундармаа Н. Олон улсын харилцааны соёл, ёс зүй-УБ.,2008.59 дахь тал

Судалгаанд хамрагдсан алба хаагчдыг боловсролын хувьд авч үзвэл: 1 буюу 0,6 хувь нь бүрэн дунд 16 буюу 10.2 хувь нь тусгай дунд, 139 буюу 89.1 хувь нь дээд боловсролтой алба хаагчид байна.


Харин ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл: Нийт алба хаагчдын 72 буюу 46.1 хувь нь Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасаг, 8 буюу 5.1 хувь нь Эрүүгийн цагдаагийн тасаг, 9 буюу 5.7 хувь нь Мөрдөн байцаах тасаг, 12 буюу 7.6 хувь нь Захиргааны удирдлагын тасаг, 23 буюу 14.7 хувь нь Шуурхай удирдлагын тасаг, 21 буюу 13.4 хувь нь Замын цагдаагийн тасаг, 11 буюу 7 хувь нь бусад албан тушаалын алба хаагчид хамрагджээ.

Таны ажиллаж буй байгууллагын нэгжийн дарга өглөө бүр тантай мэндчилдэг үү? гэсэн асуултанд 83 буюу 53.2 хувь нь мэндэлдэг, 62 буюу 39.7 хувь нь дуугардаггүй, 11 буюу 7 хувь нь заримдаа дуугардаг гэж хариулжээ.

График №5 Мэндчилгээ



График №6 Мэндчилгээний ач холбогдол



Дээрх графикаас үзвэл нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн дарга буюу тасгийн дарга нарын 46.8 хувь нь ажлын шинэ өглөөг эхлүүлэхдээ өөрийн удирдлагад ажиллаж буй алба хаагчидтай мэндчилдэггүй гэсэн дүгнэлт гарч байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн дарга ба алба хаагчдын мэндчилгээний ач холбогдолыг та юу гэж дүгнэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчдын 65 буюу 41.6 хувь нь тухайн өдөр ажиллах эрч хүчтэй болдог, 51 буюу 32,6 хувь нь удирдагчийнхаа өгсөн үүрэг, даалгаврыг давуулан биелүүлэх эрч хүч авдаг, 22 буюу 14,1 хувь нь хамт олонтой хүн шүү гэсэн эерэг мэдрэмж авдаг, 18 буюу 11,5 хувь нь мэндэлсэн ч, эс мэндэлсэн ч миний сэтгэл зүйд огт нөлөөлдөггүй гэж хариулсан байна.

Дээрх графикаас дүгнэхэд нэгжийн дарга, алба хаагчдын мэндчилгээ нь алба хаагчийн ажлын бүтээмжид эерэгээр нөлөөлдөг байж болзошгүй юм.

Дүгнэлт: Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн даргын удирдлагын арга барил нь алба хаагчдын ажлын бүтээмжид шууд нөлөөлдөг. Бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд удирдагч нь сайн харилцаа холбоо, шударга байдал, шийдэмгий байдал, багийн ажиллагааг дэмжих хэрэгтэй. Үүний зэрэгцээ, алба хаагчдыг хөгжүүлж, сургалт өгч, тэдэнд мотиваци өгөх нь чухал.

Цагдаагийн алба хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нэгжийн дарга алба хаагчдаа зөв чиглүүлж, хамтран ажиллах орчныг бий болгож, тэдний хүсэл зориг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхээс гадна ил тод, нээлттэй харилцаа, өдөр тутам бие биетэйгээ мэндчилэх, тухайн өдрийн ажилд нь амжилт хүсэх хүндлэл бүхий орчныг бий болгосноор алба хаагчийн ажлын бүтээжүүд эерэгээр нөлөөлж, ажиллах урам зориг, бахдал төрөх, байгууллагын үйл ажиллагааны эцсийн зорилгод эерэг нөлөө үзүүлж чадна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдаас авсан судалгаанаас дүгнэхэд удирдлагын арга барилд хамгийн түрүүнд зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай энгийн бөгөөд ямар нэгэн хөрөнгө мөнгө шаардлахгүй зүйл бол “Мэндчилгээ” гэж дүгнэж байна.

Мэндчилэх нь хүний сэтгэл зүйд ойр дотно мэдрэмж төрүүлэхээс гадна тухайн байгууллагын соёлыг илтгэж, байгууллагын зорилго, зорилт хэрэгжих хамгийн анхны үндэс гэж ойлгож болно.

Санал: Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын ажилтан, алба хаагчдыг иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай харилцах үйлдэл бүрийг хуульчилж, журамласан байдаг. Үүний нэгэн адил алба хаагчид хоорондоо эвсэг, найрсаг мэндчилэх агуулгыг журмаар зохицуулах.
2. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага жил бүр шилдэг алба хаагчийг тодруулахдаа өөрийн соёлыг бүрдүүлэх, хамт олны эерэг, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлыг харгалзах үзүүлэлтэд тусгах зэрэг болно.

Ашигласан материал

1. Доржжав.Д Сонгодог жишээн дээр удирдахуйд суралцах нь-Уб.,2022
2. Цолмон Ц. Удирдахуйн үндэс ба даргын ажил-Уб.,1996
3. Эрдэнэчулуун Д. Удирдахуйн сэтгэл судлал-Уб.,2013
4. Ундармаа Н. Олон улсын харилцааны соёл, ёс зүй-Уб.,2008
5. www.market.mn .
6. www.slideshare.net

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ БОЛОН
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ
EXECUTION OF ADMINISTRATIVE COURT DECISIONS
AND ROLE OF THE POLICE

Д.Энх-Амар

Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн ахмад

Enkh-Amar.D

University of Internal Affairs of Mongolia,
Law and Social Science
school, Public Law Department,
Lecturer police captain

Хураангуй: Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагдаад 20 жилийн хугацаа өнгөрчээ. Уг шүүх байгуулагдсаны ач холбогдол, үр нөлөөг нийгэмд харуулах гол үзүүлэлтийн нэг бол шүүхийн шийдвэр биелэгдэж, захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхол хамгаалагдаж, бодитоор сэргээгдэх явдал юм. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд уг шаардлагыг хангахтай холбоотой харилцааг зохицуулсан хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар хэд хэдэн удаа хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орж байсан боловч өнөөдрийн байдлаар тодорхой зохицуулагдаж, шүүхийн шийдвэрээр хамгаалагдсан хүн, хуулийн этгээдийн эрх бүрэн сэргэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Мөн захиргааны эрх зүйн онолд, аливаа захиргааны байгууллагын чиг үүрэг, түүний хуваарилалтын асуудал суурь шинжтэй асуудал байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй захиргааны байгууллагуудын чиг үүргийн хуваарилалтыг холбогдох хуулиудад хийхдээ системчлэлийг ихээхэн алдагдуулах, судалгаа шинжилгээгүйгээр дур мэдэн хийх, өөрчлөх зэрэг сөрөг хандлагууд ажиглагдах боллоо. Өөрөөр хэлбэл, тухайн захиргааны байгууллага ямар асуудлыг шийдвэрлэх, ямар асуудалд оролцох эсэх асуудлыг тогтоохдоо түүнд хамааралгүй чиг үүргийг оногдуулах, эсхүл зайлшгүй хамааруулах ёстой чиг үүргийг орхигдуулах, өөр захиргааны байгууллагад өгөх зэрэг алдаа, дутагдал гарч байна. Иймд хууль тогтоомжийн зохицуулалт, энэ талаарх бусад орны жишгийг харьцуулан судалж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замын талаар судлаачийн хувьд санал дэвшүүлэхээр энэхүү илтгэлийг бэлтгэлээ.

Abstract: 20 years have passed since the establishment of the Administrative Court in Mongolia. One of the main indicators of the importance and effectiveness of the establishment of the court is that the court's decision is fulfilled, and the rights and interests of people and legal entities violated due to illegal administrative activities are protected and actually restored. In the past 20 years, there have been several amendments to the laws and regulations regarding the improvement of the laws and regulations regulating the relationship related to the fulfillment of the requirements in the execution of administrative court decisions, but as of today, the rights of persons and legal entities protected by court decisions are clearly regulated natural environment is not formed.

Also, in the theory of administrative law, the function of any administrative organization and its distribution is a fundamental problem, and in recent years, in the distribution of functions of administrative organizations operating in Mongolia in the relevant laws, there have been negative trends such as significant loss of systematization, arbitrarily making and changing without research can be observed. In other words, there are errors and shortcomings, such as assigning functions that do not belong to the administrative organization, or omitting the functions that must be assigned to it, or assigning them to

another administrative organization when determining which problems to solve and which problems to participate in. Therefore, as a researcher, I have prepared this report in order to compare the laws and regulations and the standards of other countries in this regard, identify the problems, and propose solutions as a researcher.

Түлхүүр үг: Шийдвэр гүйцэтгэл, чиг үүрэг, хуваарилалт, зохицуулалт

Keywords: Decision making, functions, distribution and coordination

Үндсэн хэсэг. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд (шинэчилсэн найруулга) шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн 137 дугаар зүйлийн 137.2-т шүүхийн шийдвэрийг биелүүлэлгүй хоёр, түүнээс дээш удаа торгох шийтгэл авагдсан хариуцагчид шүүгч Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хуульд заасан сахилгын шийтгэлийг оногдуулах мэдэгдлээ хүргүүлж, эрх бүхий этгээд сахилгын шийтгэл оногдуулж, энэ тухай шүүхэд мэдээлэхээр⁵⁰, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуульд “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн талаарх шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа” гэх бүлэг нэмж, тодорхой зарим зохицуулалт орсны дотор 79 дүгээр зүйлд “Албадлагын арга хэмжээ”-ний талаар заалт нэмсэн боловч 2017 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн хуулиар хүчингүй болгож, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөхөөр заажээ.

Харин Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон Зөрчлийн тухай хуульд “захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй”-тэй холбоотой зохицуулалт ороогүй бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахад захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг Арвандөрөвдүгээр бүлэгт зохицуулахдаа шүүхийн шийдвэрийн төрлөөс хамаарч шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг ялгамжтай заасан нь сайн талтай боловч Захиргааны хэргийн шүүхийн зорилго, шийдвэрийн төрөл тус бүрийн онцлог, ижил болон ялгаатай үр дагавар, шийдвэр шууд хэрэгжиж болох, эсхүл шийдвэрийг гүйцэтгэх тодорхой үйл ажиллагаа явуулах шаардлагатай эсэх, нэхэмжлэгч хүн, хуулийн этгээдийн эрхийг хэрхэн сэргээхтэй холбоотой шийдвэр гүйцэтгэх арга, журмыг зохицуулж чадаагүй байна. *Тухайлбал:*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 134 дүгээр зүйлээр “Захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хүчингүй болгох тухай, тэдгээрийг илт хууль бус болохыг тогтоосон шийдвэрийг биелүүлэх” гэж гарчиглан,

- “... шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноор захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хүчингүйд тооцох бөгөөд тэдгээрийг дахин хэрэглэхгүй”,

- “... хүчингүйд тооцогдсоноор бусад этгээдийн эрх ашиг, сонирхолд нөлөөлөх бол тухайн захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээг хуульд нийцүүлэн энэ хуулийн 127.2-т заасан хугацааны дотор дахин гаргах, байгуулах үүрэгтэй”,

- “... шийдвэрийн талаар эрх ашиг, сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тэдгээр нь тодорхойгүй тохиолдолд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, улсын нэгдсэн бүртгэлд зохих өөрчлөлтийг оруулна ...”⁵¹ гэх зэргээр зохицуулжээ.

Уг зүйл, заалтуудаар зохицуулсан захиргааны актыг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох, хэм хэмжээ тогтоосон актыг хүчингүй болгох, илт хүчин төгөлдөр бус болохыг тогтоох зэрэг шийдвэрүүдийн үр дагавар хоорондоо ялгаатай, зарим шүүхийн шийдвэр шууд хэрэгждэг, хариуцагч тодорхой үйлдэл хийх шаардлагагүй, заримыг нь Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хуулиар зохицуулсантай давхцах, зөрчилдөхөөс гадна шүүхийн шийдвэр биелүүлэх журам /процесс/-тай холбоогүй, шүүхийн шийдвэрээр заагаагүй, захиргаанд дахин акт гаргах, гэрээ байгуулах, мэдээллийн хэрэгслээр мэдэгдэх зэргийг үүрэг болгосон материаллаг шинжтэй зохицуулалт ч байна.

⁵⁰ Төрийн мэдээлэл. 2016. №9. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

⁵¹ Төрийн мэдээлэл. 2017. №24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны зорилго нь тухайн хэргийн оролцогч талуудад хамааралтай /хэм хэмжээний актаас бусад/ буюу хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэхээр байхад бусад этгээдийн эрх, ашиг сонирхлын талаар, олон нийтэд мэдээлэх талаар заасан нь тухайн хэргийн оролцогчид ямар үр дагавартай болох нь тодорхойгүйгээс шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой хэн, хэзээ, ямар үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх, ямар үр дүнд хүрэх нь тодорхойгүй үлджээ.

Дээрхээс гадна уг хуульд шийдвэрийг биелүүлж, тодорхой үйл ажиллагаа хийхийг даалгасан шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой “Захиргааны акт гаргахыг даалгасан, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоосон шүүхийн шийдвэрийг биелүүлэх” гэсэн 135 дугаар зүйлд:

- ... захиргааны актыг шүүхийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 127.2-т заасан хугацаанд гаргах үүрэгтэй.

- ... шийдвэрт заасан захиргааны актыг гаргаснаар шүүхийн шийдвэрийг биелүүлсэнд тооцно” гэсэн 2 заалт байгаа нь энэ төрлийн шийдвэрийг хариуцагч биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэлийг хэрхэн хангах арга, журам мөн л тодорхойгүй байна. Уг хуулийн бүлэг зохицуулалтыг ямар хэрэгцээ шаардлага, үндэслэлээр хэн, хэрхэн санаачилж ямар зорилгоор ийнхүү зохицуулсныг тухайн хуулийн үзэл баримтлал, танилцуулга⁵²-аас хайхад энэ талаар тусгагдаагүй байна.

Түүнчлэн манай Монгол Улсад Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ хуулиар цагдаагийн байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг
- Нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүрэг
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг
- Захиргааны хяналтын чиг үүрэг

Дээрхээс нэг сонирхол татахуйц чиг үүрэг байгаа нь захиргааны хяналтын чиг үүргийг цагдаагийн байгууллагад оногдуулсан нь Германы цагдаагийн эрх зүйгээс ялгаатай байна.

Өөрөөр хэлбэл, захиргааны хяналтын чиг үүрэг гэх ойлголтын цаана цагдаагийн байгууллагыг нийгмийн харилцаанд тулгарсан бүхий л асуудалд татан оролцуулах нөхцөл байдлыг нээсэн байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийг харвал манай улсын цагдаагийн байгууллагад захиргааны хяналтын чиг үүргийг өргөн хүрээнд оногдуулсан болох нь харагдаж байгаа бөгөөд энэ нь цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг болох “аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах” чиг үүргийг бүдгэрүүлэх, тарамдуулах, цалгардуулах нөхцөл байдал бий болох эхлэл болсон байна.

Үүнийг нарийвчлан харвал:

13.1.Цагдаагийн байгууллага захиргааны хяналтын чиглэлээр дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.хүн ам, экологийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй хордуулах, мансууруулах бодис болон галт зэвсэг, сум хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх, хадгалж хамгаалах, ашиглах талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

13.1.2.иргэн, хуулийн этгээд галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах болон галт зэвсэг, сум хэрэгсэл үйлдвэрлэх, захиалах, худалдах, тээвэрлэх журмын биелэлтэд хяналт тавих;

13.1.3.зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч болон зөрчлийн тоо бүртгэл хөтлөх;

13.1.4.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;

13.1.5.эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах, хэн болох нь тогтоогдоогүй цогцсыг таниулах ажиллагаа явуулах;⁵³

⁵² <https://forum.parliament.mn/projects/119>

⁵³ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

13.1.6.гээгдэл эд хөрөнгө, мөнгийг бүртгэх, шаардлагатай бол хадгалах, хууль ёсны эзэмшигчид нь олгох, хэрэв хууль ёсны эзэмшигч олдохгүй бол төрийн, эсхүл орон нутгийн холбогдох байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

13.1.7.жолоодох эрхийн болон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг олгох, бүртгэх;

13.1.8.хуульд заасан бусад.

13.2.Цагдаагийн байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан захиргааны хяналтын үүрэг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан эрхийг эдэлнэ **гэж заажээ**.

Захиргааны эрх зүйн тусгай ангийн нэгэн чухал хууль болох Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн **8 дугаар зүйлд заасан** зохицуулалтаас харахад ч цагдаагийн байгууллагад захиргааны хяналтын чиг үүргийг өргөн хүрээнд тусгажээ.

Харьцуулалт

ХБНГУ, БНСУ, Япон улсад тусдаа захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг зохицуулсан тусгай хууль байдаггүй, Захиргааны шүүхийн мөнгөн төлбөртэй холбоотой шийдвэрийг Иргэний шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэх */mutatis mutandis зарчмаар/-*ээр зохицуулсан нь нийтлэг байна.

Харин ХБНГУ -ийн хувьд Захиргааны шүүхийн процессын хуулийн⁵⁴ 172 дугаар зүйлд захиргааны байгууллагад тодорхой үйлдэл хийхийг даалгасан шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд албадлагын арга хэмжээг шүүх авахаар тусгайлан тодорхой зохицуулжээ.

Тухайлбал “даалгах буюу тодорхой үүрэг хүлээлгэсэн” шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд анхан шатны шүүх 10,000 еврогоор торгох албадлагын арга хэмжээ авах, шийдвэрийг биелүүлэх хүртэл давтан торгож болохоор тусгаснаас үзвэл хэн, хэзээ, ямар шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд аль шүүх ямар албадлага хэрэгжүүлэх, торгуулийн дүн тодорхой, мөн “шийдвэрийг биелүүлэх хүртэл” давтан торгохоор байгаа нь хариуцагч захиргааны байгууллага, албан тушаалтныг хариуцлагажуулсан, уг албадлагын үр дүн нь шийдвэр заавал биелэгдэх үр дагаварт хүргэхээр байна.

Үүнээс гадна ХБНГУ-ын эрх зүйн тогтолцоонд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг аюулаас урьдчилан сэргийлэх, түүнээс нийгмийг хамгаалах явдал гэж үздэг ба ингэхдээ энэхүү чиг үүргийг 2 түвшинд хуваан ялгаатай байгууллагуудад хуваарилжээ. Тодруулбал:

Аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах байгууллага:

- Хэв журмын байгууллага → анхдагч чиг үүрэгтэй
- Цагдаагийн байгууллага → субсидиар /хоёрдогч байх/ чиг үүрэгтэй /яаралтай, зайлшгүй тохиолдолд/

Дээрхээс үзвэл, ХБНГУ-д аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудалд цагдаагийн байгууллага шууд буюу анхдагч чиг үүргийг хүлээдэггүй. Харин яаралтай, зайлшгүй тохиолдолд тухайн холбогдох захиргааны байгууллагад /хяналт хэрэгжүүлдэг/ туслалцаа үзүүлэх зорилгоор чиг үүргээ хэрэгжүүлдэг байна.

Түүнчлэн, цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийг дараах байдлаар ангилна:

- Гэмт хэрэгтэй тэмцэх → мөрдөх байгууллага /репрессив ү.а/

Репрессив үйл ажиллагаа гэдэг нь мөрдөн шалгах, шийтгэх зорилго бүхий үйл ажиллагаа. Тиймээс энэ нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа биш болно.

- Аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах → захиргааны байгууллага /превентив ү.а/

Превентив үйл ажиллагаа гэдэг нь мөрдөн шалгах, шийтгэх бус, харин тухайн аюулаас урьдчилан сэргийлэх, аюулаас хамгаалах үйл ажиллагаа байна. Ингэснээрээ энэ нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа болно.

Энэ үйл ажиллагааны тухайд 2 ялгаатай зарчим үйлчилдэг байна. Дурдвал:

- Тусгаарлах зарчим /Trennungsprinzip/: Бавари, Берлин, Бранденбург, Хамбург, Хессен, Мекленбург-Форпоммерн, Нийдерзаксен гэх мэт 12 муж улс

⁵⁴ https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html

- Нэгдмэл байх зарчим /Einheitsprinzip/: Баден-Вюрттемберг, Бремен, Заарланд, Заксен 4 муж улс

Тусгаарлах зарчим: Аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах байгууллагын чиг үүргийг 2 байгууллага хувааж хэрэгжүүлдэг зарчим.

- Хэв журмын байгууллага /Аюулгүй байдлын байгууллага/ Энэ нь анхдагч харьяаллыг хэрэгжүүлнэ
- Цагдаагийн байгууллага /Хууль сахиулах цагдаа Vollzugspolizei/ Энэ нь яаралтай тохиолдолд ажиллана, туслалцаа үзүүлнэ

Нэгдмэл байх зарчим: Аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах байгууллагын чиг үүргийг 1 байгууллага хэрэгжүүлнэ. Аюулгүй байдлын байгууллага болон хууль сахиулах цагдаа нь 1 дороо гэсэн үг юм.

Дээрхээс үзвэл, ХБНГУ-д тусгаарлах зарчмыг баримталдаг байх бөгөөд өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага нь хоёрдогч түвшинд урьдчилан сэргийлэх, хамгаалах чиг үүргийг гүйцэтгэнэ гэж үздэг болно.

Чиг үүргийн хуваарилалт

Харин чиг үүргийн хуваарилалтыг нарийвчилсан агуулгаар авч үзэхэд захиргааны эрх зүйн онцлог буюу захиргааны эрх зүйн тусгай ангийн салбаруудад ялгамжтай зохицуулалтаар хэрэгжинэ.

- Цагдаа, хэв журмын байгууллага. Аюулаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг нийтлэг байдлаар харьяалсан.
- Тусгай хэв журмын байгууллага. Аюулаас урьдчилан сэргийлэх чиг үүргийг хязгаартайгаар харьяалсан. Жишээ нь:
 - Замын хөдөлгөөний асуудал хариуцсан байгууллага
 - Барилгын асуудал хариуцсан байгууллага ...

Захиргааны эрх зүйн тусгай ангийн дараах салбаруудад цагдаагийн байгууллагын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чиг үүрэг өөрийн гэсэн онцлог байдалтайгаар, ялгаатай зохицуулагдана.

Тусгай салбарууд

- Гадаадын иргэдийн эрх зүй,
- Барилгын эрх зүй,
- Газар хамгаалал,
- Аж ахуйн үйл ажиллагааны эрх зүй,
- Эрүүл мэнд хамгаалал,
- Гентехникийн эрх зүй,
- Гар үйлдвэрлэл,
- Байгаль орчны хамгаалал,
- Хүнсний бүтээгдэхүүний эрх зүй,
- Бооцоот тоглоом,
- Банкны эрх зүй,
- Замын хөдөлгөөний эрх зүй,
- Жагсаал цуглааны эрх зүй,
- Зэвсэг, аюултай бодис.

Дүгнэлт. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх ойлголт захиргааны байгууллагад байх боломжгүй. Учир нь Захиргааны байгууллага, албан тушаалтан нь хуулийг хэрэгжүүлж, тодорхой үйл ажиллагаа /акт, гэрээ, хэм хэмжээний акт болон бусад/-г явуулахдаа хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргахдаа Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох “хууль дээдлэх” зарчим болон Захиргааны ерөнхий хууль болон бусад хуульд заасан тусгай зарчмыг баримталж ажиллах үүрэгтэй.

Энэ үүргийн нэг нь Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагын алдаа буюу хуульд нийцээгүй үйл ажиллагааг тогтоож, түүний улмаас хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг хамгаалсан шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх үүрэг хамаарна.

Өөрөөр хэлбэл төрийн албан хаагч эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэж байхдаа өөрийн буруутай үйл ажиллагааны үр дагаврыг арилгах нь төрийн албаны хариуцлага бөгөөд энэ нь тухайн буруутай үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах зэрэг үйл ажиллагаагаар илэрнэ.

Цагдаагийн байгууллагын чиг үүргийн тухайд чиг үүргийн хуваарилалтын онолын судалгааны хөгжил тааруу **бөгөөд чиг үүргийн хуваарилалтыг** хуульд хэт ерөнхий байдлаар хийдэг, эсхүл хийхгүй орхигдуулдаг, эсхүл давхардуулдаг. Тиймээс цагдаагийн байгууллага бүхий л асуудалд оролцох, хутгалдах ёстой мэт хандлага амь бөхтэй болсон. **Түүнчлэн** зарим талаараа төрийн бусад байгууллага, албан тушаалтан цагдаагийн байгууллагын чиг үүрэг рүү халдаж, өмнөөс нь ажлыг нь хийх гэж оролддог.

Санал. Дээрх санал дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. үүнд:

- Биелэгдэх шаардлагатай шүүхийн шийдвэрийн төрлийг тодорхой болгох
- Захиргааны байгууллагаас төлбөр, хохирол гаргуулах зэрэг нэхэмжлэлийг хангасан тохиолдолд Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмыг хэрэглэх */mutatis mutandis/*
- Шийдвэрийн биелэлтэд анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүх нь хяналт тавих, албадлага хэрэглэх журмыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой тусгах
- Захиргааны ерөнхий хуульд шүүхийн шийдвэрийн төрөл тус бүрд тохирсон биелүүлэх арга, хугацаа, журмыг тусгах
- Шийдвэр биелүүлээгүй захиргааны байгууллага, албан тушаалтанд авах албадлагын арга хэмжээ, хэрэгжих процессыг тодорхой зохицуулах
- Хуулийн төсөл боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийг мөрдөх
- Хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг төрөөс хариуцсаны дараа Захиргааны албан тушаалтнаас гаргуулах хуулийн заалтыг хэрэгжих механизмыг бий болгоход захиргааны албан тушаалтны даатгалын асуудлыг нэг мөр болгох.
- Цагдаагийн байгууллагын чиг үүргийн хуваарилалтын асуудлыг орчин үеийн онолоор нь судлах, энэ талаарх судалгааны ажлуудыг хөхиүлэн дэмжиж хийлгэх.
- Цагдаагийн болон хэв журмын эрх зүйн салбарын шинжлэх ухааны системчлэлийг бий болгох /ерөнхий , тусгай зохицуулалт/.
- Хууль тогтоомжийг судалгааны үр дүнд тулгуурлан шинэчлэн сайжруулах.

Ашигласан материалын жагсаалт

- ❖ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.2002 он
- ❖ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль.2015 он
- ❖ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.2016 он
- ❖ Зөрчлийн тухай хууль.2017 он
- ❖ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он
- ❖ Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он
- ❖ <https://forum.parliament.mn/projects/119>
- ❖ https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ
KEY ISSUES OF THE LEGAL REGULATION OF THE CRIMINAL
LIMITATION OF THE RIGHT TO TRAVEL

Н.Сайнбаяр

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн
процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш,
хууль зүйн доктор, цагдаагийн хошууч
[/sainbayar.n@uia.gov.mn/](mailto:sainbayar.n@uia.gov.mn/)*

N. Sainbayar

Senior Lecturer, Criminal Procedure Law
Department, Police School, University of Internal
Affairs, Doctor of Laws, Police Major

Хураангуй: Эрүүгийн эрх зүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, тэр дундаа ялыг оновчтой хэрэглэх асуудал туйлын чухал асуудал. Ял гэмт үйлдэлд тохирсон, гарцаагүй байж сая нийгэмд шударга ёс тогтох үндсэн нөхцөл бүрдэнэ.

Ялын үр нөлөө нь түүний гарцаагүй болоод тохирсон хэлбэрт агуулагдана. Сүүлийн жилүүдэд хийгдэж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад “зорчих эрхийг хязгаарлах ял”-ыг шинээр хуульчилсан нь дэвшилтэд зохицуулалт болсон гэж судлаачийн зүгээс үзэж байна. Энэхүү өгүүллэгээр зорчих эрхийн үр нөлөө, зорчих ялаар шийтгүүлсэн этгээд оргон зайлсан тохиолдолд авч хэрэгжүүлэх эрүүгийн процессыг тодорхой болгох чиглэлээр дүгнэлт, саналаа дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: In criminal law, the issue of imposing criminal liability, including the rational application of punishment, is an extremely important issue. Only when punishment is appropriate and inevitable for the criminal act, the basic conditions for establishing justice in society are created.

The effectiveness of punishment is contained in its inevitable and appropriate form. The researcher believes that the new legalization of “punishment for restricting the right to travel” in the revised version of the Criminal Code, within the framework of legal reforms carried out in recent years, has become a progressive regulation.

This article aims to present conclusions and proposals in the direction of clarifying the effectiveness of the right to travel and the criminal process to be followed in the event of a person sentenced to a travel sentence fleeing.

Keywords: travel restriction sentence, effect of sentence, escape, convict.

Түлхүүр үгс: зорчих эрхийг хязгаарлах ял, ялын үр нөлөө, оргон зайлах, ялтан.

Үндсэн хэсэг. Нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох нь төрийн эрүүгийн бодлогын чухал асуудлуудын нэг. Тухайн ял нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж, өдүүлэгчийн эрх зүйн байдалд тохирсон байж сая ялын үр нөлөө бий болдог. Хүнд гэмт хэрэгт хатуу ял оноох ёстой, энэ нь дараа үйлдэгдэх гэмт хэргээс сэргийлж чадна гэсэн бурангуй үзэл баримтлал хоцрогдон буйг өнгөрсөн түүх болоод криминологийн шинжлэх ухаан нотолсоор байна. Энэ талаар: “Заримдаа ял харгис хатуу байх нь ашиг тусгүй байдаг, яагаад гэвэл хүмүүсийг харанхуй бүдүүлэгт тооцож айлган сүрдүүлэх замаар захирах нь анх байгуулсан

нийгмийн гэрээ, шударга ёсныхоо үзлээс хөндийрнө”⁵⁵ гэж тодорхойлсон нь ч тохиолдлын шинжтэй зүйл биш юм.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах нь гарцаагүй, тэгвэл ямар ял оногдуулах вэ гэдэг нь хамгийн чухал болох нь маргаангүй юм. Иймд зорчих эрх хязгаарлах ялын үр нөлөө, түүнд тулгамдаж буй асуудлыг эрүүгийн эрх зүйн түвшинд, мөн энэ төрлийн ял шийтгүүлсэн этгээд оргон зайлсан тохиолдолд эрүүгийн процессыг тодорхой болгох гэсэн үндсэн 2 түвшинд судлан авч үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дах хэсэгт: хүн бүр “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй...” гэж заасан. Үүнээс зорчих эрхийг хязгаарлах ялын агуулгыг тодорхойлбол, Үндсэн хуульд заасан хүний чөлөөтэй зорчих эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлаж, хяналт тогтоох үйл явц юм. Нийгмийн хэрэгцээ шаардлага нь тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн хүнд заавал хорих ял биш, олон улсын түвшинд түгээмэл хэрэглэгддэг бусад төрлийн ялыг хэрэглэх бүрэн боломжтой байдлаар илэрхийлэгдэнэ.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 5.5 дугаар зүйлд: зорчих эрхийг хязгаарлах ялыг хуульчилсан. Хуулийн агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд, “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэхээс гадна түүнийг нийгмээс бүрэн тусгаарлахгүйгээр засарч, хүмүүжих, зүй зохистой, зөв амьдралд ороход нь туслах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, өөрийгөө хөгжүүлэх, ажил хөдөлмөр эрхэлж гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэх, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг олгох, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулдаг.

Шүүх зорчих эрхийг хязгаарлах ялыг сонгож оногдуулахдаа гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм буруугийн хэр хэмжээ, хувийн байдал, бусдад учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хүний үндсэн эрх, журамт үүрэг, амин чухал хэрэгцээ шаардлагуудыг харгалзан “эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох”, “тодорхой газар очихыг хориглох”, “шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих” зэрэг хуульд нэрлэн заасан хязгаарлалтын аль нэгийг, эсхүл хэд хэдэн хориглолт, хязгаарлалтыг зэрэгцүүлэн хэрэглэх, түүнчлэн чөлөөтэй зорчих хязгаарлалтын бүсийг нэг, эсхүл хэд хэдэн дүүрэг, хороо, багийн нутаг дэвсгэрийн аль тохирох нэгжийг хамааруулан тогтоох боломжтойгоос гадна ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл, тодорхой хүнтэй харилцахыг давхар хориглож болно.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн хүн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг хүлээх ба хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтын нөхцөлийг өөрчлөх, хязгаарлалт тогтоосон бүсээс гадагш түр зорчих, эсхүл удаан хугацаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлага үүсвэл энэ талаарх хүсэлтээ хяналт тавьж буй эрх бүхий байгууллагын албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх боломжтой.

Ялтан зорчих эрхийн хязгаарлалтыг зөрчиж хяналтын бүсээс гарах, хориглосон газарт очих, уулзахыг хориглосон хүнтэй харилцах, техникийн хяналтын тоног төхөөрөмжийг устгах, гэмтээх, хэвийн ажиллагааг нь сарниулах, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэх, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзах, эсэргүүцэх зэргээр ял эдлүүлэх журмыг ноцтой зөрчвөл зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааг хуульд заасны дагуу хорих ялаар солино.

Шүүх тодорхой үндэслэл заахгүйгээр ялтны гадагш зорчихгүй байх хязгаарлалтын бүсийг хэт өргөнөөр буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн том нэгж болох аймаг, нийслэл, эсхүл сум, дүүргийн нутаг дэвсгэрээр хялбарчилж тогтоох, эсхүл хэт хумьж оршин суугаа баг, хорооны

⁵⁵ Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Орч. Г.Эрдэнэбат. Уб., 2021.

нутаг дэвсгэрээс, эсхүл оршин суух хаяг буюу гэрээсээ гарч явахыг хориглох, түүнчлэн хязгаарлалт тогтоох нутаг дэвсгэрийн хүрээг шийдвэрлэхгүй орхигдуулах, хязгаарлалт тогтоох хугацааг оновчгүй тогтоох зэрэг алдаа зөрчил нь ял оногдуулах үндэслэл, журамд нийцэхгүйгээс гадна уг ялын зорилго, хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлнэ⁵⁶ гэж үздэг байна.

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ

Өөрийн оршин суух газраас явахыг хориглох	Тодорхой газар очихыг хориглох	Шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих
---	--------------------------------	------------------------------------	---

Хэдийгээр зорчих эрхийг хязгаарлах ялыг 2017.07.01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгаж өгсөн боловч 2022.01.01-ний өдрөөс л шүүхээс оногдуулж эхэлсэн. 2022 оноос эхлэн хэрэгжиж эхэлж байгаа боловч энэхүү ялын хэрэгжилтэд эрх зүйн зохицуулалтын багагүй асуудлууд байсаар байна.

Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх ёстой гэсэн үндсэн зарчмын дагуу зарим тохиолдолд шүүгдэгчийн ахуйн асуудлаас хамаарч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэх эсэх нь эргэлзээтэй байдлыг бий болгосоор байна. Тодруулбал, Зорчих эрхийг хязгаарлах ялыг “өөрийн оршин суух газраас явахыг хориглох” үүрэг болгох хэлбэрээр зөвхөн тодорхой оршин суух хаягтай хүнд л оногдуулахаар харагдаж байна. Оршин суух хаяггүй этгээдэд өөр ялыг сонгох хэрэглэж буй нийгмийн хэрэгцээ шаардлага нь дээрх зарчмыг зөрчихөд хүргэх юм.

Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангах зорилгоор цөөнгүй хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээний актуудыг батлан мөрдүүлж байгаа хэдий ч оргон зайлсан тохиолдолд хэрхэн шалгаж шийдвэрлэх асуудал эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхойгүй хэвээр байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял зөвхөн тодорхой газар, нутаг дэвсгэрт ялын хугацааг өнгөрөөх асуудал бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хязгаарлалт тогтоох⁵⁷ таслан сэргийлэх арга хэмжээтэй адилтан авч үзэж болохгүй. Таслан сэргийлэх арга хэмжээнд тодорхой газар нутгаар зорчихыг хязгаарлахаас гадна, тодорхой хүнтэй уулзахыг хориглодоггоороо онцлогтой юм.

Зорчих эрхийг хязгаарлах нь ялын төрөл бөгөөд энэ төрлийн ял шийтгүүлсэн этгээд оргон зайлсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүйг дурдах нь зүйтэй. Эрүүгийн хуулийн 21.11 дүгээр зүйлд оргон зайлах гэмт хэргийн хуульчилсан хэдий ч, Баривчлагдсан, цагдан хоригдсон яллагдагч, цагдан хоригдсон шүүгдэгч, эсхүл хорих ял шийтгүүлсэн ялтан оргон зайлсан бол гэж томъёолсон нь зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн этгээд оргосон нь энэ гэмт хэргийн субъектын шинжийг хангахгүйд хүрч буй юм.

Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино⁵⁸ гэсэн хуулийн заалт байдаг ч оргон зайлсан ялтныг хэрхэн эрэн сурвалжлах ажиллагаа явуулах, мөн хэрхэн шүүхийн шийдвэр гаргах хүртэл хугацаанд хэрхэн саатуулах асуудал зохицуулалтгүй үлджээ.

Оргон зайлсан ялтныг улсын хэмжээнд эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгууллаа гэж үзэхэд, ялтныг олж тогтоосны дараа, түүний үлдсэн зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ял болгох

⁵⁶ Монгол Улсын Дээд шүүхийн 2024.10.09-ний өдрийн 2024/ХШТ/119 дугаартай шийтгэх тогтоол.

⁵⁷ Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйл.

⁵⁸ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 3 дах хэсэг.

хүртэл хугацаанд хэрхэн саатуулах талаар хуулийн зохицуулалтгүй өдий хүрчээ. Өөрөөр хэлбэл, саатуулсан ялтныг шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд албадан байлгах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс алба хаагчид ялтныг хажуудаа харж байлгаж, хянаж хонох зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасаар байна.

Энэ талаар ДХИС, ЦЕГ хамтарсан Эрүүгийн процесс дах эрэн сурвалжлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал сэдэвт⁵⁹ эрдэм шинжилгээний бага хуралд оролцогчид онцолж байсан нь асуудлын тулгамдсныг давхар илэрхийлнэ. Зорчих эрхийг хязгаарлах ялын эрх зүйн зохицуулалт ийнхүү тодорхой бус, хууль зүйн хариуцлага хуульчлагдаагүй байдал нь ялтныг энэ төрлийн ялыг биелүүлэх эрмэлзэлгүй болгож, ялын үр нөлөөг бууруулахад хүргэх нь дамжиггүй.

Зорчих эрхийг хязгаарлах ял глобалчлагдаж байгаа энэ цаг үед хүний нийгмээс тусгаарлахгүйгээр эрүүгийн хариуцлагыг хүлээлгэж буй оновчтой арга хэрэгсэл боловч эрх зүйн зохицуулалтыг сайжруулахгүйгээр энэ төрлийн ялын ач холбогдол тодорхойлогдоход хүндрэл байсаар байна.

Дүгнэлт. Судалгааны ажлын явцад дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Зорчих эрхийг хязгаарлах ялыг тодорхой төрлийн гэмт хэрэгт оногдуулж эхэлсэн нь хүний эрх эрх чөлөөг хүндэтгэсэн, цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн оновчтой ялын нэгэн төрөл болжээ.

2. Зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтан оргон зайлсан тохиолдолд үлдсэн ялыг хорих ялаар солихоос өөр хууль зүйн хариуцлага байдаггүй нь энэ төрлийн ялаар шийтгүүлсэн этгээд оргон зайлах зэргээр сөрөг нөхцөлийг бүрдүүлж байна.

3. Энэ төрлийн ял шийтгүүлсэн яллагдагч оргон зайлсан тохиолдолд түүнийг эрэн сурвалжлах, олж тогтоож саатуулах ажиллагааны талаар эрх зүйн зохицуулалтгүй байгаа нь хүний эрх эрх чөлөөг зөрчих эрсдлийг бий болгожээ. Тухайлбал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг оргосон ялтныг хууль бусаар саатуулсан гэх гэмт хэргийн сэжигтэн яллагдагч болгох, оргон зайлсан ялтны эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлах зэргийг дурдаж болно.

4. Зорчих эрхийг хязгаарлах ялын хязгаарлах газар нутгийн хэмжээ, хязгаарыг тодорхойлж өгөөгүйгээс ялтнуудад өөр өөр цар хүрээ, хэмжээ бүхий хязгаарлалт оногдуулах сул талтай гэж үзлээ.

Санал. Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Оргон зайлсан ялтныг эрэн сурвалжлах, саатуулах процессыг тодорхой болгох. Тодруулбал, оргон зайлсан ялтныг саатуулж болох бөгөөд саатуулсан хугацаа нь эдлэх ялаас нь хасагдах агуулгаар холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

2. Зорчих эрхийг хязгаарлах ялыг тодорхой нутаг дэвсгэрийн хил хязгаараар бус радиус бүхий хэмжээгээр хязгаарладаг олон улсын туршлагыг нэвтрүүлэх.

3. Зорчих эрхийг хязгаарлах ялыг тодорхой оршин суух хаягтай ялтанд оногдуулж байгааг хэрэв ялтан хүсвэл гэж агуулгын өөрчлөлтийг оруулах зэрэг болно.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он;
2. Эрүүгийн хууль 2015 он;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он;
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он;

⁵⁹ 2024.12.06-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургууль, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төв, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба хамтран “Эрүүгийн процессын эрэн сурвалжлах ажиллагаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан.

5. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн тогтоол. Дугаар 128. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай;

6. Сайнбаяр, Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. УБ.,2024;

7. Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2024.10.09-ний өдрийн №2024/ХШТ/119 дүгээр тогтоол

8. "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 02.10.2024);

9. Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/>;

10. Цахим эх сурвалж: <https://star.worldbank.org/>.

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ШИНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ:
КИБЕР ГЭМТ ХЭРЭГ, ОНЛАЙН ЗАЛИЛАН**
"NEW TYPES OF CRIMES COMMITTED IN MONGOLIA:
CYBERCRIME, ONLINE FRAUD"

Б.Ганболд,
Дотоод Хэргийн Их Сургуулийн Цагдаагийн
сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах
багш, цагдаагийн ахмад

B. Ganbold,
senior lecturer of the Department of Criminal
intelligence at the Police School of the University
of Internal Affairs, police captain

Хураангуй: Монгол Улс, газар зүйн байршил, тусгаар тогтнол, эдийн засгийн хувьд дэлхий дахинд буй байр сууриа бэхжүүлсээр байгаа ч, кибер гэмт хэрэгтэй тэмцэх асуудал дээр бусад орноос доогуур байгаа нь хууль эрх зүйн орчин, олон улсын хамтын ажиллагаа, дэд бүтэц, мэргэшсэн боловсон хүчинтэй болох хэрэгцээ шаардлага улам бүр чухал болж байна гэдгийн харуулсаар байна.

Abstract: Mongolia, while strengthening its position in terms of geographical location, sovereignty, and economy globally, still lags behind other countries in tackling cybercrime. This highlights the increasing need for improvements in the legal framework, international cooperation, infrastructure, and the development of skilled human resources to effectively combat cybercrime.

Түлхүүр үгс: Кибер гэмт хэрэг, фишинг / хуурамч цахим сайт, төлбөрийн хэрэгсэл ашиглан хувь хүний нэвтрэх нэр, нууц үгийг хулгайлахад чиглэсэн хортой программ/, мэдээллийн аюулгүй байдал

Keywords: "Cybercrime, phishing (using fake websites and payment tools to steal personal login credentials and passwords), information security."

Оршил: Дижитал эрин үед кибер гэмт хэрэг нь дэлхийг даяар хувь хүн, бизнес, засгийн газар зэрэг бүх салбаруудад нөлөөлж, томоохон сорилтыг хүн төрөлхтний өмнө бий болгоод байна. Монгол Улс, газар зүйн байршил, тусгаар тогтнол, эдийн засгийн хувьд дэлхий дахинд буй байр сууриа улам бүр бэхжүүлсээр байгаа болов ч, кибер гэмт хэрэгтэй тэмцэх асуудал дээр бусад улс орноос доогуур байгаа нь хууль эрх зүйн орчин, олон улсын хамтын ажиллагаа, дэд бүтэц, мэргэшсэн боловсон хүчинтэй болох хэрэгцээ шаардлага улам бүр чухал болж байна гэдгийн харуулсаар байна.

Монгол Улс мэдээллийн технологи, интернэтийн хэрэглээг өргөнөөр нэвтрүүлж байгаатай холбогдуулан кибер гэмт хэргийн төрөл, гаралт ихсэж үйлдлийн арга улам нарийсаж байна. Энэ нийтлэлд Монгол улсад кибер гэмт хэрэг ямар байдлаар илэрч буй, үүний шалтгаан, нийгэмд үзүүлэх нөлөө, мөн энэ асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хийж буй оролдлогуудыг товчхон авч судлахыг хичээлээ.

Монгол Улс дахь кибер гэмт хэргийн нөхцөл байдал:

Кибер гэмт хэрэг нь интернет болон бусад дижитал харилцааны хэрэгслүүдийг ашиглан үйлдэгддэг шинэ төрлийн гэмт хэрэг юм. Эдгээр гэмт хэргүүд нь онлайн залилан, хувийн мэдээллийн хулгай, санхүүгийн залилан, кибер хүчирхийлэл, харилцаа холбооны сүлжээнд хууль бусаар нэвтрэх буюу хакердах, вирус тараах зэрэг олон төрлийн үйлдлүүдийг хамардаг.

Манай улсад хамгийн түгээмэл тохиолдож буй кибер гэмт хэрэг нь санхүүгийн залилан, фишинг халдлага болон харилцаа холбооны сүлжээнд хууль бусаар халдах зэрэг үйлдлүүд байна.

Онлайн санхүүгийн залилан, энэ төрлийн гэмт хэрэг нь хуурамч вэбсайтууд болон фишинг имэйлүүд ашиглан хувь хүний мэдээллийг хулгайлдаг. Мөн дараагийн түгээмэл үйлдэгддэг кибер гэмт хэрэг бол хувийн болон төрийн байгууллагууд руу чиглэсэн халдлагууд юм. Монгол улсад интернетийн хэрэглээ өргөжиж, илүү олон хүн онлайн үйлчилгээ ашиглаж эхэлсэнтэй зэрэгцэн кибер гэмт хэрэгтнүүд улам нарийн, илүү өндөр технологи ашиглан халдаж гэмт хэрэг үйлдсэн хэвээр байна.

Онлайн Залилах болон Санхүүгийн Залилангийн гэмт хэрэг:

Онлайн залилах болон санхүүгийн залилан гэдэг нь дижитал платформуудыг ашиглан хуурамч мэдээлэл өгч, хувь хүмүүсийн мөнгө болон хувийн мэдээллийг хулгайлах гэмт хэргийг хэлдэг. Монгол улсад энэ төрлийн гэмт хэрэг нь интернетийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр өсч байгаа олон гэмт хэргийн нэг төрөл юм. Сошиал медиа платформууд, цахим худалдааны вебсайтууд болон онлайн төлбөрийн системүүд нь гэмт хэрэгтнүүдэд иргэдийг онилон, судлан, залилах таатай орчныг бүрдүүлж өгч байна.

Монгол улсад хамгийн түгээмэл тохиолддог онлайн залилах гэмт хэргийн нэг төрөл нь "фишинг" халдлага гэж дээр дурьдсан. Гэмт хэрэгтнүүд хуурамч имэйл илгээж, эсвэл танил сайтуудыг хуурамчаар дуурайлган хийж, иргэдийн хувийн мэдээлэл, банкны данс, нууц үг, картын дугаарыг залилж авч хулгайлдаг. Эдгээр хуурамч сайтууд нь танил брэндүүдийн цахим худалдааны вэбсайтууд болон банкны сайтыг дуурайж, хэрэглэгчдийг хууран мэхлэх зорилгоор бүтээгдсэн байдаг.

Мөн санхүүгийн залилангийн өөр нэг түгээмэл хэлбэр нь хөрөнгө оруулалтын залилан юм. Залилагчид өндөр өгөөж амлаж, иргэдийг криптовалют эсвэл үл хөдлөх хөрөнгө гэх мэт салбарт хөрөнгө оруулахад урьдаг. Иргэн мөнгөө шилжүүлсний дараа залилагчид усанд хаясан чулуу мэт алга болж, хохирогчид өөрийн хөрөнгийг буцааж авах боломжгүй болж хоцордог. Энэ төрлийн залилан нь Монгол улсад амьдарч буй дунд давхаргын хүмүүсийн хөрөнгө оруулах хүсэлд тулгуурлан чиглэгддэг бөгөөд эдийн засгийн эрсдэлээс зайлсхийхийн тулд олон хүн хөрөнгө оруулах хүсэлд хөтлөгдөн энэ төрлийн залилах гэмт хэргийн хохирогч болсоор байна.

Мөн Монгол улсад дижитал төлбөрийн системүүдийн хурдтай хөгжиж байгаа нь гэмт хэрэгтнүүдэд мөнгө хулгайлах, гэмт хэргийн замаас олсон мөнгөө угаах боломжийг олгодог. Зарим цахим худалдааны вебсайтууд болон банкны системүүдийн аюулгүй байдлын стандартууд хангалтгүй байдаг бөгөөд энэ нь гэмт хэрэгтнүүдэд гэмт хэрэг үйлдэхдээ ашиглах боломжийг бүрдүүлж өгч байна.

Шалтгаан нөхцөл:

Манай улсад кибер гэмт хэрэг нэмэгдэхэд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Нэгдүгээрт, Монгол улсад цахим шилжилт хурдацтай явагдаж интернетийн хэрэглээ, ялангуяа гар утсаар дамжуулан интернетийн үйлчилгээ авч ашиглаж буй хүн амын тоо эрс өссөн. Гэвч эдгээр хүмүүсийн мэдээллийн аюулгүй байдалд анхаарал хандуулахгүй, мэдлэг тааруу хэнэггүй байхаас шалтгаалан, цахим гэмт хэрэгт өртөх эрсдэл нэмэгдсээр байна. Монголд улсад кибер аюулгүй байдлын боловсрол, мэдлэг, ойлголт харьцангуй бага байгаа нь иргэдийг цахим гэмт хэргээс өөрийгөө хамгаалах хязгаарлагдмал боломжийг бий болгож байна.

Хоёрдугаарт, Өнөөдрийн байдлаар Монгол Улсад кибер гэмт хэргийн эсрэг хуулийн хүрээ, хэрэглээ хангалттай хөгжөөгүй байна. Хэдийгээр Монгол Улс сүүлийн жилүүдэд кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд томоохон алхам хийсэн байгаа ч хууль эрх зүйн орчин нь чамлалттай хэвээр байна. Хууль сахиулах байгууллагууд нь техник, технологийн мэдлэг дутмаг байгаа бөгөөд кибер гэмт хэргийг мөрдөж, шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг чадвартай хүний нөөц дутагдалтай байна. Мөн интернэт орчин нь олон улсын хил хязгаарыг давж гарах боломжийг олгодог тул кибер гэмт хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгах нь улс орнуудын хоорондын хууль тогтоомж, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх зэрэг асуудлуудаас болж хүндрэлтэй хэвээр байна.

Кибер Гэмт Хэрэгний хор уршиг:

Монгол улсад кибер гэмт хэргийн нөлөө маш өргөн хүрээтэй. Санхүүгийн хувьд, байгууллагууд болон хувь хүмүүс залилах, хакердах болон бусад төрлийн кибер халдлагаас болж сэтгэл санаа болон эд хөрөнгийн хохирол их амсадаг. Ихэнх тохиолдолд хохирогчид хулгайлагдсан эд хөрөнгөө буцааж авах боломжгүй үлддэг. Кибер гэмт хэрэг нь олон нийтийн сүлжээ, шинэ дижитал платформуудын талаар буруу ойлголт төрүүлж итгэлийг алдагдуулж, Монгол улсын цахим эдийн засгийн өсөлтөд саад учруулж байна. Онлайн худалдаа, цахим үйлчилгээний талбарууд дахь хэрэглэгчид хуурамч вэбсайтууд болон өөр төрлийн залилах гэмт хэрэгт өртөх эрсдэлээс айж, цахим орчинд санхүүгийн гүйлгээ хийхээс зайлсхийдэг.

Мөн кибер гэмт хэрэг нь нийгэмд болон иргэдийн сэтгэлзүйд хортой нөлөөлж байна. Кибер хүчирхийлэл, онлайн доромжлолын гэмт хэргийн хохирогчид сэтгэл зүйн хүндрэлд орох, хувь хүний мэдээллийн хулгай, бусдын нэр төр алдар хүндэд халдах зэрэг гэмт хэрэгт өртөж урт хугацааны сөрөг үр дагаврыг амсах эрсдэлтэй. Мөн интернэт кибер орчин нь гэмт хэрэгтнүүдэд өөрсдийгөө халхавчлах, нуугдах, ял завших, зайлсхийх боломжийг олгодог тул кибер гэмт хэргийн гаралт ихсэж иргэд өөрсдийгөө хамгаалахад улам бүр хүндрэлтэй болсоор байна.

Бизнес эрхлэгчдийн хувьд үр дагавар нь бас хүнд байна. Иргэд өөрсдийн брэндтэй холбоотой луйврын хохирогч болсон тохиолдолд ялангуяа жижиг бизнесүүд нэр хүндэд нь хүнд хохирол учруулж болзошгүй. Цаашилбал, санхүүгийн гүйлгээг онлайнаар хийдэг байгууллагууд аюулгүй байдлын асуудалтай тулгарч кибер халдлагын бай болж болзошгүй. Гэмтсэн системийг засварлах, алдагдсан өгөгдлийг сэргээх, олон нийтгүй харилцах хямралыг зохицуулах нь маш их зардал дагуулдаг.

Дүгнэлт. Монголын засгийн газар кибер гэмт хэргийн өсөлтийг хүлээн зөвшөөрч, уг асуудлыг шийдвэрлэхийн тулд хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. 2017 онд Монгол Улс анхны Кибер Аюулгүй Байдлын Хуулийг баталсан бөгөөд энэ хуулиар дижитал технологийн хэрэглээг зохицуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, кибер гэмт хэргийг таслан зогсоох, мөрдөн шалгах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх анхны суурь тавигджээ.

Мөн Монгол Улс кибер аюулгүй байдлыг хангах төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагыг бий болгосон бөгөөд энэ агентлаг нь улс орондоо кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын талаар олон нийтэд боловсрол олгох, технологийн аюулгүй байдлыг сайжруулах ажлуудыг зохион байгуулж байна.

Үүнээс гадна Монгол улсын төрийн болон хувийн хэвшил өөрсдийн цахим эд хөрөнгийг хамгаалахын тулд кибер аюулгүй байдалд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн байна. Олон компаниуд шифрлэлт, цахим хамгаалалтын системүүдийг бий болгож өөрсдийн ажилчдын дунд кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох сургалт арга хэмжээ авч байна. Гэвч технологийн хурдтай хувьсан өөрчлөгдөж буй байдал нь байгууллагуудыг тогтмол шинэчлэл хийж байх шаардлагатайг сануулсаар байна.

Монгол Улсад кибер гэмт хэрэг өссөөр байгаа нь үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх чухал асуудал бөгөөд үүнийг шийдвэрлэхэд ганц төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд гэлтгүй хувь хүмүүсийн хамтын хүчин чармайлт хамгаас чухал юм. Дижитал шилжилт, цахим эдийн засагт оролцож буй иргэдийн тоо нэмэгдэж буй энэ үед кибер гэмт хэргийн эрсдэл өсөх нь дамжиггүй. Эдгээр эрсдэлийг бууруулахын тулд кибер аюулгүй байдлын хуулийг сайжруулах, олон нийтэд мэдээллийн аюулгүй байдлын талаар ойлголт өгөх, хууль сахиулах байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх шаардлагатай. Монгол Улс дижитал эринд аюулгүй орчин бүрдүүлэхийн тулд энэ асуудлыг шийдвэрлэх чиглэлээр идэвхтэй арга хэмжээнүүдийг шат дараалан авч хэрэгжүүлэх ёстой.

Санал. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг сайжруулахад нөлөөлж болох дараах саналуудыг авч үзлээ. Үүнд:

1. Хууль эрх зүйн чадамжийг сайжруулах

- **Кибер гэмт хэрэгтэй холбоотой хууль тогтоомж:** Манай улс кибер гэмт хэрэг, хакердах, хувийн мэдээлэл хулгайлах, өгөгдөл алдах, онлайн луйвар зэрэг кибер гэмт хэрэгт чиглэсэн хүчтэй хуулиудыг батлах хэрэгтэй. Эдгээр хууль нь олон улсын стандартад нийцэж байх ёстой бөгөөд дэлхий даяар хамтын ажиллагааг хангахад чухал юм.

- **Хуулийг шинэчлэх:** Хууль тогтоомжуудад шинэ технологиуд, кибер гэмт хэрэгт ашиглагддаг арга барилтай холбогдсон шинэчлэлтүүдийг үргэлж хийж байх шаардлагатай.
 - **Тохирох шийтгэл болон хэрэгжилт:** Кибер гэмт хэргийн үйл ажиллагаанд заасан шийтгэлийг чангатгаж, хууль сахиулах байгууллагуудын кибер гэмт хэрэгтэй тэмцэх тусгай нэгжүүдээр дамжуулан үр дүнтэй хэрэгжүүлэх.
2. Хоёрдогч хамгаалалтын технологиудыг хөгжүүлэх
- **Галт хана (Firewall) ба Шифрлэлтийн системүүд:** Хувийн мэдээллийг хууль бус хандалтаас хамгаалах, хулгайд алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хүчтэй галт хана /хамгаалагч/ болон шифрлэлтийн техникуудыг хэрэглэх.
 - **Дотоод сүлжээг хянах систем (IDS):** Сүлжээгээр дамжих бусад үйл ажиллагааг хянах, холбогдох гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардагдах мэдээлэл олж авах зорилгоор IDS ашиглах.
 - **Хиймэл оюун ухаан (AI) ба Машин бие даан суралцах (ML):** Эдгээр технологиуд нь сүлжээнд болж буй эрсдэлтэй үйлдлийг таньж, кибер халдлагын оролдлогыг цаг алдалгүй илрүүлэхэд тусална.
 - **Хоёр шатлалт баталгаажуулалт (2FA):** Онлайн дансанд хэт олон тооны нэвтрэх эрхээс хамгаалах зорилгоор хоёр шатлалт баталгаажуулалтыг хэрэглэгчдэд уриалах.
3. Кибер аюулгүй байдлын сургалт ба ойлголтыг хүртээмжтэй болгох
- **Олон нийтэд чиглэсэн сургалт:** Иргэдэд онлайн аюулгүй байдлын зөв дадал зуршлыг зөвлөж, цахим хуудас болон сэжигтэй холбоосуудаас хэрхэн сэргийлэх, баталгаажуулсан нууц үг зохиох аргуудыг сургах.
 - **Ажилтнуудад зориулсан сургалт:** Байгууллагууд өөрсдийн ажилтнуудаа кибер аюулгүй байдлын ойлголт, дадал зуршлыг тогтмол сургаж, хүний алдаа болон халдлагаас урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг олгож байх.
 - **Сургалтын хөтөлбөрүүд:** Сургууль болон их дээд сургуульд кибер аюулгүй байдлын боловсролыг түлхүү хөгжүүлэх нь кибер аюулгүй байдалтай нүүр тулж, давж гарах чадвартай боловсон хүчин бэлтгэхэд тусална.
4. Олон улсын хамтын ажиллагааг сайжруулах
- **Олон улсын хамтын ажиллагаа:** Кибер гэмт хэрэг нь хил хязгааргүй үндэстэн дамнаж үйлдэгддэг гэмт хэрэг тул хууль сахиулах байгууллагууд (жишээ нь, Интерпол, Европол) хоорондын хамтын ажиллагаа кибер гэмт хэрэгтэнг илрүүлэх болон шүүхийн байгууллагад шилжүүлэхэд чухал үүрэгтэй.
 - **Шийтгэл эдлүүлэх гэрээ хэлэлцээрүүд:** Улсууд кибер гэмт хэргийн үйлдэгчдийг эх оронд нь шилжүүлэн авчрах зорилгоор экстрадицийн гэрээ байгуулах.
 - **Дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд ба тогтолцоо:** Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Холбоо зэрэг олон улсын байгууллагууд кибер гэмт хэрэгтэй тэмцэх дэлхий нийтийн ёс зүйн тогтолцоог тогтоох .
5. Хууль сахиулах байгууллагын бүрэлдэхүүн нэгж тус бүр дээр кибер гэмт хэрэгтэй тэмцэх тусгай тасгийг байгуулах
- **Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тусгай нэгжүүд:** Олон улсад өөрсдийн цагдаагийн байгууллага дотор кибер гэмт хэргийн тусгай нэгжийг байгуулж, кибер гэмт хэргийн эсрэг тэмцдэг. Манай улсын хувьд кибер гэмт хэрэгтэй тэмцэх ганцхан нэгж байдаг. Эрүүгийн цагдаагийн газрын харьяа Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар. Бусад хот сууринд байрлах цагдаагийн газар хэлтэст шинэ төрлийн гэмт хэрэг болох кибер гэмт хэргийн таньж мэдэх, илрүүлэх, мөрдөн шалгах, таслах зогсоох мэдлэг чадамж дутмаг байсаар байна.
 - **Хувийн секторын хамтын ажиллагаа:** Хууль сахиулах байгууллагууд технологийн компаниуд, интернет үйлчилгээ үзүүлэгчид (ISP), кибер аюулгүй байдлын компаниудтай хамтран кибер гэмт хэрэг үйлдэгчдийг илрүүлэх таслан зогсоох чиглэлээр мэдээлэл солилцдог байх хэрэгтэй.

6. Яаралтай хариу арга хэмжээ үзүүлэх таслан сэргийлэх тусгай баг бий болгох.

- **Хариу арга хэмжээ үзүүлэх баг:** Байгууллагууд болон засгийн газар кибер халдлагын үед хариу үйлдэл үзүүлэх тусгай багтай байх ёстой бөгөөд гэмт хэргийг хэрхэн үйлдсэн болохыг цаг алдалгүй тооцоолох мөн түүнээс болж учирсан хохирлыг тодорхойлох, таслан зогсоох үүрэгтэй.
- **Өгөгдлийн нөөцлөлт:** Үндсэн өгөгдлөө тогтмол нөөцөлж байх, халдлага болж өгөгдөл алдсан тохиолдолд хурдан сэргээн босгох боломжтой байх.
- **Олон нийтийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа:** Засгийн газар болон хувийн байгууллагуудын хамтын ажиллагаа нь кибер халдлагад илүү хурдан хариу өгөх боломжийг олгодог.

7. Хар Веб (Dark Web) дээрх үйл ажиллагааг хянах

- **Хар вебийг хянах (dark web):** Кибер гэмт хэрэг, хулгайлагдсан мэдээлэл эсвэл хууль бус үйлчилгээг борлуулж буй үйл ажиллагаа нь хар веб дээр ихэвчлэн явагддаг. Хууль сахиулах байгууллагууд нь эдгээр үйл ажиллагааг таслан зогсоох урьдчилан сэргийлэх болон мөрдөн шалгах зорилгоор тогтмол хянаж байх.
- **Технологийн компаниудтай хийх хамтын ажиллагаа:** Нийгмийн сүлжээ, хайлтын систем, төлбөрийн үйлчилгээний компаниуд нь хууль сахиулах байгууллагуудтай хамтран хууль бус үйл ажиллагааг илрүүлж, устгахад чухал үүрэг гүйцэтгэж байдаг.

8. Этик хакердалт (Цагаан малгайт хакерууд)

- **Этик хакеруудын дунд алдаа засах урамшуулалт хөтөлбөр зарлах:** Цагаан малгайт хакерууд нь байгууллагуудын систем дэх сул талуудыг олж, эдгээрийг мэдээлэх замаар кибер гэмт хэрэг үйлдэхээс өмнө урьдчилан сэргийлэх боломжийг олгодог.
- **Хактивизм:** Этик хакерууд нь кибер аюулгүй байдлын талаарх мэдлэгийг олон нийтэд түгээх, байгууллагуудын сул талуудыг илрүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэж болно.

9. Бизнесийн байгууллагын кибер гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрүүд

- **Кибер аюулгүй байдлын бодлого болон аудит:** Байгууллагууд нь бүхэлдээ кибер аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, халдлагаас урьдчилан сэргийлэхийн тулд тогтмол аюулгүй байдлын аудит хийдэг байх.
- **Өгөгдлийн хандалтын хяналт:** Хувийн мэдээллийг зөвхөн шаардлагатай хүмүүст хүргэх нь халдлагын аюулыг хязгаарлахад тусална.
- **Гэмт хэргийн тухай мэдээлэл өгөх:** Ажилтнууд болон хэрэглэгчдийг сэжигтэй үйл ажиллагаа болон зөрчилд цаг алдалгүй хууль сахиулах байгууллагад мэдээлэхийг уриалснаар кибер халдлагаас сэргийлэх боломжтой.

10. Олон нийтийн болон хувийн секторын хамтын ажиллагаа

- Засгийн газар, хувийн байгууллага, болон төрийн бус байгууллагууд хамтран кибер аюулгүй байдал болон кибер гэмт хэрэгтэй тэмцэх нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх.
- **Мэдээлэл солилцох:** Төр, хувийн хэвшлийн хооронд мэдээлэл солилцох платформуудыг бий болгох нь кибер гэмт хэрэгтнүүдийн үйлдлийг таслан зогсооход тусална.

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ОНЛАЙН БЭЛГИЙН СҮРДҮҮЛЭГ, ХҮЧИРХИЙЛЭЛ ONLINE-GROOMING AND SEXTORTION

*Б.Батжаргал
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш
Цагдаагийн дэд хурандаа
Batjargal B,
Police lieutenant colonel,
senior lecturer of the
Department of Criminal intelligence
at the Police school of the
University of Internal Affairs Mongolia*

Хураангуй. Кибер орчинд үйлдэгддэг бэлгийн сүрдүүлэг, хүчирхийлэлд хэн ч өртөх боломжтой, мөн хаанаас ч үйлдэгдэх боломжтой. Тэр тусмаа хүүхдийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, шийтгэхэд энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдлэг чухал юм. Энэхүү өгүүлэлд тус гэмт хэргийн төрөл, хүчин зүйл, үйлдэгддэг арга, хэрэгсэл, төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг судалж бичив.

Abstract. Cyber crime refers to one of the modern threats to national security. The article provides the main factors that determine the development of cybercrime which like online-grooming and sextortion. Studied government policies and non-government organizations operates.

Түлхүүр үгс: кибер гэмт хэрэг; хүүхдэд садар самуун сурталчлах, уруу татах; интернэт ашигласан бэлгийн сүрдүүлэг; онлайн бэлгийн сүрдүүлэг, хүчирхийлэл.

Key words: information technology crimes; cybercrimes to exploit children; online-grooming; sextortion; violence.

Үндсэн хэсэг. Хил хязгааргүй интернэтэд суурилсан технологийн хөгжил нь амьдралд шинэ шинэ эерэг боломжуудыг нээхийн зэрэгцээ бидний хүүхдэд хараа хяналтгүйгээр хандах сөрөг боломжийг нээж өгч, эрсдэл учруулж байна. Хүүхдийг биет байдлаар бид хамгаалж чадах боловч гэмт этгээдүүд энэ хамгаалалтыг технологийн тусламжтайгаар үгүй хийж чадаж байна гэхэд хэлсдэггүй.

Интернэт ашиглан хоорондоо харилцах, мэдээлэл солилцох, суралцах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нь өнөө цагт хүүхдүүдийн амьдралын энгийн нэгэн хэв маяг болсон. Гэвч үүнийг дагаад онлайн бэлгийн сүрдүүлэг, хүчирхийлэл (Online-Grooming; Sextortion) -ийн аюул занал учирч байна.

Бид хүүхэддээ танихгүй хүнтэй ярилцаж, уулзаж болохгүй талаар анхааруулан халамжилдаг ч хүүхдүүд кибер орчинд хүмүүстэй шинээр харилцаа тогтоох, найзын хүсэлтийг хүлээн авах, бүлгэмд элсэх, амьдрал дээр бодитоор нүүр тулж уулзаж байгаагүй ч аль хэдийн онлайн найзууд болсон байх, дагалдах зэрэгт тэднийг танихгүй хүн гэж харахгүй байх нь олонтаа.

Online-Grooming нэр томъёолол нь насанд хүрсэн хүн интернэт ашиглан хүүхэдтэй найз нөхөр болж итгэлийг нь олж авч улмаар түүнтэй дотно харилцаа үүсгэн сэтгэл зүйн эмзэг байдалд тулгуурлан ятгах, айлгах, сүрдүүлэх арга замаар түүнээс нүцгэн зураг, бичлэг зэргийг гаргуулан авах ажиллагаа юм.⁶⁰ Энэ ажиллагаандаа гэмт этгээдүүд нийгмийн сүлжээ, цахим шуудан, текст мессеж, онлайн тоглоомын чат болон веб сайтуудыг хэрэгсэл болгон ашигладаг. Гэмт этгээдүүд хүүхэдтэй биетээр уулзах гэж оролддог нь хамгийн аюултай юм. Хүүхдийн гэнэн цайлган,

⁶⁰ https://info.thorn.org/hubfs/Research/2022_Online_Grooming_Report.pdf

туршлагагүй байдлыг ашиглан гэмт этгээдүүд төрөл бүрийн сэтгэл зүйн дайралт, дарамт учруулснаар өөрсдийн санаархалдаа төвөггүй хүрч чаддаг нь энэ төрлийн гэмт хэргийн онцлог юм.

Хохирогчийг сонгож онилох шалтгаан:

- Хохирогчийг мэддэг, таньдаг байх;
- Нийгмийн сүлжээний бүлгэмийн гишүүдээс нүдэнд өртөхүйц гадаад төрх байдлаар нь;
- Тусгайлан захиалгын дагуу;
- Санамсаргүй байдлаар;

Хохирогчийг онилсны дараа түүний талаар нийгмийн сүлжээ дэх олох боломжит бүхий л хувийн мэдээллийг нарийн судалж, найз болох хүсэлт илгээдэг.

Эдгээр гэмт этгээдүүд нэг платформоос нөгөө платформ руу буюу хоёрдогч, гуравдагч платформ руу шилжүүлэх, ингэхдээ ихэвчлэн криптографын аргаар хамгаалагдсан (encrypted) платформыг ашиглан харилцдаг нь хууль хяналтын байгууллагууд мөрдөхөд бэрхшээл учруулах, мөрөө баллах зорилготой байдаг. Олон улсын онлайн бэлгийн мөлжлөгийн эсрэг сайн дурын Thorn байгууллагаас хийсэн судалгаагаар хохирсон гурван хүүхэд тутмын хоёрт нь энэ аргыг хэрэглэсэн үр дүн тогтоогдсон.⁶¹

Гэмт этгээдүүд хүүхдийн итгэлийг олж авахын тулд түүнтэй тогтмол харилцаатай байж, сонирхдог сэдвээр нь ярилцах, тохиолдсон бэрхшээл, асуудлуудыг нь анхааралтайгаар сонсох, бэлэг илгээх зэрэг аргыг хэрэглэдэг.

Sextortion нэр томъёолол нь Sex extortion гэсэн холбоо үгнээс гаралтай ба дээрхтэй адил итгэлийг олж авах, эсвэл бэлэг, мөнгө санал болгох, шууд сүрдүүлэх аргаар үйлдэгддэг.⁶²

Хүүхэдтэй бэлгийн харилцааны сэдвээр ярилцах, чатлах, түүнд нүцгэн, садар самуун зураг илгээх, ингэхдээ гэмт этгээд байнга дэлгэцийн үйл явцыг бичлэг, скрийншот хийж баримтжуулж байдаг ба буцаагаад эдгээр цуглуулсан материалуудаар сүрдүүлэх; онилсон хүүхдийн талаар нарийн судалгааг хийсний үндсэн дээр мэдээллээр сүрдүүлэх; бэлэглэсэн бэлгийг буцааж нэхэх, төлбөр төлөхийг шаардах; бэлэг, төлбөрийн хариуд нь өөрийн нүцгэн зураг, бичлэг илгээхийг шаардах; нүцгэн зураг, бичлэг нь хэдий байхгүй ч аль хэдийн байгаа мэтээр сүрдүүлэх, хиймэл оюун ухаанд суурилсан технологийн тусламжтай эвлүүлэгт оруулан сүрдүүлж нүцгэн зураг, бичлэгийг гаргуулж авах ажиллагаа юм.

Холбоо тогтоохдоо ихэвчлэн ойролцоо насны ижил эсвэл эсрэг хүйсний хуурамч профайл хаягийг ашигладаг ба олон төрлийн хуурамч хаягаас нэг этгээд нэгэн зэрэг харилцах, эсвэл бүлэг этгээдүүд үгсэн тохиролцож олон янзын дүрээр харилцдаг.

Sextortion нь уламжлалт ба санхүүгийн гэсэн хоёр төрөлтэй.

Уламжлалт төрөл нь гэмт этгээд хохирогчийг сүрдүүлж илүү их зураг бичлэгийг гаргуулж авах, мөн биечлэн уулзаж хүчирхийлэх зорилготой үйлдэгддэг бэлгийн мөлжлөгийн хэлбэр гэмт хэргийн төрөл юм. Хохирогчид нь ихэвчлэн 10-17 насны охидууд байдаг.

Санхүүгийн төрөл нь гэмт этгээд хохирогчийг сүрдүүлж бэлгийн карт, крипто валютаар төлбөр төлснөөр түүний нууцыг хадгалах ба эсрэг тохиолдолд нийтэд дэлгэнэ хэмээн сүрдүүлдэг. Санхүүгийн зорилготой учраас ихэвчлэн хилийн чанадаас үйлдэгддэг ба хохирогчидын дийлэнхийг 13-17 насны хөвгүүд эзэлдэг.

Гэхдээ уламжлалт ба санхүүгийн төрөлд эр, эм хүйсээс үл шалтгаалан ямар ч насны ХҮҮХЭД ХОХИРОГЧ болох боломжтой.

Хэрхэн хамгаалах вэ?

Нээлттэй, илэн далангүй харилцаа, итгэлцэл бол хамгийн сайн хамгаалалт юм. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ ямар ч сэдвээр нээлттэй ярилцаж, ойлголцож чаддаг, хүүхдэд ямар нэгэн асуудал бэрхшээл тулгарахад эцэг эх, асран хамгаалагчид шууд ханддаг байх итгэлцэл бий болгох, интернэт орчинд хэрхэн зүй зохистой, аюулгүй биеэ авч явах, аюул занал бий гэдгийг,

⁶¹ [https://info.thorn.org/hubfs/Research/2022 Online Grooming Report.pdf](https://info.thorn.org/hubfs/Research/2022%20Online%20Grooming%20Report.pdf)

⁶² <https://www.ice.gov/features/sextortion> АНУ-ын Холбооны мөрдөх товчооны албан ёсны веб сайт.

түүнээс урьдчилан сэргийлэх, аюул занал учирсан тохиолдолд тэр даруй мэдэгдэх талаар урьдчилан ярилцах;


Мөн хүүхдийнхээ хэрэглэдэг гар утас, бусад төхөөрөмжийг шалгах, хэнтэй харилцаж, нөхөрлөж байгааг мэддэг байх, хүүхдийн зан байдал өөрчлөгдөх зэргийг ажиглах;

Хүүхдийн нийгмийн сүлжээ дэх хувь профайлын нууцлал аюулгүй байдлын тохиргоог шалгах. Хэдий чинээ мэдээллийг ил байлгана, төдий чинээ гэмт хэрэгтэнг мэдээллээр хангах боломжтой гэдгийг ойлгуулах;

Ашиглаж байгаа төхөөрөмжүүдэд эцэг эхийн хяналтын тохиргоог идэвхижүүлэх, нэмэлтээр хяналтын программ суулган ашиглах;

Кибер орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал:

График 1. Гэмт хэргийн тоо, 2015-2023 он.⁶³



Бүртгэгдсэн гэмт хэргийн зүйл, ангиар нь авч үзвэл залилах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, заналхийлэх, хүчиндэх, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, кибер орчинд хууль бусаар халдах төрлийн гэмт хэрэг тус тус үйлдэгджээ.

Кибер орчинд хүүхдийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх өнөөгийн байдал:

Монгол Улсын Засгийн газар, ХЗДХЯ, МУГХУСАЗЗ, ЦЕГ, Харилцаа холбооны зохицуулах хороо, НҮБ-ын Хүүхдийн сан, Faro төрийн бус байгууллага хамтран цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2018, 2019 онд “UNFRIEND, “Цахим орчинг зөв болгоё”, “Зөвийг түгээе” аяныг зохион байгуулсан.⁶⁴

Энэ аянууд хэрэгжих хугацаанд улсын хэмжээнд гэмт хэрэг 10-60 орчим хувиар буурсан. Гэхдээ бууралтыг байнга барьж чадахгүй байна. Хүүхэд хохирсон гэмт хэрэг сүүлийн гурван жил арав, тав, гурван хувиар буурсан эерэг үзүүлэлт бий. Гэсэн хэдий ч жилд дунджаар 1500-2000 хүүхэд гэмт хэргийн хохирогч болж байна⁶⁵.

Монголын Улсын хууль сахиулах байгууллагууд АНУ-ын хууль сахиулах байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, гэмт хэрэгтнүүдийг мөрдөх, яллах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах

⁶³ Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал. УБ.,2023

⁶⁴ Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам судалгааны тайлан УБ.,2021. 34 дахь тал

⁶⁵ Д.Будзаан: Хүүхдийн эсрэг гэмт хэргийн 87 хувийг насанд хүрсэн хүмүүс үйлддэг. ЦЕГ-ын албан ёсны веб сайт., <https://police.gov.mn/a/5049>.

чиглэлээр сайн туршлагаа хуваалцаж байна. Монгол Улсын цагдаагийн байгууллага G7 24/7 цахим гэмт хэрэгтэй тэмцэх Олон улсын сүлжээнд нэгдэн орж⁶⁶, ингэснээр бусад гишүүн орнуудын хууль хяналтын байууллагуудтай шуурхай мэдээлэл солилцон хамтран ажиллах, цахим нотлох баримтыг гаргуулан авах боломжтой болж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд 2013 оноос www.ekids.mn цахим хуудсыг ажиллуулан хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгч нарт зориулан хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээг сурталчлан таниулах, цахим орчин дахь эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээлэл, зөвлөмж, зааварчилгаа, сургалтын гарын авлага зэргийг бэлтгэн хүргэж байна.⁶⁷

Мөн Хүүхдийн тусламжийн утас 108 нь 24 цагийн турш үнэ төлбөргүйгээр Монгол улсын өнцөг булан бүрээс 0-18 насны хүүхдийн хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авч, тухайн орон нутаг, байгууллагын мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучлах, яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучлах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн мэдээллийг хүргэх, хүүхдийн дуу хоолойг сонсон хүүхэд хамгааллын асуудлаар шийдвэр гаргахад болон хүүхэд хамгаалалд хүүхдийн оролцоог хангах, оролцоонд тулгуурлан хүүхдийг хөгжүүлэх, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалалд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.⁶⁸

Эрүүгийн хуулийн 16.8 болон 16.9-д хүүхдийг садар самуунд уруу татах, ашиглахыг хориглосон заалт байдаг ч садар самуун явдал гэсэн ойлголтыг нарийвчлан тодорхойлоогүйн дээр кибер орчинд хүүхдийг садар самуунд оролцуулах, уруу татах, ашиглах болон бодит хүүхдийг оролцуулаагүй ч хүүхдийн дүрсийг дуурайлгасан зохиомол дүрийг садар самуунд оролцуулах талаар тусгайлсан заалт оруулаагүй байна. Түүнчлэн, кибер орчинд хүүхдийг уруу татах, холбоо тогтоох, урхихах, кибер орчинд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэхээр дарамтлах гэх зэрэг бусад нарийн асуудлуудыг хуульчилж, зохицуулаагүй байна.⁶⁹

Жишээ 1. ...Би тухайн охиноос “чи хэдэн настай вэ” гэж асуухад “13 настай” гэхээр нь “би 19 настай” гэж хэлэхэд “би ах хүнтэй уулзахгүй” гээд байсан.

...Би надтай уулзах юм бол чамтай дахиж уулзахгүй, чи надтай уулзвал чатаа группт тавихгүй” гэж хэлэхэд намайг 1 дүгээр хороолол, 32 дугаар байрны гадаа дуудахаар нь яваад очтол ирээгүй байсан тул “би явлаа шүү” гэхэд “би очиж байна” гэж биччихээд “айгаад байна” гэсэн. Тэгээд 2 цагдаа ирээд намайг бариад авсан...”

Шүүгдэгч Б.А-ын үйлдэлд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл тогтоогдоогүй ба эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болох тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэнийг харгалзан, тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, нөхцөл, хувийн байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.8 дугаар зүйлийн 1-д зааснаар 3000 /гурван мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 3.000.000 /гурван сая/ төгрөгөөр торгох ял оногдуулах нь зүйтэй гэж шүүх үзлээ.

Санал. Хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, Олон улсад амжилттай хэрэгжиж байгаа гэрээ конвенцид нэгдэн орох. Учир нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа манай Улсын хуульд дээрх хүчирхийллийн хэлбэрүүд олон улсын нэр томъёоны агуулгаар ороогүй, зарим нь огт байхгүй.

⁶⁶ [Цагдаагийн байгууллага G7 24/7 цахим гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын сүлжээнд нэгдэн орлоо](#)

⁶⁷ [Цахим орчны хүүхэд хамгаалал | Харилцаа холбооны Зохицуулах Хороо](#)

⁶⁸ [Хүүхдийн тусламжийн утас 108 танилцуулга – Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв](#)

⁶⁹ Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам судалгааны тайлан УБ.,2021, [12].

- Ялын бодлогыг чангатгах. Дээрх үйлдлүүдэд оноох ялын бодлого сул байгаа нь шүүхээр орж, ял шийтгүүлсэн хэргүүдээс харагддаг.
- Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, мэдлэг мэдээллийг түгээх, санал гомдол хүлээн авах Үндэсний нэгдсэн цахим платформыг хөгжүүлж, олон нийтэд таниулах.
- Төрийн, төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагын хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, шинэ түвшинд гаргах шаардлага гарч байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс хамгаалах Олон Улсын Thorn байгууллагын 2022 онд гаргасан тайлан.
2. АНУ-ын Холбооны мөрдөх товчооноос Монгол Улсад зохион байгуулсан сургалтын материалууд Уб.,2024.
3. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан
4. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам судалгааны тайлан Уб.,2021.

Цахим эх сурвалж:

5. <https://108.mn>
6. <https://info.thorn.org>
7. <https://www.ice.gov>
8. <https://sherloc.unodc.org>
9. <https://police.gov.mn>
10. <https://shuukh.mn>
11. <https://crc.gov.mn>
12. <https://ekids.mn>

МОНГОЛ УЛС ДАХЬ ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ
ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН ШИНЖ, ИЛРЭХ ХЭЛБЭР
CURRENT SYMPTOMS AND FORM OF DETECTION
OF ORGANIZED CRIME IN MONGOLIA

Багтөмөр Мөнхбаяр
Докторант
Battumur Munkhbayar
Doctoral

Хураангуй. Зохион байгуулалттай гэмт хэрэг нь улс орны дотоод аюулгүй байдалд ноцтой хор аюул учруулдаг томоохон хүчин зүйл бөгөөд сүүлийн жилүүдэд үндэстэн дамнасан аюул эрсдэлийг бий болгож, улс орнуудаас хамтын ажиллагаа шаарддаг болсон байна.

Энэ нь дэлхийн нийтийн хэмжээнд нэг дэлхий хэмээх үзэл бий болсон өнөө үед ганцхан улс орны ард иргэдийг биш дэлхий нийтийг цочроосон элдэв гэмт хэрэг, аллага, терроризм заналхийлж байгаа нь зохион байгуулалттайгаар үйлдэгдэж буй гэмт явдал юм. Гэмт хэрэг зарим тохиолдолд зөвхөн тодорхой нэгэн хил хязгаарт хамаарагдах бус харин соёл урлаг, бизнес, улс төр, нийгмийг бүхэлд нь хамарч тэр ч бүү хэл олон улсын хэмжээнд хил хязгаарт үл захирагдан үйлдэгдэх болсон.

Abstract. Organized crime is a significant factor posing serious threats to the domestic security of countries and has recently created transnational risks, requiring cooperation between nations.

In today's world, where the concept of "one world" has emerged, it is no longer just the citizens of a single country who are affected; rather, the entire world is being shocked by various crimes, murders, and terrorism carried out in an organized manner. In some cases, crime is not confined to a specific border but encompasses culture, art, business, politics, and society as a whole, and is even perpetrated internationally without regard for borders.

Түлхүүр үг: Зохион байгуулалттай гэмт хэрэг, нэгдсэн үндэсний байгууллага, цагдаагийн байгууллага, хууль тогтоомж

Keywords: Organized crime, integrated national organizations, police organizations, and legislation

Нэг. Удиртгал.

Зохион байгуулалттай гэмт хэрэг нь улс орны дотоод аюулгүй байдалд хор аюул учруулдаг томоохон хүчин зүйл болсоор ирсэн бөгөөд өдгөө хүрээгээ тэлж үндэстэн дамнасан аюул эрсдэлийг бий болгож улс орнуудаас хамтын ажиллагаа шаардах болсон.

Социалист нийгэмд гэмт хэрэг байхгүй, тэр тусмаа зохион байгуулалттай гэмт хэрэг байх ёсгүй гэсэн зохиомол онол нь үйлдэгдэж буй гэмт хэрэг нийгмийн үзэгдлийг хуучин нийгмийн үлдэгдэл болгон энэ нь гагцхүү капиталист нийгэмд байх зүйл хэмээх тайлбарт төөрөгдөж явсан үе бий⁷⁰.

Хүн төрөлхтөн оршин тогтнохын тулд дайн дажин, байгалийн гамшиг, халдварт өвчин гэх мэт аюул, сүйрэлтэй цаг үргэлж тэмцэж ирсэн бол эдүгээ эдгээр бүх аюул, сүйрлийн жагсаалтыг учруулах хор аюулынхаа хэмжээгээр ЗБГХ тэргүүлэх төлөв ажиглагдаж байна. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйлийг олон улсын санхүү, мөнгөний зах зээл нээлттэй болсон, шинэ харилцаа холбоо, мэдээллийн систем дэлгэрсэн, интернэтийн сүлжээ асар хурдацтай өссөн зэрэг эерэг үр дагавар болон төр, засгийн эрх мэдэл, хяналтын хүрээ, бололцоо хумигдсан сөрөг үр дагавруудтай холбон эрдэмтэн, судлаачид тайлбарлаж байна.

XXI зуунд Дэлхийн нийтийн хэмжээнд нэг дэлхий хэмээх үзэл бий болсон өнөө үед ганцхан улс орны ард иргэдийг биш дэлхий нийтийг цочроосон элдэв гэмт хэрэг, аллага, терроризм

⁷⁰Д.Адъяабазар, З.Төрмандах. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс. Уб., 2005, 4 дэх тал

заналхийлж байгаа нь *зохион байгуулалттайгаар үйлдэгдэж буй гэмт явдал юм. Энэ нь олон улс орныг буюу үндэстэн дамнаж үйл ажиллагаагаа явуулан өргөжин тэлсээр байна.*

Гэмт хэрэг зарим тохиолдолд зөвхөн тодорхой нэгэн хил хязгаарт хамаарагдах бус харин соёл урлаг, бизнес, улс төр, нийгмийг бүхэлд нь хамарч тэр ч бүү хэл олон улсын хэмжээнд хил хязгаарт үл захирагдан үйлдэгдэх болсон. Мэдээж ингэхэд сайтар зохион байгуулагдсан байх нь чухал. Нөгөө талаар гэмт хэрэг нь эдийн засгийн хүрээний нэг хэсэг болон тогтдог бөгөөд зарим хүмүүсийн амьдралын хэв загвар, эх үүсвэр нь болсон байдаг.

Түүхийн хуудсыг эргэн сөхөхөд хүний нийгмийн амьдралын бүхий л үеийн туршид гэмт хэрэг нь олон янзын хэлбэрээр оршин тогтнож байсан ба түүнийг зөвхөн ганц этгээд төдийгүй хэсэг бүлэг хүмүүсээс маш нарийн зохион байгуулалттайгаар үйлдэж иржээ.

Эртний цааз хуулиудад гэмт хэрэг ганцаараа болон бүлэглэн үйлдсэн тохиолдлыг дурдсан эх сурвалжуудыг авч үзлээ. Үүнд:

Алтан хааны цаазад: “...Хулгайчийн алж идсэний үлдэгдлийг авбал тавтаар торгох”-оор заасан нь үлдэгдлийг авсан хүнийг ямар нэгэн хэмжээгээр хулгайд оролцсон гэж үзсэн нь гэмт хэрэгт хамтран оролцох явдлаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой заалт гэж үзэж болохоор байна.

Монгол-Ойрадын Их цаазад: 95-р зүйлд “...Олон цөөн хүн отоож хулгай хийж хойно нь нэг нь ирж хэлбэл нэг нь ялгүй, бусдаас нь гүйцээж ав, хүн мэдсэн хойно нь хэлбэл тусгүй” гэж заажээ. Үүнээс үзэхэд гэмт хэрэгт бүлэглэн оролцсон боловч сайн дураараа хэргээ илчлэн ирсэн тохиолдолд ялаас хэлтрүүлэх ил болсон үед мэдээлэх нь хэргийн хариуцлагаас мултрах оролдлого болох заалт оруулсан нь тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт: “...Олон газар аливаа хүн уулгалж булаах, огт хүнийг хор хийсэн үгүй эд олсон нь хулгайн тоо 3 хүнээс дээш болвоос тэргүүлсэн ялт хүнийг улсын хязгаар дор цөл, дэд ялт хүнийг аймаг алгасаж цөл, хэрэв 4 хүнээс дээш 9 хүн дор хүрвээс тэргүүн дэдийг үл бодон цөм улсын хязгаарт цөлж бүрнээ зовоох албанд явуул.

Цугласан хоршоо 10 хүнээс дээш болвоос хүнийг хор хийсэн ба эс хийснийг үл бодон тэргүүлсэн ялт хүнийг буудан алах ял оноож тэр дор нь буудан алах. Эд олсон үгүй санаа өдсөн ялт хүнийг тайжаас байлгаж 100 ташуурдан жанч. Бүгдээр үгсэх нь болвоос хамтаар явсан ба эс явсныг үл бодон тайжаас байлгаж цөм үүрд тахиулах үгүй бологтун” гэжээ. Энэ хуулиас үзвэл ял шийтгэлийг ялгамжтай оногдуулж гэмт хэргийг зохион байгуулсан, голлон үйлдсэн этгээдийг *тэргүүн*, хамжигчаар оролцсон этгээдийг *дэд* гэж нэрлэж байжээ. Өмнөх хуулиудын адил зохион байгуулалттай гэмт хэрэг гэсэн ойлголт тусгагдаагүй байна.

Хоёр. Зохион байгуулалттай гэмт хэргийн онолын үндэс

Монгол оронд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар төр, засгаас холбогдох арга хэмжээнүүдийг авч, хууль, тогтоомжуудыг батлан мөрдөж байгаагийн зэрэгцээ эрдэмтэн, судлаачид Орос хэлээр “Организованная преступность” гэдэг үгийг Монгол хэлнээ “Зохион байгуулалттай гэмт явдал” хэмээн нэршиж, өөр өөрсдийн үзэл бодол, байр сууриа илэрхийлж, холбогдох дүгнэлт тодорхойлолтыг өгсөн байна.

ЗБГХ гэсэн ойлголтыг Монгол эрдэмтэн судлаачдын тодорхойлолтуудыг авч үзвэл: Уг асуудлыг хэрхэн тодорхойлсныг харьцуулан үзэх нь зохион байгуулалттай гэмт хэргийн мөн чанар, нийгмийн хор аюулыг үнэлэхэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Академич С.Нарангэрэл: “Зохион байгуулалттай гэмт явдал” бүтээлдээ дурдахдаа “...Зохион байгуулалттай гэмт явдлыг дэлхийн улс орнуудад янз янзаар тодорхойлж байгаа боловч нийтлэг шинж байдаг талаар тэмдэглэсэн. Зөвлөлтийн албан ёсны эх сурвалжаас үзвэл үйлдвэрлэлийн хэлбэрээр гэмт үйл ажиллагаа явуулж худалдан авах, коррупцийн тусламжтайгаар өөрсдийн аюулгүй байдлаа хангахыг эрмэлздэг бүлгүүдийн хоорондын янз бүрийн шинжтэй хэлхээс холбооны нарийн шинжтэй систем юм.

АНУ-ын Холбооны хууль тогтоомжид зохион байгуулалттай гэмт хэргийг хууль бус бараа таваар нийлүүлэх хууль бус үйлчилгээ үзүүлэх тухайлбал хар тамхи мансууруулах бодис борлуулах, мөрийтэй тоглоом, янхны газар, рэкет ажиллуулах зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй зэрэг нийгэмлэг нэгдлийн гишүүдийн өндөр зохион байгуулалттай сахилгатай хууль зөрчсөн үйл ажиллагааг заасан байна” хэмээжээ.

С.Нарангэрэл гэмт бүлэглэл, байгууллагын талаар: “...Гэмт бүлэглэл, байгууллага нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэхийн тулд буй болж нягтаршсан ба зохион байгуулалттай гэмт бүлэг мөн, бүлэглэлийн нягтаршсан байдал нь гэмт хэргийн ашиг орлогоос татварын нэгдмэл сан бий болгож материалын талаар хангагдахаас гадна тагнан турших, лоббидох, хахуульдах, нууц явуулга хийх тусгай хэсэгтэй хоорондын харилцааны хатуу дэг жаягтай, бүлэглэлийн бичигдээгүй дүрмийг зөрчихөд хатуу шийтгэлтэй. Эд хөрөнгө ба эрх мэдэл эзэмшихийн төлөө чармайсан, босоо шатлан захирах дэг ёстой хууль сахиулах төр засгийн бүтэцтэй хөдөлгөөнөөр харилцан ажиллах зэрэг шинжээр илэрдэг юм” гэж тодорхойлсон байна⁷¹.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Н.Жанцан: Зохион байгуулалттай гэмт явдалд байх үндсэн шинжийг дараах байдлаар тодорхойлжээ. “...Хамгийн чухал шинж нь гэмт хэрэг үйлдэхээр тохирч нэгдсэн тодорхой хүмүүс нь гэмт хэргийн замд тогтвортой орсон байна. Тэд өөрийн гэсэн хатуу журам сахилгатай, өөрсдийн удирдлагуудаасаа хараат, тэднийгээ хаяж, зайлж явах боломжгүй болсон байна. Гэмт бүлэглэлд оролцож байгаа хүмүүсийн тоо амьдрал дээр 5-аас доошгүй дээд хэмжээ нь хэдэн 100 хүн хүртэл хамрагдах тохиолдол байна. Тэдний бүтэц зохион байгуулалт нь чухам ямар төрлийн гэмт хэргийг ямар салбарт үйлдэх гэж байгаагаас хамаарч өөр өөр байдаг. Ихэнх тохиолдолд гэмт бүлэглэлийн гишүүд өөр өөрсдийн үүрэг ролийг сайн мэдэж байдаг” хэмээв.

Хууль зүйн доктор, процессор Д.Адъяабазар Мафи /Гэмт байгууллага/ бүтээлдээ: “...Зохион байгуулалттай гэмт явдал гэдгийг нийгмийн хууль ёсны хяналтаас өөрсдийгөө хамгаалах зорилгоор авлигад автагдсан этгээдийн тусламжтайгаар хяналтын эсрэг, сөрөг үйл ажиллагааг явуулж байгаа, хамгаалах систем бүхий, гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгосон, тогтвортой, шаталсан бүтэцтэй гэмт этгээдүүдийн нэгдэл үүсгэн гэмт үйл ажиллагаа явуулахыг хэлнэ” гэж тодорхойлжээ⁷².

Гадаадын эрдэмтэн судлаачдын тодорхойлолтыг авч үзвэл: Сүүлийн үед олон улсын хэмжээнд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх талаар улс орнууд эрх зүйн бодлогоо нэгтгэн тодорхойлж, хамтран тэмцэх болсон. Зохион байгуулалттай гэмт хэргийн талаар эрдэмтэн, судлаачид өөр өөрсдийн санал, дүгнэлт, тодорхойлолтоо өгсөөр байна.

ОХУ-ын эрдэмтэн В.Ярочкин “...Зохион байгуулалттай гэмт явдал нь гэмт хэргийн ертөнцийн тогтсон хатуу бүтцээс хэрэгжүүлж буй тодорхой гэмт үйлдлийн цогцолбор” гэж тодорхойлсон бол **А.Н.Гуров** “...Зохион байгуулалттай гэмт явдал гэдэг нь нийгмийн хэмжээний гэмт үзэгдлийн гэмт үйл ажиллагааг ажил (бизнес) болгон эрхэлдэг, авлига ба бусад хамгаалах хэрэгслийн тусламжтайгаар нийгмийн хяналтаас хамгаалах системийг бий болгож, харьцангуй өргөн олныг хамарсан ажиллагаа явуулдаг тогтвортой удирдлагатай бүлэглэл гэж ойлгож болно⁷³” гэжээ.

ОХУ-ын эрдэмтэн Гриб В.Г, Ларичев В.Д нар “...Зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааны зорилго нь хамгийн аюулгүй аргаар үлэмж хэмжээний ашиг олоход чиглэнэ. Чухам энэхүү зорилго нь түүндээ хүрэх арга, хэрэгслээ тодорхойлдог ба уг зорилгод хүрэх нэг хэрэглүүр нь зохион байгуулалттай байх явдал” гэж үзжээ.

Паул Лунде “Зохион байгуулалттай гэмт хэрэг” сэдэвт бүтээлдээ: “...ЗБГХ-ийн тодорхойлолтыг олон тооны хууль хяналтын байгууллагууд болон бусад газрууд хийсэн ба тэд бүтд өөр байдаг нь уг гэмт хэргийн бүлэглэлүүдийн үйл ажиллагаа нь маш өргөн цар хүрээтэй, олон тооны аргачлалыг ашигладаг, орон нутаг, улсын онцлогоос шалтгаалан ондоо байдаг ба зах зээлийн өөрчлөлт, хууль зүйн орчин зэрэгт дээд зэргээр зохицож үйл ажиллагааны хэлбэрээ ямагт сайжруулдагтай холбоотой юм.

Зарим хуулийн байгууллагууд нь зохион байгуулалттай гэмт шунахай сэдэлтээс үүсэлтэй айлган сүрдүүлэлт болон авлига дагалдсан, нарийн зохион байгуулалттай, тогтмол нууцлаг байдалд явагдах хууль бус ажиллагаа” гэж тодорхойлдог гэжээ.

АНУ-ын криминологи судлаач Ховард Абадинскийн тодорхойлсноор: “...ЗБГХ-ийн бүлэглэл нь хууль бус аргаар болон хуулийн дагуу ашиг хонжоо болон эрх мэдэл олох гэсэн хүмүүсийн идеологийн бус нэгдэл” гэжээ. Энэхүү нэгдэл 3 доошгүй зохион байгуулалтын төвшинтэй. Гишүүд нь хоорондоо хамаатан

⁷¹Д. Адъяабазар, З.Төрмандах.Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс. УБ., 2005, 6 дахь тал

⁷²Д.Адъяабазар. Мафи-Гэмт байгууллага”. УБ, 1999

⁷³В.Ярочкин. Зохион байгуулалттай гэмт явдал, аюул хаанаас нүүрлэж байна. УБ., 2005, 7 дахь тал

садан болон найз байх нь элбэг. Бүлэглэлд эзлэх байр суурь, үүрэг нь мэдлэг чадварын дагуу оногддог. Тэдгээр нь тодорхой салбар газарт монополь байр суурьтай болохыг эрмэлздэг ба үүний төлөө хүч хэрэглэх буюу авлигал хэрэглэдэг. Дотроо маш нарийн зохион байгуулалт болон сахилга баттай, тодорхой үйлдлүүд дээрээ гишүүн биш хүмүүсийг бас ашигладаг. Бичигдсэн эсвэл аман дүрэм журамтай ба тэдгээрийг зөрчсөн тохиолдолд алах хүртэл шийтгэлтэй” гэж тодорхойлсон бол Америкийн Коза Ностра мафийн тодорхойлолт ба италийн Сицилийн мафи нар мөн адил зохион байгуулалттай⁷⁴ гэсэн байна.

НҮБ-ын 2000 оны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдтэй тэмцэх тунхаглалд “*ашиг хонжоо олохын тулд гурав буюу түнээс дээш тооны хүмүүсийн зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэхийг бэлдэх*”⁷⁵ гэж тодорхойлсон байна.

ЗБГХ гэсэн нэр томьёо нь эрүүгийн эрх зүйн онол болоод практикт өөр, өөр утга агуулгаар хэрэглэгдэж ирсэн. Учир нь практикт аливаа нэг гэмт хэргийг хэд хэдэн этгээд нарийн зохион байгуулж үйлдсэн тохиолдолд үүнийг “зохион байгуулалттай гэмт хэрэг” гэж нэгэн адил нэрлэж заншсан байдаг.

ЗБГХ-ийн (бүлэг, бүлэглэл) талаар эрдэмтэн судлаачдын тодорхойлолтоос нийтлэг шинжүүдийг дурдвал:

- Тодорхой гэмт хэргийг үйлдэхээр урьдчилан үгсэн тохирч нэгдэн, нягтаршсан байна
- Удирдан чиглүүлдэг удирдагчтай
- Байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулдаг
- Гэмт үйл ажиллагааг орлогын эх үүсвэр болгодог
- Тодорхой хуримтлалтай
- Хатуу, дэгтэй
- Гэмт үйл ажиллагааны чиглэл нь төрөл бүрийн салбарт явагдах чадвартай
- Улс төр, хууль хяналтын байгууллагад нөлөөлөх
- Өөрсдийгөө хамгаалах системтэй
- Гэмт үйлдэл нь улс орон, үндэстэн дамнаж үйл ажиллагаа явуулах өргөн цар хүрээтэй явагддаг гэх мэт нийтлэг шинжүүдтэй байна.

Гурав. Зохион байгуулалттай гэмт хэргийн шинж, онцлог

Эрдэмтэн, судлаачид зохион байгуулалттай гэмт бүтцийн үүсэх нөхцөл, шалтгаан, хөгжлийн үе шатны талаар зохих судалгаануудыг хийсэн байдаг.

ОХУ-ын судлаач А.Н.Гуров нь зохион байгуулалттай гэмт явдлын үүсэл хөгжлийн үе шатыг дараах түвшинд авч үзсэн байна.

- энгийн түвшний,
- дунд түвшний,
- дээд (өндөр) түвшний хэмээн ангилсан.

АНУ-ын судлаач Питер Латиа нь зохион байгуулалттай гэмт явдлын хөгжлийн үе шатыг

- Нөлөөгөө тогтоох хэрцгийллийн үе,
- Нөлөөгөө бэхжүүлэх шимэгчийн үе,
- Симбиотик буюу харилцан хамаарлын үе гэж тус тус ангилаад үе шат тус бүрийн гэмт явдлын шинжийг тодорхойлсон байна.

ЗБГХ-ийг хэн, ямар зохион байгуулалтаар үйлдэх нь урьдчилан үгсэн нэгдэж, үе шаттай хэрэгждэгийг тодорхойлсон гадаад, дотоодын судлаачдын тайлбараас үзэхэд дотоод зохион байгуулалт, дэс дарааллыг бүхэлд нь ойлгох “**сүлжээ**” хэлбэрээр авч үзэх шаардлагатай болж байна.

Энэ нь ерөнхий шинж нь нийтлэг боловч ямар гэмт хэргийг үйлдэхээр, ямар нөхцөлд зохион байгуулагдсан болон түүний дотоод бүтэц, гишүүний тоо, үйл ажиллагааны хүчин чадал, цар хүрээ,

⁷⁴Паул Лунде. Зохион байгуулалттай гэмт хэрэг. 2004.

⁷⁵НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенц. 2000

нийгэмд эзлэх байр суурь тогтвортой байдал, төрийн байгууллагаас болон хуулийн байгууллагаас хамгаалсан хамгаалалтын хэр хэмжээ зэрэг шалгуураар хамгийн энгийн нэгжээс өндөр зохион байгуулагдсан байна. Үүнд:

- Зохион байгуулалттай бүлэг⁷⁶
- Зохион байгуулалттай бүлэглэл⁷⁷
- Зохион байгуулалттай гэмт сүлжээ буюу байгууллага⁷⁸ гэж гурван төрөлд ангилж үзвэл чухал ач холбогдолтой гэсэн байна.

Зохион байгуулалттай гэмт хэргийн зохион байгуулалт, сүлжээний элементүүдийн тус бүрийнх нь шинжийг тодорхойлбол:

Зохион байгуулалттай гэмт бүлэг: Тэд гэмт үйл ажиллагаагаа харьцангуй тогтвортой эрхэлж орлогын эх үүсвэр болгох зорилгоор урьдчилан нэгдэж зохион байгуулагдсан байх. Гүйцэтгэх үүргээ тодорхой хуваарилж түүндээ зохицсон бүтэц, зохион байгуулалт, удирдлагатай /босстой/ байх. Хамаатан садан, найз нөхөд, үзэл бодлын болон орон нутгийн холбоо, цуг гэмт хэрэг үйлдсэн буюу хамт ял эдэлж байсан зэрэг харилцаа холбоонд нэгдэн тулгуурладаг байх. Гэмт хэрэг үйлдсэн эсхүл үл хамааран оролцогчид нь байнга холбоо хамтын ажиллагаатай байх зэрэг үндсэн шинжийг агуулдаг.

Зохион байгуулалттай гэмт бүлэг нь бүтцийн хувьд хамгийн энгийн зохион байгуулалттай төрөл юм. Зохион байгуулалттай бүлэг урьдчилан тохиролцсон бүлэг этгээдээс ялгагдах гол шинж нь бүлгийн гишүүд гэмт хэрэг үйлдэх явдлыг орлогын эх үүсвэр болгох зорилгоор урьдчилан нэгдэж, зохион байгуулалтад орсон байхаас гадна энэхүү үйл ажиллагаагаа тогтвортой эрхлэх зорилготой байна.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл: Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь зохион байгуулалттай гэмт бүлэгтэй харьцуулахад хууль сахиулах болон төрийн албан тушаалтнуудын оролцоотой, нийгмийн салбаруудад хамрах цар хүрээ, бүтэц, зохион байгуулалт, техникжилт зэрэг байдлаараа арай өндөр түвшинд зохион байгуулагддаг онцлогтой.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь:

- Гэмт хэргийн ертөнцөд нөлөө бүхий удирдагчтай байх
- Хяналт тогтоосон нутаг дэвсгэрийн хүрээнд гэмт үйл ажиллагаа эрхэлдэг байх
- Өөрсдийгөө хамгаалах зэвсэг бүхий цэрэгжсэн тусгай бүлэгтэй байх
- Төрийн зарим байгууллагад өөрсдийн талд ажиллах нөлөө бүхий ажилтан, албан хаагчтай байх зэрэг үндсэн шинжтэй.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь үйл ажиллагааны хамрах цар хүрээ, оршин тогтнох хугацаа, төрийн эсрэг гэмт хэрэг төдийлөн туйлбартай эрхэлдэггүй шинжээрээ зохион байгуулалттай гэмт байгууллага буюу мафиас ялгагддаг.

Зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэлүүдийг бие даасан байдлаар нь мафи зохион байгуулалтын хэмжээнд авч үзэх боломжгүй юм. Зохион байгуулалттай гэмт хэрэгтнүүд бодол санаагаа ихэвчлэн хууль бус гэмт арга замаар хэрэгжүүлдэг учир хамгийн их эрсдэлтэй бизнес эрхэлдэг.

Зохион байгуулалттай гэмт сүлжээ буюу байгууллага: Гэмт сүлжээ буюу байгууллагад дараах үндсэн шинж байдаг.

- Материаллаг бааз нэгдсэн мөнгөний фонд банкны тооцоотой байна.
- Хамтын үйлдвэр хоршоо, ресторан, казино гэх мэтийг эзэмшилдээ авсан байх ба түүний орлого, санхүүжилт нь удирдлагадаа заавал мэдээлэгдэж хянагдаж байна.

⁷⁶“Гэмт үйл ажиллагаа эрхлэх замаар тогтмол ашиг олох зорилгоор зохион байгуулагдсан хоёр буюу түүнээс дээш хүмүүсийн хууль бус нэгдэл”

⁷⁷Хууль зүйн ухааны доктор Н.Жанцан. “...Гэмт бүлэглэл нь /байгууллага нь/ хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэхийн тулд буй болсон нягтарсан ба зохион байгуулалттай бүлэг мөн”...бидний үзэж байгаагаар гэмт бүлэглэл нь зохион байгуулалттай бүлгээс илүү нягтарсан ба хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэх зорилготой байдаг онцлогоороо ялгагдана гэжээ.

⁷⁸“Зохион байгуулалттай гэмт бүлгийн хамгийн дээд түвшинд зохион байгуулагдсан хэлбэр юм”.

- Гэмт байгууллага нь удирдах бүрэлдэхүүнтэй/зөвлөл/ байна. Тэр нь хамтын удирдлагын байгууллага байх ба гишүүд нь ихэвчлэн тэгш эрхтэй байна.
- Өөрсдийн дунд тогтоосон хатуу дүрэм, журам, тангарагтай. Зарим тохиолдолд энэ нь бичгийн хэлбэртэй харилцан зөвшөөрч баталгаажсан байна. Удирдлагын системтэй, зарим тохиолдолд салбар удирдлагатай, тэднийг тодорхой чиг үүрэгтэй бүлгүүдэд хуваасан мэдээллийн болон хяналтын албатай байдаг.
- Өөрсдийн дунд ойлголцох дохио болон хэллэгтэй байна.
- Мэдээллийн баазтай тагнуулын болон сөрөг тагнуулын мэдээлэл цуглуулагчтай байна.
- Өөрсдийн гэсэн төлөөний хүнийг засаглалын болон хууль хяналтын байгууллагад ажиллуулсан байх. Эдгээр шинж гэмт байгууллага буюу мафид ихэвчлэн бүрэн хэмжээгээр байдаг болох нь судалгаагаар тогтоогдсон байна

Гэмт байгууллага нь хэд хэдэн гэмт бүлэглэлийг өөртөө нэгтгэдэг. Дээрх ангиллын “Зохион байгуулалттай гэмт байгууллага” нь мафи гэсэн томъёололтой утга дүйх шинжийг⁷⁹ агуулдаг.

Зохион байгуулалттай гэмт сүлжээний оролцогчдыг гүйцэтгэх үүргээс нь хамаарч дараах хэсгүүдэд ангилж болно. Үүнд:

Гүйцэтгэгчид: -Энд зөвхөн тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэгчид шууд хамаарна. Өөрөөр хэлбэл гэмт хэргийг гардан үйлдэгчид энэхүү ойлголтод хамрагдана. Тэд заавал гэмт бүлгийн гишүүн байх албагүй байдаг /нэгдэл нь тогтвортой биш/.

Гэмт сүлжээний гишүүд болон оролцогчид: Энэхүү ойлголтод хууль бусаар үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид хориотой эд зүйлийн наймаачид төдийгүй гэмт бүлгийн /тодорхой төрлийн гэмт хэрэг үйлддэг/ мэргэжлийн гэмт хэрэгтнүүд, эрүүгийн элементүүд багтана.

Холбох хэсэг: Ихэвчлэн гэмт бүлгийн толгойлогч нар болон түүний бие төлөөний хүмүүс байх ба гэмт бүлэглэлийн удирдлагын шийдвэр биелүүлэх, гэмт хэргийг гардан гүйцэтгэгчийг хянах, гэмт бүлэглэлийн дотоод бүтцийн нэгж хэсэг болох зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн хоорондын маргаантай асуудлуудыг шийдвэрлэх, бүлэг хоорондыг мэдээллээр хангах тус нутаг дэвсгэрийн болон бусад зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй харилцаа холбоо тогтоох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Нэгэн ёсондоо менежерийн үүрэг гүйцэтгэдэг.

Хамгаалах хэсэг: Энд авлигад автагдсан төрийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчийн өгсөн мэдээлэл, тусалцааны дагуу гэмт бүлэг, бүлэглэлийг хамгаалах, гишүүдийг эрүүгийн хариуцлагад татуулахгүй байх үүднээс сөрөг тагнуул хийх, хууль хамгаалах болон бусад гэмт бүлэг, бүлэглэлийн сонирхлыг татаж буй хүрээ, салбарын үйл ажиллагааны талаар мэдээлэл олж авах, тагнуул хийх алба хамаарна.

Ихэвчлэн хүчний болон хууль сахиулах байгууллагаас гарсан, хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэх ажиллагаатай холбоо бүхий хүмүүсийн бүлгийн /хамгаалах хэсгийн/ удирдагч хамаарна. Түүнчлэн тэдгээр хүмүүстэй: Гэмт хэргийн ертөнцөд нэр нөлөө бүхий гэмт хэрэгт, нарийн мэргэжилтэн, өөрөөр хэлбэл шинжлэх ухааны тодорхой салбарт мэргэшсэн этгээд. Жишээлбэл: эдийн засгийн ухааны мэргэжилтэн банк, санхүүгийн луйвар, хийх, авлигад автагдсан төрийн ажилтан, албан хаагчид тэд зөвхөн бүлгийн сонирхол татаж буй асуудлыг талаар мэдээ, мэдээлэл өгдөг. Гүйцэтгэгчид өөрөөр хэлбэл, тодорхой төрлийн гэмт хэргийг гардан гүйцэтгэгчид нягт хамтран ажилладаг.

Дөрөв. Зохион байгуулалттай гэмт хэргийн нийгмийн хор аюул:

Зохион байгуулалттай гэмт хэргийг Монгол улсын одоогийн улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай шууд холбон үзэх нь зүйтэй болов уу. Энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлж буй хүчин зүйлийг дотоод, гадаад, эдийн засгийн, нийгмийн, улс төрийн гэж авч үзэж болно. Үүнд:

Эдийн засгийн хүчин зүйл:

⁷⁹Д.Адъяабазар. Мафи-Гэмт байгууллага. УБ., 1999

- Аж ахуй, санхүүгийн салбарт хүндрэл, тогтворгүй байдал
- Буруу, алдаатай хувьчлалын сөрөг үр дагавар
- Баян, хоосны туйлын ялгарал
- Импорт экспортоос давамгайлсан байдал
- Инфляцын хэлбэлзэл /өсөлт, бууралт/
- Уул уурхай, стратегийн орд газруудыг тойрсон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт
- Сүүлийн жилүүдэд гарсан томоохон бонд, хөтөлбөр, түүнийг дагасан хөрөнгө оруулалт, зарцуулалт
- Төсвийн оновчгүй төлөвлөлт, хөрөнгийн үр дүнгүй зарлага, зарцуулалт, ашиг хонжоо хайх байдал
- Хөрш орнуудаас хүнс, эд материал, бусад түүхий эдийн хамааралтай байдал
- Бусад

Нийгмийн хүчин зүйл:

- Иргэдийн нийгмийн хамгааллын дорой, хүртээмжгүй байдал
- Хөдөөгөөс хот суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн /зохиомол хотжилт/
- Нийслэл дэх хүн амын хэт бөөгнөрөл
- Нийт хүн амын ажилгүйдэл, ядуурал, түүнтэй холбоотой иргэдийн бухимдал
- Ажиллах хүчний хомсдол бий болж, хөдөлмөрлөх насны иргэд гадаад оронд амьдрах шилжилт хөдөлгөөний байдал
- Нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн хэмжээний акт, хууль, журам алсыг харсан стандартгүй, хувьсаж өөрчлөгдөж байгаа байдал
- Мал, аж ахуй хөдөөгийн амьдралын цорын ганц эх сурвалж болсон байдал
- Архидан согтуурал ба мансуурал ихэссэн байдал
- Иргэдийн сахилга, хариуцлага алдагдсан байдал /залуу үе/
- Цахим орчны шүүлтүүргүй мэдээлэл, хэрэглээ нэмэгдсэн, аюулгүй байдал алдагдсан байдал

Улс төрийн хүчин зүйл:

- Улс төрийн засаглалын тогтворгүй байдал, талцал, хуваагдал, үзэл баримтлал тодорхойгүй, хувьсамтгай байдал
- Гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдсэн төрийн тууштай хатуу бодлогогүй байдал
- Улс төрийн хүрээний авлига хавтгайрсан байдал
- Төрд итгэх иргэдийн итгэл алдарсан зэрэг болно.

Эдгээр бэрхшээлүүд нь зохион байгуулалттай гэмт явдал үүсэж, хөгжих дотоод нөхцөл, шалтгаан, хөрс суурь болдог. Зохион байгуулалттай гэмт явдал үүсэж, хөгжих нөхцөл, шалтгааныг саармагжуулах, арилгах талаар тодорхой арга хэмжээ авахгүй бол хөгжиж буй шатандаа яваа улс, орнууд зохион байгуулалттай гэмт явдлын эрхшээлд орох аюул нүүрлэж эхэлнэ.

Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас тагталзан, зах зээлийн эдийн засагтай эрх зүйт улс болон хөгжих болсноор эдүгээ даяаршлын үйл явц хөгжлийн олон шинэ боломжийг нээж өгсний сацуу үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг нэвтрэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсад гэмт хэргийн тоо жилээс жилд өсөж, гэмт явдлын бүтцэд хүнд хэргийн эзлэх хувийн жин нэмэгдсэн, гэмт хэрэгтнүүдийн шинэ, залуу үе буй болж, мэргэших хандлага ажиглагдаж байгаа зэрэг нь гэмт хэрэг зохион байгуулалттайгаар үйлдэгдэх, зохион байгуулалттай гэмт хэрэг үүсэж бүрэлдэх хүчин зүйл болж байна.

Зохион байгуулалттай гэмт хэрэг ямар ч хил хязгаар, нийгмийн соёл, иргэншлээр хязгаарлагддаггүйд аюул нь оршиж байгааг энэ чиглэлийн эрдэмтэн судлаачид санал нэгтэй баталдаг.

Өнгөц харвал зохион байгуулалттай гэмт хэрэг Монгол улсыг зовоох хэмжээнд хүрээгүй гэсэн сэтгэгдэл төрүүлж болох ч үндэстэн дамнасан гэмт хэргээс ангид байх нэг ч улс, үндэстэн гэж байхгүй болсон бөгөөд “аюул, занал төрүүлэхгүй” байгаа нь зохион байгуулалттай гэмт сүлжээ хүчирхэг байгаа, өөрийгөө нийгэмд “энгийн ердийн, байх ёстой зүйл” мэтээр хүлээн зөвшөөрүүлж чадсан, түүнд нийгмийн идэвхтэй, ухамсар бүхий хэсгийн нөлөө бүхий олонх нь нэгдсэнийг илтгэх шинж байдгийг бид иш үндэс болгов.

Якуза нар Монгол улсыг бизнес хийхэд хамгийн ашигтай байж болох юм гэж үзсэн нь гайхах зүйлгүй. Монгол улсад Якуза аюул заналхийлэл үзүүлнэ гэдэгт эргэлзэж байгаа ч аюул хаа нэгтэй байж л таарна гэж гадаадын мэргэжилтэн үзсэн нь нэгийг өгүүлж байна⁸⁰.

Зохион байгуулалттай гэмт хэргийн зохион байгуулалтын сүлжээ Монгол улсад нэгэнт буй болж, үйл ажиллагааны нэг хэсэг нь төр засгийн эрх мэдэл, хяналттай өрсөлдөх, нөгөө нь доод нэгжээс буюу бүлгийн зохион байгуулалтын шинжийг агуулж идэвхэжсэн. Тэдний үйл ажиллагаа, чиглэл тус тусдаа боловч, эцэстээ хүчирхэгжсэн нэгний санаа зорилгыг биелүүлэхэд нэгдэж хоорондын харилцаа хамаарал нь ашиг хонжоо хайх, нийгмийн аюул заналыг нэмэгдүүлэх, иргэдийн санаа бодол, үзэл сурталд нөлөөлөх, аль нэг талд ашигтай шийдвэр гаргуулах байдлаар илрэн гарах нөхцөл байдлыг бүрдсэн байна.

Тав. Зохион байгуулалттай гэмт хэргийн Монгол улс дахь өнөөгийн байдал

Сүүлийн үед зохион байгуулалттайгаар үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдээс үзэхэд хар тамхи, хүн худалдаалах, хүн хулгайлах, түүх соёлын дурсгалт зүйлсийн хууль бус эргэлт, автомашины хулгайн гэмт хэргүүд нь хэд, хэдэн улс дамжсан, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй болсон байна. Манай улсад гадаадын зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл нэвтрэн орсон, Монгол улсын иргэд тэдний хууль бус үйл ажиллагаанд татагдан оролцоогүй гэх баталгаа байхгүй байна.

Хуучин бидний ойлгож, нэрлэж заншсан эрүүгийн хуульд заасан уламжлалт гэмт хэрэг үйлдэж байгаа эрүүгийн гэмт хэрэгтнүүдээс бүрдсэн зохион байгуулалттай бүлгүүдээс гадна нам, групп, компани, байгууллага, ах дүү, хамаатан садан, нутаг нуга зэрэг зохион байгуулалтын хэлбэрээсээ шалтгаалан эдгээр харилцаагаа хууль бус аргаар мөнгө олоход чиглүүлэн ашиглаж байгаа нь Монгол Улсын нийгэмд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, сүлжээ хэлбэршлээ олж, Монгол Улсын онцлогыг илтгэх цөөн хүн амтай, хот суурин газраа илүүтэйгээр нягтарсан, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, зан заншил, соёл, иргэншлийн онцлогтой уялдан өвөрмөц хэлбэрээр оршин тогтнож, хөгжиж байна гэж дүгнэж болохоор байна.

Шинэ үеийн бүлэглэлүүд нь ашигт малтмал, газрын наймаа, төрөл бүрийн тендер, төрийн зөвшөөрлийн системийн үйл ажиллагаа, төсөвт бараа шахах, мөрийтэй тоглоом, банк санаатайгаар дампууруулах зэрэг гэмт хэргүүд үйлдэн хурдан ашиг олох чиглэлд анхаарлаа чиглүүлж олсон орлогоо хууль ёсны болгож угаах, татвараас зайлсхийх чиглэлээр ажиллах хандлагатай байна. Энэ бүгдтэй тэмцэх ажиллагааг шинэ шатанд гаргахад улс төр, эдийн засгийн шийдвэр, гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, хууль хяналтын байгууллагуудын ажиллах нөхцөлийг сайжруулах шаардлагатай үүсэж байна.

Тухайлбал: Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа үндсэрхэг үзэлтэй гэгдэх бүлэг, хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа, зорилго нь онолын хувьд тодорхойлсон “эх оронч, үндэсний үзэл”-ээс илүүтэйгээр эдийн засгийн ашиг сонирхолд чиглэсэн үйл ажиллагааг хууль бус үйлдэл, гэмт явдлын хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Хэт үндсэрхэг үзэлтэй бүлгэм, хөдөлгөөнүүд нь өөрсдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах үүднээс улс төр, бизнес, эрүүгийн гэмт хэрэгтнүүдийн хууль бус үйл ажиллагаа, нөлөөнд орох, тэдний дунд төлөөлөлтэй болох, эвлэлдэн нэгдэж улс төрийн аль нэг хүчний доор нэгдэх сонирхолтой байгаагийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэлийн шинжтэй болж нэгдэх процесст орсон байна.

Жишээлбэл: Сүүлийн үед идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг “Б” нэртэй үндсэрхэг үзэлтэй төрийн байгууллага нь улс орон даяар 2000 орчим дэмжигч, гишүүнтэй тооцоолол байдаг ба гишүүдийг насны байдлаар нь авч үзвэл 30 хувийг 18-25 насны, 45 хувийг 25-35 насны, 15 хувийг 35-50 насныхан тус тус эзэлдэг.

Үндсэрхэг үзэлтэй этгээдүүдийн зүгээс ЭХТА-ийн 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 17.6 дугаар зүйл /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/ гэмт хэргийг ихээр үйлддэг бөгөөд Эрүүгийн

⁸⁰Дэвид Е.Каплан, Алек Дүбрө. “Якуза” Вашингтон. 1986, 2 дахь тал (Орчуулсан Д.Бадрал, ред Ж.Буянбат)

хуулийн ерөнхий ангийн 3,8 дугаар зүйл /Зохион байгуулалттай гэмт бүлэг/-д заасан /Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг гэнэ/ шинжийг агуулж байна.

Гэмт хэргийн жишээ дурдахад: “Д” төрийн бус байгууллагын тэргүүн “Б” нь бусадтай бүлэглэн Монгол улсаа хамгаалъя гэх халхавчаар хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нөхөрлөл, уул уурхайн компанийн үйл ажиллагаанд хууль бусаар хөндлөнгөөс оролцож их хэмжээний мөнгө өгөхийг удаа дараа шаардан айлган сүрдүүлж, дарамтлан заналхийлсэн үйлдэлд холбогдох шалгалтын ажиллагаа явуулсан үйлдэл 2019 оны оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.6 дугаар зүйлийн 2 дэх хэсгийн 2.1 дэх заалтаар /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон/ эрүүгийн 1902008.... дугаартай хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 1..3 дугаартай тогтоолоор 2 жил, 2 сар хорих ял шийтгэл оногдуулсан байна.

Үндсэрхэг үзэлтэй бүлэг, тэдгээрийн гишүүдийн зүгээс үйлдсэн хэрэг, зөрчлийг бүрэн дүүрэн шалгаж шийдвэрлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь тэдний зүгээс гадаадын иргэдэд халдах, нийгмийн уур амьсгалыг өөрчлөх, олон нийтийн аюулгүй байдалд учруулж болох үйл ажиллагааг саармагжуулах ач холбогдолтой болохыг хууль хяналтын байгууллагууд бодлогын түвшинд нэг мөр ойлгуулан, нөхцөл байдлын талаар бодит мэдээлэл, зөв ойлголттой болгох шаардлага үүсэж байна.

Дүгнэлт: Дээрх баримт, мэдээллийг үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Өнгөц харвал ЗБГХ Монгол Улсыг зовоох хэмжээнд хүрээгүй гэсэн сэтгэгдэл төрүүлж болох ч, үндэстэн дамнасан гэмт хэргээс ангид байх нэг ч улс, үндэстэн гэж байхгүй болсон бөгөөд “аюул, занал төрүүлэхгүй” байгаа нь зохион байгуулалттай гэмт сүлжээ хүчирхэгжих, өөрийгөө нийгэмд “энгийн ердийн, байх ёстой зүйл” мэтээр хүлээн зөвшөөрүүлэх, түүнд нийгмийн идэвхтэй, ухамсар бүхий хэсгийн нөлөө бүхий олонхыг нэгтгэх эрсдэл үүсэж болзошгүй.

2. Сүүлийн жилүүдэд зохион байгуулалттайгаар үйлдэгдсэн гэмт хэргийн түвшин, гадаад дотоод хүчин зүйл, шалтгаан нөхцөл, хүрээ, хамрагсдын байдлаас дүгнэхэд Монгол Улсад эрүүгийн гэмт хэрэгтнүүдийн гэмт бүлгээс гадна хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис зөөвөрлөх, зарж борлуулах, галт зэвсэг тэсэрч дэлбэрэх бодис, түүх соёлын дурсгалт зүйлс хууль бусаар худалдаалах гэмт хэргийн бүлгүүдийн үйл ажиллагаа идэвхжих, компани, группээр халхавчлан эдийн засгийн гэмт хэрэг үйлддэг бүлгүүдийн үйл ажиллагаа өргөсөх, хуулийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор улс төрийн салбарт нөлөөлөл хамгаалалт бий болгох, төрийн болон хуулийн байгууллагуудын албан тушаалтнуудыг урвуулан ашиглах явдал эрс идэвхжих хандлагатай болжээ.

3. Стратегийн орд газрууд болон байгалийн баялгаа эргэлтэд оруулах төр засгийн бодлогын үр дүнд гадаадын хөрөнгө оруулалт ихээр нэмэгдэж, үндэстэн дамнасан корпорацаар халхавчилсан гадны улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхжих хандлагатай байгаа нь зохион байгуулалттай гэмт хэргийн нөхцөл байдлыг хүндрүүлж болзошгүй байгааг харуулж байна.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ЦБ-ын чиг үүргийн нэгжээс нийгмийн зүгээс нөлөөлөх эерэг, сөрөг хүчин зүйлсийг тооцоолсны үндсэн дээр мэдээлэл олох-дүн шинжилгээ хийх-хариу сөрөг арга хэмжээ авах дунд болон урт хугацааны стратеги, тактикийг боловсронгуй болгож үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

2. Ижил чиг үүргийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, харилцан мэдээлэл солилцож ажиллах болон улс эх орны ашгийн үүднээс нэгдсэн ойлголттойгоор үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх.

3. Улс орнууд хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх: Зохион байгуулалттай гэмт хэрэг нь үндэстэн дамнасан шинжтэй болсон тул улс орнууд хоорондоо мэдээлэл солилцох, хамтран ажиллах.

4. Хууль эрх зүйн орчныг сайжруулах: Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд зориулсан хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шинэчлэх шаардлагатай.

5. Технологийн дэвшлийг ашиглах: Орчин үеийн технологи, программ хангамжийг ашиглан гэмт этгээдүүдийн үйл ажиллагааг тандах, таслан зогсоох боломжтой.

6. Олон нийтийн ухамсар, оролцоог нэмэгдүүлэх: Иргэдийн дунд зохион байгуулалттай гэмт хэргийн хор уршгийн талаар мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, тэднээс мэдээлэл авах замаар гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд татан оролцуулах нь үр дүнтэй.

7. Мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх: Цагдаа, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшүүлэх сургалт явуулах, гадаадын туршлагаас суралцах боломж олгох нь чухал.

Ашигласан материал

1. Монгол Улсын үндсэн хууль, 1992 он
2. Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997
3. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015
4. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017
5. Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль, 2017
6. Д.Адъяабазар, З.Төрмандах.Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс. УБ., 2005
7. Д.Адъяабазар. Мафи-Гэмт байгууллага. УБ., 1999
8. В.Ярочкин. Зохион байгуулалттай гэмт явдал, аюул хаанаас нүүрлэж байна. УБ., 2005
9. Паул Лунде. Зохион байгуулалттай гэмт хэрэг. 2004
10. НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенц. 2000
11. Дэвид Е.Каплан, Алек Дүбрө. Якуза. 2010 (Орчуулсан Д.Бадрал, ред Ж.Буянбат)

**МӨРДӨХ АЛБАНЫ БҮТЭЦ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ
ТҮҮХЭН ҮЕЧЛЭЛЭЭР ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ
STRUCTURE, MANAGEMENT AND ORGANIZATION OF THE INVESTIGATION
OFFICE A COMPARATIVE STUDY THROUGH HISTORY**

Д.Бямбабат

*ДХИС-ын Удирдлагын академийн 8021
дамжааны суралцагч, цагдаагийн хошууч*

D.Byambabat

*No. 8021 of the Academy of Management of the University
of Internal Affairs
course student, police major*

Хураангуй: Хүн төрөлхтний үүсэл, хөгжлийн түүхэн үйл явц, ангийн тэмцлийн үр дүнд улс, гүрэн байгуулагдаж, улсаа дагаж төр оршин тогтнож, улмаар төрт ёсны үйл хэргийг нэг мөр даган хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлагын үүднээс хууль тогтоомжууд бий болон хөгжлийн явцад нийгмийн янз бүрийн тогтолцоог дамжин, өнөөдрийн ардчилсан нийгмийг хүртэл өөрийн бодит үүргээ биелүүлж ирсэн түүхтэй.

Түүхийн энэхүү хөгжлийн бүхий л үе шатанд дэлхийн улс, гүрнүүд гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, гэмт этгээдийн хувийн шинж байдал, онцлогийг судлахад чиглэсэн судалгааг тасралтгүй явуулж ирсэн нь одоогийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, мөрдөн шалгах, нотлоход чиглэсэн орчин үеийн салбар шинжлэх ухааны хөгжлийг тодорхойлж, улмаар мэдлэгийн тусгай салбар криминологи, криминалистик, эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй зэрэг салбар шинжлэх ухааны онолын үндэс суурийг бий болгож мөрдөн шалгах ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын ойлголт хөгжиж ирсэн түүхтэй.

Энэхүү өгүүллээр мөрдөх алба үүсэн байгуулагдсан түүхэн уламжлалыг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа, түүний удирдлагын эрх зүйн зохицуулалт нь хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг судлахыг зорьсон.

Abstract: As a result of the historical process of the origin and development of mankind, and as a result of the class struggle, states and empires were established, and the state followed the state, and then, in view of the necessity and requirement to implement state affairs in a single line, laws were created and through various social systems in the course of development, even today's democratic society has a history of fulfilling its real obligations.

At all stages of this development of history, countries and powers of the world have continuously conducted research aimed at identifying crimes, their causes, and investigating the personality and characteristics of criminals. It has a history of determining the development of science, and then creating the theoretical foundations of special branches of knowledge such as criminology, forensics, criminal law, criminal law, and the management and organization of investigations.

This article aims to study how the historical tradition of the establishment of the investigation service, the fight against crime and violations, and the investigation, as well as the legal regulation of its management, have evolved.

Түлхүүр үг: Мөрдөх алба, удирдлага, зохион байгуулалт, түүх, бүтэц

Keyword: Investigation Service, Management, Organization, History, and Structure

Үндсэн хэсэг. Монгол Улсын Засгийн газраас 1934 онд “Ардын цагдан сэргийлэх газрын дүрэм”-ийг шинээр боловсруулан батлуулж, уг дүрмээр цагдан сэргийлэх байгууллага нь хуулийг биелүүлэх талаар иргэдээс шаардах, үл биелүүлэгчдэд хууль ёсоор арга хэмжээ авах, сэжигтнийг шалгах, гэмт хэрэгтнийг баривчлах, байцаан нэгжих эрх олгосон байна.

1935 онд “Аливаа эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх тухай хууль”-ийг Улсын бага хурлаар батлан шинэчилсэн байна. Энэ хуулинд “байцаагч түшмэд” гэх нэрийг өөрчлөн “байцаагч” гэж нэрлэн тус улсын дотор эрүүгийн хариуцлагад татах явдлыг үүсгэн мөшгөн байцаах үүрэг бүхий байгууллагыг тодорхойлсон. Үүнд:

1. Хууль хамгаалах прокурорууд ба тэдгээрийн байцаагч нар
2. Дотоодыг хамгаалах газар
3. Үндэсний хувьсгалт цэргийн прокурор ба тэдгээрийн байцаагч нар
4. Сум ба хорооны нарийн бичгийн дарга нар
5. Цагдан сэргийлэх газрууд харьяалагдаж байсан.

Дотоод явдлын яамыг 1936 онд өргөтгөж, хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий офицер, ажилтнуудыг томилон ажиллуулжээ. 1940 оны 03 дугаар сард Улсын цагдан сэргийлэх газрын даргын 41 тоот тушаалд “цагдан сэргийлэх газар бол гэмт хэрэг үйлдэгчдийг дайчлан баривчлах, хорьж мөрдөх, байцаан нягтлах ажлуудыг явуулах мөрдөн байцаах газар мөн⁸¹ гэж тодорхойлжээ.

Сайд нарын зөвлөлийн 1942 оны 14 дүгээр хуралдаанаар “Цагдан сэргийлэх байгууллагын дүрэм”-ийг шинэчлэн баталж, тус байгууллагад гүйцэтгэх ажил эрхлэх, мөрдөн байцаалт явуулах эрх олгож, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны үе шатыг анх удаа зааглан өгсөн байна⁸². Дотоод явдлын яамны сайдын 1946 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 504 тоот тушаалаар Улсын цагдан сэргийлэх газрын 1 дүгээр хэлтсийн ажлаас мөрдөн байцаалтын ажлыг тусгаарлан “ард иргэдийн өргөдөл, гомдлыг шалган барагдуулж, мөрдөн байцаалт явуулах үүрэгтэй тусгай группийг хоёр хэсэгтэй байгуулсан нь мөрдөн албаны анхны суурийн эхлэл тавигдсан юм.

Цагдан сэргийлэх байгууллагад мөрдөн шалгах ажиллагааг дагнан хариуцах мэргэжлийн алба буй болсон анхны өдрөөс эхлэн алдаа дутагдалд дүгнэлт хийж, урьдчилан хорих, түр саатуулах төвийг мөрдөн байцаах группын мэдэлд авч, түр саатуулах, хорьж мөрдөх сэжигтэн, яллагдагчдыг гүйцэтгэх хэлтэс, сэргийлэх ангиуд өөрсдийн тогтоолоор шийдвэрлэж байсныг өөрчлөн зөвхөн мөрдөн байцаах группын даргын баталсан тогтоолоор хорьж саатуулдаг шинэ журам тогтоосон байна. Энэ цагаас цагдан сэргийлэхийн гүйцэтгэх ажилтан төлөөлөгч нар мөрдөн байцаалтын ажил давхар эрхэлж байсныг Дотоод явдлын яамы сайдын тушаалаар зогсоожээ. 1947 оны 06 дугаар сард Улаанбаатар хотын Цагдан сэргийлэх ангийн төлөөлөгч нар мөрдөн байцаалт эрхэлж байсныг яамын сайдын 384 тоот тушаалаар зогсоож, улсын хэмжээний мөрдөн байцаах ажлыг мөрдөн байцаах хэлтэс хариуцах болгож зарим орон тоог нэмэгдүүлж өгсөн байна. 1948 онд Мөрдөн байцаах хэлтсийг дотор нь өмчид халдсан хэрэг мөрдөх, эрүүгийн бусад хэрэг мөрдөх хоёр групптэй болгож улмаар 1952-1953 онд нийслэлийн болон хөдөө орон нутгийн бүх цагдан сэргийлэх ангиуд орон тооны мөрдөн байцаагчтай болж өргөжин Улсын цагдан сэргийлэх газрын Мөрдөн байцаах хэлтсийг байгуулан мэргэжлийн удирдлагар хангах нөхцөл, боломжийг бүрдүүлж өгчээ⁸³.

Мөрдөх алба үүсэн байгуулагдсан эхний үедээ зохион байгуулалтын хувьд бүрэн төлөвшиж чадаагүй, мөрдөн байцаагчид дадлага туршлага багатай, гүйцэтгэх ажилтан төлөөлөгч нар нь олон жил мөрдөж ирсэн дадал зуршлаасаа салах дургүй зэрэг бэрхшээл хэсэг хугацаанд тохиолдож байсан ч дээрээс авсан арга хэмжээний үр дүнд ажлын туршлага өсөж энэ нь хууль зүйн үүднээс гүйцэтгэх ба мөрдөн шалгах ажлын ялгаа, зааг улам нарийвчлагдан тодорч гарснаар мөрдөн байцаах хэлтсийн бүтэц, зохион байгуулалтын үйл ажиллагаа төлөвшин тогтох явцад биеэ даасан хоёр өвөрмөц алба бий болгох нөхцөл бүрдэх үндэс тавигдсан байна⁸⁴.

Улмаар 1949 онд БНМАУ-ын “Эрүүгийн хэрэг байцаан шийтгэх журмын тухай хууль”-ийг шинэчлэн баталсан ба уг хуулийн 25 зүйлд “Мөрдөн байцаагч, улсын прокурорын чухал хэргийн мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, улсын прокурорын чухал хэргийн мөрдөн байцаагч, цэргийн прокурорын мөрдөн байцаагч, ДЯЯ-ны Улсыг аюулаас хамгаалах газар ба Улсын цагдан

⁸¹ Архивын баримт.УЦСГ-ын 1940 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 41 тоот тушаал

⁸² Мөрдөн байцаах газар. Монгол Улсын цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албаны түүхэн замнал. Мөрдөн байцаах албаны 65 жилийн ойд зориулав.-УБ., 2011. 7 дахь тал

⁸³ И.Цэдэн-Иш. Мөрдөн байцаах албаны түүх.-УБ., 1996. 19 дэх тал

⁸⁴ И.Цэдэн-Иш. Мөрдөн байцаах албаны түүх.-УБ., 1996. 21 дэх тал

сэргийлэх газрын мөрдөн байцаагч нар болно⁸⁵ гэж анх удаа тодорхойлох “мөрдөн байцаагч” гэсэн нэр томъёо анхлан Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд тусгагдсан ба энэ үеэс гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч “мөрдөн байцаагч”-ийн эрх, үүрэг хуулиар баталгаажсан гэж үздэг.

Цагдан сэргийлэх байгууллага түүний албадуудын үйл ажиллагааг сайжруулах, ажлын арга барилыг өөрчлөн шинэчилж, ард иргэдтэй ойртуулах тэдний ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлэхэд МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1957 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Цагдан сэргийлэх байгууллагын ажлыг сайжруулах, ажиллах бололцоо нөхцлөөр хангах тухай хууль” 19 дүгээр тогтоол их ач холбогдолтой байсан. Уг тогтоолд “мөрдөн байцаагч” нар мөрдсөн хэргийнхээ талаар шүүхийн бэлтгэл цуглаанд илтгэл тавьдаг зохисгүй практик ажиллагааг зогсоож, цагдан сэргийлэхийн нийт ажилд прокурорын хяналтыг хүчтэй болгох”-ыг заажээ.

1961 оны 03 дугаар сард Улсын прокурорын коллегийн хурлаар Мөрдөн байцаах байгууллагын ажлын байдал, цаашдын зорилтын тухай хэлэлцэж “шүүхээс хэрэг олноор буцах, хэрэг мөрдөх хугацаа хэтрэх явдал багасахгүй байна” гэсэн дүгнэлт хийж, улмаар Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 313 дугаар “Цагдан сэргийлэхийн мөрдөн байцаах хэлтсийг Улсын прокурорт шилжүүлэх тухай” тогтоолыг хэрэгжүүлж, УЦСЕГ-ын Мөрдөн байцаах хэлтсийг Улсын прокурорын газар шилжүүлэхээр тогтож, нийт 40 гаруй мөрдөн байцаагчийг офицерийн бүрэлдэхүүнээс халж, Улсын прокурорын дэргэлэх Мөрдөн байцаах газар, аймгуудад аймгийн прокурорын дэргэдэх групп болгон ажиллахаар шийдвэрлэжээ. Энэ нь тухайн үедээ мөрдөн шалгах ажлын чанарыг дээшлүүлэх, түүний удирдлагын үйл ажиллагааг шинэ шатанд гаргах зорилго, чиглэл бүхий төр, засгийн зүгээс бодлогоор хэрэгжүүлж байсан томоохон өөрчлөлт, шинэчлэлтийн ажил байна.

Мөрдөн байцаагчдын орон тоо хүрэлцэхгүй, цагдан сэргийлэх байгууллагын холбогдох албадтай ажлын уялдаа холбоо муу зэрэг шалтгааны улмаас үйлдэгдсэн гэмт хэргийг бүрэн илрүүлэхгүй байх, цаг хугацаа алдах дутагдалууд байнга гарч байсны улмаас 1964 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Мөрдөн байцаах албыг Цагдан сэргийлэх ерөнхий газарт буцаан шилжүүлэх МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоол гарч, цагдан сэргийлэх төв орон нутгийн байгууллагууд мөрдөн байцаах албыг прокурорын байгууллагаас хүлээн авах ажил эхэлсэн байна. Уг тогтоолтой холбоотойгоор 1964 онд НАХЯ-ны Сайдын тушаалаар Улсын мөрдөн байцаах газрыг байгуулсан ба Мөрдөн байцаах газрын хэлтсүүдэд Улаанбаатар хотын районуудыг хуваарилан хариуцуулж гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулахын тулд онц ноцтой гэмт хэрэгт гүйцэтгэх ажлыг мөрдөн байцаалттай нягт холбож байх, шүүх хуралд мөрдөн байцаагчийг прокурорын хамт оролцуулж байх зэрэг үйл ажиллагааг журамласан байна.

1963 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү хуулийн 125 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэргийн талаархи мөрдөн шалгах ажиллагааг прокурор, цагдан сэргийлэх болон улсыг аюулаас хамгаалах байгууллагын мөрдөн байцаагч нар хэрэгжүүлэхээр тусгайлан харъяалалыг тогтоож өгсөн ба мөрдөн шалгах ажиллагааны үндсэн чиг үүргийг хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн шалгах, гэмт хэрэг үйлдсэн эсвэл сэжигтэн этгээдийн гэм буруутай, эсэх байдлыг тогтоох, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөлийг тогтооход чиглэх талаар хуульчлан баталгаажуулсан байна. Хэдийгээр энэхүү хуульд гэмт хэргийг илрүүлэх, нотлоход чиглэсэн мөрдөн шалгах ажиллагааны процессыг тодорхойлон гаргасан боловч энэхүү ажиллагааг удирдан зохион байгуулах, түүнийг мэргэжлийн удирдлагаар хангах талаар тусгаагүй байна. Мөрдөн шалгах ажиллагааны удирдлага, түүнийг хэрэгжүүлэх субъектын талаархи анхны чухал эрх зүйн зохицуулалт бол “БНМАУ-ын Эрүүгийн байцаах шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай “ БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1968 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 13 дугаар Зарлиг бөгөөд энэхүү зарлигаар “Мөрдөн байцаах хэлтсийн дарга” гэсэн шинэ нэр томъёог анх удаа хуульд оруулж, улмаар түүний эрхийг баталгаажуулсан байна.

⁸⁵ БНМАУ-ын Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1949 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр зарлигаар батлагдсан Эрүүгийн хэргийг байцаан шийтгэх журмын хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.


Хууль ёсыг чанд сахих, гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажлыг сайжруулах зорилгоор МАХН-ын Төв хороо, Сайд нарын зөвлөл мөрдөн байцаах ажилтны улсын зөвлөгөөн хийх шийдвэр гаргаж, “Мөрдөн байцаах ажилтны улсын анхдугаар зөвлөгөөн”-ийг 1969 оны 12 дугаар сарын 15-нд зохион байгуулжээ.

Тус зөвлөгөөн дээр МАХН-ын Төв хорооны Улсын төрийн товчооноос гаргасан “Мөрдөн байцаах ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 186 дугаар тогтоолыг танилцуулж уг тогтоолд мөрдөн байцаах байгууллагын бүхий л үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэл дээр тулгуурлан явуулах, хууль ёсыг хэлбэртэй биелүүлэх, тэргүүн туршлагыг судлан нэвтрүүлэх замаар мөрдөн шалгах ажлыг цаашид улам боловсронгуй болгох, мэргэжлийн удирдлагыг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх зэрэг нэн чухал шийдвэрүүдийг гаргаж, улмаар Мөрдөн байцаах газрын дарга УЦСЕГ-ын орлогч дарга байхаар, мөрдөн байцаах ажилтны ажилласан хугацааг харгалзаж цалинг тогтоох, машин, мотоцикл, бичиг хэргийн зардал, бичгийн машинаар хангахыг тодорхой заасан байна.

Анхдугаар зөвлөгөөний үеэр мөрдөн байцаах байгууллагын талаар авах арга хэмжээний тухай Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч, уг тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс НАХЯ-ны Сайдын 1970 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 34 тоот тушаалаар УЦСЕГ-ын Мөрдөн байцаах газрыг 6 хэлтэс, 5 нэгжтэйгээр өргөтгөн зохион байгуулсан байна.

1972 оны НАХЯ-ны Сайдын тушаалаар УЦСЕГ-ыг Мөрдөн байцаах газрын дүрмийг баталсан нь тус байгууллагыг хөгжин бэхжихэд чухал алхам болсон байна. Шинэ дүрмээр Мөрдөн байцаах газрын ажилтнуудын эрхлэх ажил үүргийн хуваариг нарийвчлан зааж, УЦСЕГ-ын орлогч бөгөөд Мөрдөн байцаах газрын дарга, түүний орлогч ба хэлтсийн дарга нарын зөвлөлийг байгуулж, газрын даргад зөвлөх эрхтэйгээр ажиллах хамтын удирдлагын зарчмыг анх удаа хуульчилсан байна. Энэ үед УЦСЕГ-ын даргын тушаалаар хавтаст хэргийн соёлжилтыг сайжруулах, хэргийн газрын үзлэгийн схем, фото зураг, эд мөрийн баримт, туршилт, нэгжилт, хураан авалт зэрэг мөрдөн байцаагчийн үйл ажиллагааг харуулсан материалгүйгээр шүүхэд хэрэг шилжүүлэхийг хорриглож байжээ. МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 1976 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 406 дугаар протоколоор 1977 оны сүүлийн хавтаст “Мөрдөн байцаах ажилтны Улсын 3 зөвлөгөөн”-ийг хийхээр шийдвэрлэн 1977 оны 11 дүгээр сарын 25-нд болж нам засаг, хууль хяналтын байгууллагын удирдах ажилтан нар оролцож “Мөрдөн байцаах ажлын байдал, цаашид тавих зорилт” илтгэлийг Улсын прокурор Ж.Авхиа тавьж хэлэлцүүлсэн байна. Тус зөвлөгөөнөөс мөрдөн хэргийн 90-ээс доошгүй хувийг анхны хугацаанд 95-аас доошгүйг анхны ялын төлөвлөгөөгөөр шийдвэрлэж, учирсан хохиролыг 60-аас доошгүй хувийг мөрдөн байцаалтын явцад барагдуулах зорилт дэвшүүлсэн байна.


НАХЯ-ны сайдын 1982 оны 06 дугаар сарын 118 дугаар тушаалаар улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг дараах бүтцээр баталсан⁸⁶. Үүнд:




⁸⁶ Мөрдөн байцаах албаны 70 жилийн ном. –Уб., 2016. 26 дахь тал

Ардчилал, өөрчлөн байгууллагын үйл явц нийгмийн бүх хүрээг хамарч эхэлсэн 1990 онд Засгийн газрын 107 тоот (1990 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн) тогтоол гарч Цагдаагийн Ерөнхий газар (цаашид ЦЕГ гэх) байгуулагдав.

Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын даргын 1990 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 367-р тушаалаар дараах бүтцээр баталсан⁸⁷. Үүнд:




1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдснаар улс орны хэмжээнд дагаж, мөрдөж буй хууль тогтоомжуудыг шинэ Үндсэн хуульд нийцүүлэн шинэчлэх ажил өрнөж, 1993 оны 12 дугаар сарын 13-ны өдөр “Цагдаагийн байгууллагын тухай хууль” шинээр батлагдсан нь Монгол Улсын Цагдаагийн байгууллагын түүхэн шинэ үеийг авчирсан юм. Цагдаагийн байгууллагын тухай шинэ хууль гарснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгүүдийг яаралтай шинэчлэн өөрчлөх шаардлага тавигдаж байсан тул 1993 оны 06 дугаар сарын 07-ны өдөр “Эрүүгийн хууль”-д, 1994 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 130 дугаар тогтоолоор Тагнуулын Ерөнхий газарт Мөрдөн байцаах хэлтэс байгуулсан тул зохих орон тоог шилжүүлсэн байна. Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2000 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 158 дугаар тушаалаар Улсын Мөрдөн байцаах газрыг дараах бүтцээр баталсан⁸⁸.




⁸⁷ Мөн бүтээл. 30 дахь тал

⁸⁸ Мөрдөн байцаах албаны 70 жилийн ном. –Уб., 2016. 39 дахь тал

Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль шинэчлэгдсэн холбогдуулан Мөрдөн байцаах алба нь онц хүнд, хүнд гэмт хэрэг болон тусгайлан харьяалуулсан хүндэвтэр хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар болж, Цагдаагийн Ерөнхий газрын 2002 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 297 тоот тушаалаар тус газрын орон тоо зохион байгуулалтыг өөрчлөн баталжээ. Уг тушаалаар Улсын ерөнхий прокурорын дэргэд Мөрдөн байцаах алба байгуулах болсонтой холбогдуулан Мөрдөн байцаах газрын харьяанд ажиллаж байсан шүүх, прокурор, цагдаагийн ажилтнуудаас үйлдсэн гэмт хэргийг мөрдөж байсан хэлтсийг орон тоо төсвийн хамт Улсын ерөнхий прокурорын мэдэлд, дүүргүүдийн Мөрдөн байцаах тасгуудыг Нийслэлийн цагдаагийн газрын мэдэлд орон төсвийн хамт шилжүүлэн Улсын Мөрдөн байцаах газрын бүтцийг дараах байдлаар тогтоосон байна⁸⁹.



Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 101 тоот тогтоолоор батлагдсан ЦЕГ-ын Улсын мөрдөн байцаах газрын бүтэц, орон тоонд 1995, 2002 онуудад хууль зүйн шинэчлэл, нийгмийн тогтолцооноос хамааралтай өөрчлөлтүү орж байсан тул ЦЕГ-ын даргын 2003 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 115 тоот тушаалаар УМБГ-ын бүтэц орон тоог дараах байдлаар тогтоожээ.




⁸⁹ Мөн бүтээл. 42 дахь тал

Дээрх бүтэцтэйгээр ажиллаж байх үед Улсын Мөрдөн байцаах газрын даргын 2003 оны 03 тоот тушаалаар Мөрдөн байцаах албаны алба хаагчдын “ажлын байрны тодорхойлолт”-ыг, 2003 оны 63 тоот тушаалаар Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд прокуроро, мөрдөн байцаах албаны дарга нарын гаргаж буй шийдвэрийг зөвхөн бичгийн хэлбэрээр хүлээн авч хэргийн материалд хийж байх журам”-ыг, 2003 оны 18 тоот тушаалаар “Мөрдөн байцаах хэлтэс, тасгийн дарга, нэгжийн ажил дүгнэх аргачлал”-ыг шинэчлэн баталсан зэрэг олон зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрч ажилласан байна.

2007 онд Авилгатай тэмцэх газар байгуулсантай холбогдуулан мөн оны 03 дугаар сард Албан тушаалын гэмт хэрэг мөрдөх хэлтэс татан буугдаж, Эдийн засгийн мөрдөх хэлтэс болон өөрчлөн зохион байгуулагдаж, 5 мөрдөгчийг Авилгатай тэмцэх газарт шилжүүлсэн.

2007 оны 08 дугаар сарын 09-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хуульд орсон өөрчлөлтөөр хүндэвтэр гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах болсноор мөрдөн байцаах ажлын ачаалал эрс нэмэгдсэн, зарим дүүргүүдийн нутаг дэвсгэрт гэмт хэргийн гаралт ихэсч, тасгийн дарга нарын хяналт хэрэг нэг бүрт хүрэлцэхгүй байгаагийн улмаас ажлын чанарт сөрөг үр дагавар гарч байгааг харгалзан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 128 дугаар тушаалаар нийслэлийн 5 дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд мөрдөн байцаах 2 дугаар тасгуудыг байгуулсан нь алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хяналтыг сайжруулахад үр дүн өгсөн.

“Хүндэвтэр” гэмт хэргийн харьяаллыг тогтоосноор хэрэг бүртгэх албанаас мөн ангилалд хамаарах хэргүүд шилжин ирж нийт хэргийн тоо илт өссөнөөс гадна, шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад буурсан байна.



Мөрдөн байцаах албаны түүхийг судлахад нийгэм, улс төрийн нөхцөл байдал ямар ч үед нам төр, засгийн удирдлагуудын бүхий л шатанд мөрдөн байцаах албыг бэхжүүлэх, ажлын үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдыг хөгжүүлэх, чадвартай мэргэшсэн боловсон хүчнээр хангахад байнгын анхаарал хандуулж ирсэн нь энэ алба төвшин тогтож, хуулийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх боломжийг олгосон байна.

Монгол Улсын эртний хууль тогтоомжийн түүхэн уламжлалыг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, мөрдөн шалгах, нотлох ажиллагаа, түүний удирдлагын эрх зүйн зохицуулалт талаас нь хэрхэн авч үзснийг тайлбарлан судлахыг зорьсон.

Дүгнэлт: Хүн төрлөхтний үүсэл, хөгжлийн түүхэн үйл явц, ангийн тэмцлийн үр дүнд, улс гүрэн байгуулагдаж, улсаа дагаж төр оршин тогтнож, улмаар төрт ёсны үйл хэргийг нэг мөр даган хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээг, шаардлагын үүднээс хууль тогтоомжууд бий болж, улмаар нийгмийн янз бүрийн тогтолцоог дамжин өнөөдрийн ардчилсан нийгмийг хүртэл өөрийн бодит үүргээ биелүүлж ирсэн түүхтэй юм байна.

Түүхийн хөгжлийн бүхий л үе шатанд дэлхийн улс, гүрнүүд гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, гэмт этгээдийн хувийн шинж байдал, онцлогыг судлахад чиглэсэн судалгааг тасралтгүй явуулж ирсэн ба орчин үеийн салбар шинжлэх ухааны хөгжлийг тодорхойлж, улмаар мэдлэгийн тусгай салбар-криминологи, криминалистик, эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй зэрэг салбар шинжлэх ухааны онолын үндэс, суурь бий болгож түүний мөрдөх шалгах ажиллагаанууд хөгжиж иржээ.

Гэмт хэргийг илрүүлэх, нотлох, мөрдөн шалгах, үйл ажилагааг зохицуулж буй дэлхийн олон орны болон Монгол Улсын хууль тогтоомжийн үүсэл, хөгжлийг судлан дүгнэхэд тэдгээр нь бүхэлдээ хөгжлийн нийтлэг зүй тогтлыг илэрхийлж байгаа хэдий ч онолын чиг баримжаа, өөр, өөрийн үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлага, хууль боловсруулах үйл ажиллагаанд бусад орны зүгээс үзүүлсэн нөлөө, гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн үр нөлөөтэй арга, эрх зүйн орчинг бий болгоход бусад орны тэргүүн туршлагыг судлах, нэвтрүүлэх гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөлөлөөр өөр өөрийн хөгжлийн хэв загвараа олсоор иржээ⁹⁰.

Санал: Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн байгууллагын мөрдөх чиг үүргийг хэрэгжүүлж бүтцийн нэгжийг нэгтгэн Монгол Улсын Мөрдөх албыг байгуулах.
2. Хэргийн харьяаллыг нь нарийвчлан тогтоож, харьяаллыг нь УИХ-т хамаатуулбал, илүү тогтвортой болгох.

⁹⁰ Мөрдөн байцаах албаны 70 жилийн ном. УБ 2016.,48 дахь тал

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ
METHODS FOR ENSURING AND ENHANCING THE SECURITY OF EXPLOSIVES
AND EXPLOSIVE DEVICES TRANSPORTATION

Э.Буман-Аюуш

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн

Дотоодын цэргийн албаны

тэнхимийн ахлах багш, ахмад

Buman-Ayush.E

Senior Lecturer at Department of Internal Troops Service in Police School,
University of Internal Affairs Mongolia , captain

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Дотоодын цэргийн хуулиар хүлээлгэсэн үндсэн чиг үүрэг болох зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх ажиллагаа, "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй байдал"-ын тухай ойлголт, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар товч авч үзлээ.

Abstract: This report addresses the concept of "Safety in the Transportation of Explosives and Explosive Equipment/Device," focusing on its legal regulation in accordance with the primary functions assigned by Internal Military Law, specifically the transportation of passengers and cargo. An overview of these aspects is provided.

Түлхүүр үг: Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, тээвэрлэлтийн хамгаалалт, эрх зүйн зохицуулалт.

Keywords: Explosives, explosive devices, transportation security, legal regulation.

Үндсэн хэсэг. Монгол Улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, ашигт малтмалын томоохон ордууд эдийн засгийн эргэлтэд орж, Дотоодын цэргийн байгууллага хамгаалахаар болсонтой холбоотой тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, хэрэгцээ, импорт ихээхэн нэмэгдэж байгаа өнөө үед улс орны үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болсон дотоод аюулгүй байдлыг хангах томоохон цогцолбор ажиллагааны нэг хэсэг нь Тэсэрч, дэлбэрэх бодисыг тээврийн замд харгалзан хүргэх харуул хамгаалалт юм.

Олон зуун жилийн өмнөөс хүн төрөлхтөн дарийг мэддэг, ашигладаг байжээ. Гэхдээ эмийн журмаар хэрэглэдэг байсан. Орчин үеийн тэсрэх бодисын анхдагч нь "Трекийн гал" нэртэй ёслолын буудлагын зориулалтаар хэрэглэж эхэлсэн гэж үздэг. Эх сурвалжуудад дурдсанаар манай эриний 667 онд Коллинокос гэгч хүн "Трекийн гал"-ыг бүтээсэн гэж үздэг.⁹¹

Манай эриний 682 онд хятадад шүү, хүхэр, модны нунтаг гэсэн бүтэцтэй болж анх удаа даринь зориулалтаар ашиглаж эхэлсэн байна.⁹² Тухайлбал Венгр зууны үед ул, уурхайд тэсрэх бодис Ашигласан тухай мэдээ байдаг.

Тэсрэх бодисын дараагийн хөгжлийн үе шат нь XVIII-р зууны төгсгөлтэй холбоотой. Энэ үед маш хүчтэй тэсэрдэг тэсрэмтгий мөнгө гремучее серебро/ нээгдсэн бөгөөд 350 жилийн өмнөөс эхлэн тэсрэх бодисыг эрдсийн болон уул уурхайн салбарт ашигласан байдаг. Баруун Европын томоохон хэрэглэгч орнуудын жилийн дундаж хэрэглээ нь 40000-аас 50000 тонн хүрдэг.

⁹¹ Б.Чадраабал. Даринь үйлдвэрлэл. –Уб., 2013. 15 дахь тал

⁹² А.Хүү-Ухнаа., Б.Чадраабал В. Дарь, тэсрэх бодисын шинж чанар, үйлдвэрлэл, хэрэглээ. –Уб. 2011. 22 дахь тал

АНУ дэлхийн тэргүүлэгч спонсор орон бөгөөд жилд 2.74109 kg тонн ANFO (ammonium nitrate-fuel oil). ANFO нь хямд үнэтэй, арга техник нь воул багатай сонгомол бүтээгдэхүүн. Манай оронд уул уурхайн компаниуд ANFO ба түүний холимгуудыг ашигласаар байна.

Тэсрэх бодис /хольц гэж орчны юмсыг гэмтээх хэмжээний хурд, даралт, температур бүхий хий ялгаруулдаг, химийн урвалд өөрөө орох чадвар бүхий бодисыг (хольц) хэлнэ. Пиротехникийн бодис нь хий ялгаруулахгүй байсан ч энэхүү ангилалд хамаарна

Пиротехникийн бодис /хольц/ гэж аяндаа экзотермийн урвалд орон, тэсрэлтгүйгээр дулаан, гал, дуу чимээ, утаа эсвэл эдгээрийн цогцыг үзүүлбэр маягаар гаргах зориулалттай бодисыг хэлнэ

Тэсрэх бодис нь тодорхой нөхцөлд гадны нөлөөнд автсан химийн хувиргалт (дэлбэрэлт)-ийг хурдасгах чадвартай, өтгөрүүлсэн химийн бодис буюу эдгээр бодисын холимог юм.

Тэсрэх бодис, тэсрэх хэрэгсэлийг ашиглахад түүний бүтэц, зохион байгуулалт, физик химийн чанар, харьцах, ашиглах дүрэм заавар, пагзэрийг зохицуулах хуулийн заалт, тавигдах шаардлагыг сайтар судалсан байх шаардлагатай.

Тэсэрч дэлбэрэх бодис" гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцы хэлнэ гэж заасан байна.⁹³

Тэсрэх бодисын судалгааны нэг чиглэл бол түүнийг үйлдвэрлэх болон хадгалах үеийн аюулгүй ажиллагаа юм. Тэсрэх бодис нь урт хугацаанд найдвартай хадгалагдах шинж чанарыг агуулсан байх бөгөөд тэр нь түүний түүхий эдийн чанараас хамаарна.

Тээвэрлэлтийн явцад хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нарт тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай. Ийм учраас Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн физик, хими шинж чанарыг товч авч үзье. Тэсрэх бодисуудын шинж чанар нь дараах байдлаар тодорхойлогддог. Үүнд:

- Тэсрэх өөрчлөлтийн хурд
- Шаталтын даралт
- Тэсрэлтийн дулаан
- Тэсрэх бодисын хийн бүтээгдэхүүний эзлэхүүн, найрлага
- Тэсрэх бүтээгдэхүүний хамгийн өндөр хэм
- Гадны нөлөөлөлд мэдрэмтгий чадвар
- Тэсрэлтийн тойргийн хэмжээ
- Тэсрэлтийн нягтрал

Тэсрэх бодисын үйлчлэлээр дараах байдлаар ангилна.

- Байрлалын үйлчилгээтэй буюу бутлах /бризант/
- Ерөнхий үйлчилгээтэй буюу шидэх /фугас/

Тэсрэх бодисыг физик чанар, төлөвөөр нь байдлаар ангилна.:

- Хийн
- Шингэн
- Гель хэлбэрийн
- Суспенз хэлбэрийн
- Эмульсийн
- Хатуу
- Пластик
- Уян хатан

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэгээний хэрэгслийн тээвэрлэлтийн явцад бусдын санаатай болон болгоомжгүй үйлдийн улмаас дэлбэрэлт үүсэж ноцтой хор уршиг учирч болзошгүй учраас дэлбэрэлт үүсэх шалтгааныг хувьд авч үзье. Судлаачдын тодорхойлсоноор:

Дэлбэрэлт гэдэг нь: Физикийн болон химийн өөрчлөлтөөр маш богино хугацаанд их хэмжээний энерги ялгарах үзэгдэл юм.

⁹³ Төрийн мэдээлэл. 2013. №8. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль

Механик дэлбэрэлт гэдэг нь: Хий агуулсан сав даралтын нөлөөгөөр гэнэт дэлбэрэх үзэгдэл юм.

Химийн дэлбэрэлт гэдэг нь: Бүтээгдэхүүн, хольц нь задрах эсвэл маш хурдан хариу урвалд орсноор үүсдэг байна.

Цөмийн дэлбэрэлт гэдэг нь: Атомын задрал болон атом бөөмсийн задралын улмаас үүснэ.

Цахилгаан дэлбэрэлт гэдэг нь: Металл утсаар дамжин хүчтэй цахилгаан гүйдэл үүссэнээр бий болно.

Дэлбэрэлт нь их хэмжээний дулаан ялгаруулсан урвал байх бөгөөд урвал маш хурдан явагдаж урвалын бүтээгдэхүүнээр их хэмжээний хий үүсдэг бөгөөд маш богино хугацаанд ихээхэн хор уршиг учрах эрсдэлтэй.

Манай оронд байлдааны зориулалттай тэсрэх бодис, бүтээгдэхүүний илэрцийн тоо хэмжээ буурахгүй байгаа нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй юм. Ийм учраас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд, нэн ялангуяа хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад тэсэрч дэлбэрэх бодис, бүтээгдэхүүний талаар зохих мэдлэг олгохыг зүй ёсоор шаардаж байна.

Нөгөө талаас Монгол улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн амьдралд гарч байгаа бодит өөрчлөлт, шинэчлэлтүүдийг дагаж эерэг, сөрөг олон нөлөөлөл нийгэмд мэдрэгдэж байгаа өнөө үед тэсэрч дэлбэрэх бодис буюу аюултай ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх үйл ажиллагаа түүний хамгаалалтын асуудлын судлах хэрэгцээ шаардлага гарч байна.

Дотоодын цэргийн байгууллагын Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрмээр "Улсын онц чухал объектыг хамгалах, бусад объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх"-тэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар заасан билээ. Тиймээс тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийн тээвэрлэлтийн хамгаалалтын тухай, аюулгүй байдлыг хангах ажиллагааны талаар товч авч үзье.

Тээвэр нь улс орны дотоодын болон олон улсын харилцааны ачаа, зорчигчдыг нэг газраас нөгөөд цаг хугацаанд нь хүргэж үйлчлэхэд чиглэдэг үйлдвэрлэлийн тасралтгүй үйл явц юм. Тээврийн салбарын хөгжил нь техникийн түвшин, үйл ажиллагааны чиглэл нь тухайн улс орны байгаль цаг уурын нөхцөл, үйлдвэрлэх хүчний байршил, зам харилцааны байдлаас шууд шалтгаална.

Одоогоор Монгол улсад төрийн болон хувийн хэвшлийн ачаа тээврийн үйлчилгээний дараах төрлүүд байна. Тухайлбал: а)Улс хоорондын тээвэр, б)Орон нутгын тээвэр, в)Аюултай, хортой ачааны тээвэр, г)Овортой, хүнд ачааны тээвэр, д)Гэрээт түгээлтийн үйлчилгээ, е)Хамгаалалттай тээвэр, ё)Үнэт ачааны тээвэр зэрэг болно.

Тээврийн аль нэр төрлөөр тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин болон нислэгийн аюулгүй ажиллагаанд хохирол, аюул учруулж болох эд зүйлс болон бодисыг аюултай ачаа гэнэ.⁹⁴

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоолоор аюултай ачааг дараах 9 ангилалд хуваагддаг. Үүнд:

- 1.Тэсрэмтгий бодис.
2. Хийнүүд
3. Шатамхай шингэн
4. Шатамхай хатуу бодис
5. Исэлдэгч ба Органик бодис.
6. Хортой ба Халдвартай бодисууд
7. Цацраг идэвхит бодис
8. Идэмхий бодис
9. Бусад төрөл бүрийн аюултай бараа

⁹⁴ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоол

Иймээс бидний сонгон судлаж байгаа “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл” нь өөрөө аюултай ачааны зэрэглэлд хамаардаг байна.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын эдийн засаг зах зээлийн харилцаанд шилжин төрийн өмчийн үйлдвэрүүдийн бүтэц задарч, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд буй болж тэсрэх материалын эргэлтэнд хяналт тавих эрх зүйн орчин хангалтгүй, уул уурхайн тэсэлгээний бодисын хэрэглээ тухайн үед ямар ч зохицуулалтгүй замбараагүй байсан учраас хууль санаачлах хэрэгцээ шаардлага бий болж, Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Багабанди "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай" хуулийг анх санаачилж УИХ-д өргөн барьсан түүхтэй.

Монгол Улсын Их Хурлаас Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай бие даасан хуулийг 2004 онд батлан мөрдүүлж, улмаар 2013, 2015, 2017, 2020 онд шинэчлэн найруулсан байна.

Өнөөдөр Монгол улсын хэмжээнд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн сан бүрдүүлэх "APPS" программд 2020 оны байдлаар улсын хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдаалах, үйлдвэрлэх, тэсэлгээний ажил, үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөлтэй 78 аж ахуйн нэгж, байгууллага цахим санд бүртгэгдсэн байна.

"Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих хуулийн шаардлага тодорхой бус, Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрт нөлөө бүхий дүгнэлт гаргах эрхтэй "Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллага"-ын болон шинжээчийн эрхийг хэн, хэрхэн олгох нь тодорхойгүй, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг тодорхой заагаагүй зэрэг нь эрх зүйн хийдэл үүсгэж хуулийн хэрэгжилтэнд сөрөг нөлөө үзүүлж байна хэмээн дүгнэж байна.

Мөн хүн амын дунд өргөн хэрэглээ болсон пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах зохицуулалтыг тодорхойлох, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг нарийвчлах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт, хяналттай холбоотой харилцааг зохицуулах дүрэм, журмыг батлах эрх шилжүүлсэн зохицуулалтыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага үүсээд байна" гэжээ.

Дээр дурьдсан дүгнэлтийг үндэслэн Хууль сахиулах байгууллагаас тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор тулгуурлан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулсан. Тус хууль нь батлагдан хэрэгжиж эхэлснээр тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих төрийн нэгдсэн бодлого, хөтөлбөр хэрэгжих нөхцөл бололцоо бүрдсэний зэрэгцээ холбогдох чиг үүрэг бүхий байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй Зохицуулах зөвлөл, Мэргэжлийн итгэмжлэгдсэн байгууллагыг байгуулж өгснөөр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалт, импорт, хадгалалт, үйлдвэрлэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын болон үйл ажиллагааны үндэс суурь бий болсон байна.⁹⁵

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагаа нь дор дурьдсан хууль, эрх зүйн актаар зохицуулагддаг байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
- Терроризмоос сэргийлэх тухай хууль
- Авто тээврийн тухай хууль
- Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль,
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх хууль
- Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм

⁹⁵ УУХҮЯ-ны статистик мэдээллээс.

- Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрэм", "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хяналт, Пуршилтын ажил хийх журам" /Засгийн газрын 2006 оны 149 дугаар тогтоолоор батлагдсан /
- Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 188 дугаар тушалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй тээвэрлэх журам
- Стандарчлал, хэмжилт зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2000 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Аюултай ачааны стандарт
- Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам
- Улсын хилээр лизенцтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт Засгийн газрын 2006 оны 149 дугаар тогтоолоор батлагдсан/
- Тэсэрч дэлбэрэх зүйлийн хайгуул, устгалын ажлын заавар
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд Зэвсэгт хүчнээс тодорхойлолт олгох тухай журам
- "Техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах заавар"-/2013 онд Уул уурхайн сайдын тушаалаар батлагдсан/

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-д заасан чухал объектыг хамгаалах, бусад объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар заасан байна.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тээврийн стандартыг баримтлан тусгай тоногдсон тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэх бөгөөд тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн маршрутыг Цагдаагийн байгууллага олгож, харуул хамгаалалтыг Дотоодын цэрэг гүйцэтгэж, аюулгүй байдалд хяналт тавина гэж хуулинд тусгайлан заажээ.⁹⁶

Өөрөөр хэлбэл Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл /автомашин/-ийн аюулгүй ажиллагааны стандарт шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, зөвшөөрөл олгох, хот суурин газарт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх чиглэл, хугацааг ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төв /орон нутагт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага/ батладаг байна.⁹⁷

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нь онц аюултай ачаанд хамаарах тул тээвэрлэх үед гарч болох аливаа аюул эрсдлээс урьдчилан сэргийлж, энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд нь Дотоодын цэргийн штабтай хамгаалалтын гэрээ байгуулж хамтран ажиллаж байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Дотоодын цэргийн анги байгууллагын даргын тушаалаар томилогдсон харгалзан хүргэх харуул заагдсан нутаг дэвсгэрт харгалзан хүргэх хамгаалалтын ажлыг зохион байгуулдаг ингэхдээ хууль тогтоомж, ЦЕГ, МХЕГ-ын дарга нарын 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн а/32/231 дугаар тушаалаар батлагдсан "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам"-ыг мөрдөн ажиллаж байна.

Энэхүү журамд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, хуяглан хүргэх харуулын төрөл, онцлог, алба хаагчдыг томилж үүрэгжүүлэх, удирдлагаас тавих хяналт, харуулуудын харилцан ажиллагаа, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл, харуулын хориглох зүйл, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар нарийвчлан тусгасан байдаг.

⁹⁶ Төрийн мэдээлэл. 2013., №08. Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хуулийн 14-р зүйлийн 14.1 дэх хэсэг

⁹⁷ Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх зөвшөөрөл олгох журам код- 607

Дотоодын цэргийн хамгаалалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгэний хэрэгслийг хот суурингийн төвөөр тээвэрлэн явж байга цувааг дамжин ороход нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага нь "Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай хууль"-ийн 14.1 дэх хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд аюулгүй байдлыг ханган, мэдээ мэдээллийг тухай бүр цаг алдалгүй солилцон хамтран ажиллаж байна.

Аюултай ачаа тээвэрлэлт

Аюултай ачаанд хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй болон тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой зэрэг бусад шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдэл болон ийм шинж чанарыг агуулсан эд зүйлс бүхий ачаа багтана.

Аюултай ачааг олон улсын хэмжээнд хэрэглэгддэг аюултай ачааны таних тэмдэг болон аюулын шинж чанарын тухай санамж байрлуулсан, техник ашиглалт, аюулгүйн байдлыг хангасан, зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэж мэргэжлийн хяналтын холбогдох байцаагчаар шалгуулж ашиглахыг зөвшөөрсөн тухай дүгнэлт гаргуулсан автотээврийн хэрэгслээр холбогдох хууль тогтоомж, энэхүү журам, аюултай ачааны стандарт, аюулгүй ажиллагааны зааврын дагуу тээвэрлэнэ.

Аюултай ачааг хүн, мал, амьтан болон өөр бараа бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэх, шуудан тээвэр, нийтийн тээврийн хэрэгсэл, суудлын автомашин, ердийн хөсгөөр тээвэрлэхийг хориглоно. Аюултай ачааны хайрцаг, сав нь гэмтэлтэй, автотээврийн хэрэгсэд бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй байвал тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос урьд зэргийлж, тэдгээрийг зөв байрлуулж, хөл гэнгүй сайтар бэхэлсэн байна. Аюултай ачаа тээвэрлэх автомашиныг унтраасны дараа ачааг ачиж, буулгахыг зөвшөөрнө.

Тээвэрлэх үед бодисын сав баглаа, боодлын битүүмжлэл алдагдах, ачаа нурах зэрэг зогсох шаардлага гарсан тохиолдолд уг аюултай ачааг тээвэрлэж яваа автотээврийн хэрэгслээс хоёр тийш 100м зайд "Орохыг хориглоно" тэмдгийг байрлуулна. Ийм ачаатай автотээврийн хэрэгслийг хот, суурин газрын ойролцоо удаан хугацаагаар зогсоохыг хориглоно.

Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэнийг үйлдвэрлэгчээс савласан зориулалтын тусгай шилэн саванд тээвэрлэнэ. Шилэн сав нь гадуураа модон хайрцаг, гөрмөл шээжгий, давхар савтай байна. Автотээврийн хэрэгслийн тэвшинд шилэн савны хоолой /таг/-г дээш харуулж босоогоор хөдөлгөөнгүй байхаар бэхэлж ачина.

Аюулын зэрэг өндөр химийн хорт болон аюултай бодис бүхий ачааг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба түүний ачааны тэмдгэнд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хатуу сахина.

Аюултай ачаа тээвэрлэх жолооч нь /цуваагаар тээвэрлэх үед цувааны ахлагч нь/ замын хөдөлгөөний эрчим, автотээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан автомашины хурд болон хоорондын зайг замын хөдөлгөөний дүрэм, аюултай ачааны стандартаар тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгон өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна. Аюултай ачааг нэгэн зэрэг 3 буюу түүнээс дээш автомашинаар цуваагаар тээвэрлэх үед дараах шаардлагыг биелүүлнэ:

Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан:

- Цувааны ахлагч цувааг зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрэм, аюултай ачааны стандарт, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан аюултай ачааг тээвэрлэх үйл ажиллагааг удирдана;
- Цувааны ахлагч цувааны эхний автомашинд явах бөгөөд цувааны эхэнд хамгаалалтын автомашин, төгсгөлд нөөц автомашин явна;
- Цувааны эхний болон сүүлчийн автомашин "цуваа" гэсэн тод бичлэгтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг автомашин бүрийн урд болон ард талд харагдахуйцаар жигд байрлуулна.
- Аюултай ачаа тээвэрлэсэн автотээврийн хэрэгслийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ.

Дотоодын цэргийн хамгаалалттай хуулийн этгээдийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээврийн замд харгалзан хүргэх үүргийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл:

№	Жил	Тээвэрлэсэн тоо	Хүн	Хоног	Цаг	Явсан км	Харгалзан хүргэсэн ачаа		
							Тонн/кг	Метр	Ширхэг
1	2019	678	696	1045	3789	789.543	10.548.649 кг	3,785,654 метр	4,546,741 ширхэг
2	2020	983	1003	3064	9541	965.841	Цианит натри 654,489 кг Тэсрэх бодис 6,561,645 кг	4,985,554 метр	6,113,478 ширхэг
3	2021	856	925	1984	5214	854.103	Цианит натри 653,779 кг Тэсрэх бодис 10,464,771 кг	4,995,463 метр	6,668,964 ширхэг
4	2022	979	993	2045	5962	894.756	Цианит натри 1,377,412 кг Тэсрэх бодис 11,449,322 кг	5,458,632 метр	7,115,652 ширхэг
5	2023	1076	1115	4058	9864	1.548.952	Цианит натри 5,899,512 кг Тэсрэх бодис 12,366,478 кг	10,557,965 метр	9,458,964 ширхэг

Дээрхи хүснэгтээс харвал сүүлийн 5 жилийн интервалаар авч үзэхэд тэсэрч дэлбэрэх бодисн тээвэрлэлтийн хамгаалалт цаашид улам өсөх хандлагтай, ачаалал их байгаа тул өнөөгийн зохицуулж байгаа эрх зүйн акт учир дутагдалтай байгааг цаашид анхаарах шаардлага гарч байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар буюу 2024 оноос Дотоодын цэргийн 809 дүгээр анги хариуцан ажиллаж байна.

Дүгнэлт. Манай оронд байлдааны зориулалттай тэсрэх бодис, бүтээгдэхүүний илэрцийн тоо хэмжээ буурахгүй байгаа нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд аюул занал учруулж байгаагаас гадна, хууль бус эргэлтээр олж авсан тэсрэх бодис, тэсрэх хэрэгслийг "Террорист ажиллагаа"-нд ашиглахгүй гэсэн баталгаа байхгүй байна. Иймээс тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагаа нь цэргийн хамгаалалтад явагдах нарийн төвөгтэй, асуудал тул олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн хөгжүүлэн бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх, тодорхой төсөв хөрөнгийг улсын төсөвт жил бүр тусгайлан суулгаж өгдөг байх, бүтэц, зохион байгуулалт, техник хэрэгслийн хувьд боловсронгуй болгох, хүний нөөцөө сургаж бэлтгэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн, зохицуулах, сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Санал:

1. Хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодис, инженерийн мэргэжлийн чиглэлээр ажиллах мэргэжилтэнг гадаадын их, дээд сургуулиар бэлтгэх эсвэл энэ чиглэлийн дээд боловсрол эзэмшсэн инженерүүдийг сонгон авч, цагдаагийн мэргэжлийн богино хугацааны сургалтад хамруулж, хосолсон мэргэжилтэн бэлтгэх.

2. Одоо ажиллаж байгаа офицер, ахлагч нарт уул уурхайн маркшайдэр, инженер, галын байцаагч зэрэг мэргэшсэн хүмүүсээр хамтарсан ажлын байран дахь сургалтыг явуулах.

3. Дотоодын цэрэг нь хуулийн хүрээнд өөр бусад үйл ажиллагааг явуулж ажлын ачаалал өндөр байгаа тул алба хаагчаас үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор хосолсон хэлбэрээр үүрэг гүйцэтгүүлэх.

4. Байгууллага, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллах. Жишээ нь: тээвэрлэлтийн хамгалалтын үед зогсох, жолоочийг амраах, онцгой байдлын байгууллага нь өөр өөрийн хариуцсан хэсэгт хяналт тавьж, хамтран ажиллах шаардлагатай байна.

5. Бичил уурхайд гар аргаар тэсрэх бодис үйлдвэрлэхийг эрс хориглох. Ингэснээр тэсрэх бодисын хууль бус эргэлтийг буурна.

6. Эх орныхоо байгалийн баялаг, эрдэс бодис, давс, хужир, шүү одоо ажиллаж байгаа үйлдвэрүүдийн илүүдэл, хаягдал, хүхрийн хүчил, биодизель түлшний үйлдвэрийн хаягдал глицерин, хавар намрын цагт их хэмээр ялгаран зам, талбай гудамжийг бохирдуулан хаягддаг модны хөвөн, энд тэндгүй хаягддаг хуванцар сав, ундааны лааз, удахгүй манайд ашиглалтад орох нефть нэрэх, нүүрс коксжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ашиглан, Монгол оронд дарь, тэсрэх бодисын үйлдвэр байгуулах боломж байгааг судлах.

7. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлж, стратегийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр нэг орноос хараат бус байх зорилтыг биелүүлэхэд зэвсэг галт хэрэглэлийн үндэсний үйлдвэрлэл чухал байгаа зэрэг нийгэм эдийн засгийн хувьд ашигтай арга хэмжээг зохион байгуулах.

Эх сурвалжийн жагсаалт

Нэг. Монгол Улсын хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
2. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. УБ., 1993.
3. Цагдаагийн албаны тухай хууль. УБ., 2017.
4. Дотоодын цэргийн тухай хууль. УБ., 2017.
5. “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль УБ., 2013
6. Онц байдлын тухай хууль. УБ., 1995.

Хоёр. Ном, сурах бичиг, сэтгүүл

1. Б.Чадраабал. Дарины үйлдвэрлэл. УБ., 2013
2. А.Хүү-Ухнаа, Б.Чадраабал. Дарь, тэсрэх бодисын шинж чанар, үйлдвэрлэл, хэрэглээ. УБ. 2011

**УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ХАМГААЛАЛТАД АЛБАНЫ НОХОЙГ
АШИГЛАХ, СУРГАЖ БЭЛТГЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ**
**ISSUES TO BE CONSIDERED IN THE USE AND TRAINING OF OFFICE DOGS FOR THE
PROTECTION OF OBJECTS OF PRIVATE NATIONAL OBJECTS**

Дотоод хэргийн их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Дотоодын
цэргийн албаны тэнхимийн багш
Ахмад Б.Ариунтөгс
ariuntugs_0304@yahoo.com
Department of Internal Troops
Service of the Police School, University of Internal
Affairs Mongolia Lecturer, capitan Ariuntugs.B

Хураангуй: Объектын хамгаалалтанд албаны нохой ашиглах, албаны нохойны ойлголт болон ашиглалт холбогдох хууль тогоомж ба гадаад улс орнууд албаны нохойг хархэн ашиглаж байгааг Дотоодын цэргийн байгууллагын хамгаалалтад ашиглагдаж байгаа албаны нохойн хөтөч, нохойн сургалт бэлтгэл, анхаарах асуудлын талаар авч үзлээ.

Summary: The use of service dogs in the protection of objects, the understanding and use of service dogs, the relevant laws and the use of service dogs by foreign countries have been discussed in terms of service dog guides, dog training and preparation, which are used for the protection of domestic military organizations, and issues to be considered.

Түлхүүр үг: Дотоодын цэрэг, харуул хамгаалалт, албаны нохой, сургалт бэлтгэл
Key words: Internal troops, guard, service dog, training

Үндсэн хэсэг: Хүн төрөлхтөн эрт дээр үеэс нохойн соргог, хурдан шаламгай хөдөлгөөн хүнд амархан дасамтгай, хүний аж амьдралд тустай чанаруудыг мэдэх болсноор чулуун завсгийн дунд үе буюу барагцаагаар 30-40 мянган жилийн өмнө тус амьтныг гэрийн тэжээмэл амьтан болгон гаршуулж, итгэлт сайн нөхрөө болгон гаршуулж өөрийн болон гэр орноо хамгаалах үйл ажиллагаанд ашиглаж иржээ.

Манай орны хувьд НАХЯ сайдын 1958 оны 10 дугаар сарыг 18-ны тоот тушаалаар эрэлч нохойн хоолны норм, тоног төхөөрөмж бэлтгэх эрэлч нохойн албаны байр байгууллахаар шийдвэрлэж 2 айлын сууц ажлын контор бүхий нэг давхар байшинг барьж бий болгосноор албаны нохойн байртай болсон.

ЗХУ-ын нэрт анатомич И. П. Павлов нохойн дээр хийсэн эрдэм шинжилгээний туршилтын дүнд үндэслэн сүүн тэжээлт амьтдын "мэдрэлийн системийн үйл ажиллагааны онол"-ыг дэвшүүлж, тэдэнд мэдрэхүйн 5 эрхтэнг үйлчилж гадаад орчны элдэв үзэгдэл, нөлөөг мэдрэн төв мэдрэлийн систем дамжуулж байдгийг тогтоосон билээ. И.П.Павловын шинжлэх ухааны үндэстэй энэхүү судалгаанд үндэслэн нохойн мэдрэмж, үнэрч авьяасыг гэмт хэргийн халуун мөрөөр ашиглах явдлыг нээн хэрэгжүүлжээ.

Эрэлч нохойн төлөөлөгчийн 1964 онд дотооддоо сургаж эхэлсэн бөгөөд 1967 оноос эрэлч албаны нохой хамгаалалт, эргүүл шалгалтад ашигладаг болсон байна.

Монголын ЦСБ-ын эрэлч нохойн албыг дасгал сургууль бүхий нохойгоор хангах ажил чухал зорилт болж байжээ. Анх 1952 онд Монголд ажиллаж байсан ЗХУ-ын 54 дүгээр трестээс 1 нохой авч Эрэлч нохойн алба гараагаа эхэлж байсан бол ЗХУ-аас 1957 онд -2, Чехословак Улсаас 1960 онд -3, БНАГУ-аас (1977 онд -20, дотооддоо 1961 онд -2, 1965 онд -1, 1968- онд 16, 1974 онд -10 1981 онд -10, 1985-12, 1987 онд -10, 1989-9, 1987 онд дотооддоо 15 нохой сургаж бэлтгэж байжээ.

Албаны нохой гэдэг нь сурах бичиг дээр тэмдэглэгдсэнээр “Албанд ашиглаж байгаа ерөнхий болон мэрэгжлийн сургалтад нохой хөтлөгчийн хамт бэлтгэсэн төрийн эрх бүхий байгууллагаас албаны нохойн гэрчилгээтэй нохой”-г ойлгоно. Улсын онц чухал объектийн хамгаалалтын үйл

ажиллагааны стандартад албаны нохой гэдгийг “Албаны нохой” гэж харуул хамгаалалтад ашиглах зорилгоор сонгож авсан, мал эмнэлэг, ариун цэврийн үзлэгт хамрагдсан, анги, салбар, салааны бүртгэлд авагдсан нохой байна.

Нохойг сургахад сургагч буюу хувь хүнээс маш их тэвчээр шаарддаг учраас уйгагүй хөдөлмөр хэрэгтэй байдаг. Дрессер гэдэг нь амьтан сургах гэсэн франц утгатай уг юм.'

Албаны нохойг объектын хамгаалалтанд ашиглах: Улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, гадны халдлагаас хамгаалах, тогтоосон дэглэм журам сахиулах, объектын нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор харуул хамгаалалтад нохой ашиглана

“Албаны нохой”⁹⁸ гаж харуул хамгаалалтад ашиглах зорилгоор сонгож авсан, мал эмнэлэг, ариун цэврийн үзлэгт хамрагдсан, анги, салбар, салааны бүртгэлд авагдсан нохой байна. Улсын онц чухал объектын харуулын цэгүүд нь албаны нохойтой байна. Албаны нохойд "Дайр, барь, зогс, суу" зэрэг команд дохиог заавал сургасан байна.

Харин ариун цэвэр, эрүүл ахуйн онцгой дэглэм сахиулах шаардлагатай, лабораторд албаны нохой ашиглахыг хориглоно.

Манай улсын хувьд нохойн алба нь хил хамгаалах ажилд нохойг авч ашиглаж эхэлснээр энэ чиглэлийн ажлын эхлэлийг тавьсан байна. Монгол улсын цагдаагийн байгууллагад албаны нохойг ашигласан түүхийг үндсэн гурван хасэгт хуваан авч үзэж болно. Цагдан сэргийлэх байгууллагад нохойн алба үүсэж бүрэлдсэн үе (1944- 1980 он) Цагдан сэргийлэх байгууллагад нохойн алба хөгжин цэцэглэсэн үе (1980-1990он} Нохойн албаны хөгжлийн өнө үе (1990 оноос хойш) гэж үечлэн хуваан үзэж болно. Одоогийн байдлаар манай оронд:

- Цагдаагийн байгууллага;
- Хил хамгаалах байгууллага;
- Гаалийн байгууллага;
- Төмөр зам;
- Тагнуулын ерөнхий газар;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;
- Дотоодын цэрэг;
- Иргэний агаарын тээврийн зэрэг албад өөрийн үйл ажиллагааны чиглэлээр албаны нохой

ашиглаж байгаа боловч олон улсын шаардлагад нийцүүлж албаны нохойг мансууруулах бодис илрүүлэх болон объектийн хамгаалалтанд ашиглах чиглэл хангалтгүй байна.

Объект хамгаалах харуулын нохой. Энэ төрөлд Кавказский, Азиатский овчарки, немец овчарки, Ротвейлер, Дорнод европ овчарки зэрэг үйлдэрийн нохойнуудыг ашиглаж болно.

Объект хамгаалах харуулын ноход хэрэглэх нь янз бүрийн объектуудын харуул хамгаалалтыг хүчтэй болгож хамгаалалтанд байх хүмүүсийн тоог хорогдуулах боломж олгодог. Харуулын нохойг объектод хүн орж ирэх үед чанга хуцах объект руу нэвтрэх гэж оролдсон хүнийг барих газар орныг нэгжихэд сургасан байна.

Харуулын нохойг объектод ашиглах төрөл:

- Объектод сул тавих;
- Хөдөлгөөнгүй блокпостод тоноглох;
- Хөдөлгөөнтэй блокпостод тоноглох;

1. Нөхцөлд цочируулагч нь: Хамгаал команд ба туслахын зүг рүү баруун гараараа зангах зангалт орхи зэрэг командууд байна.

2. Нөхцөлд бус цочируулагч: туслах саваагаар саваадаж нохойн уур хорслыг хөгжөөх зугтааж байгаа хунийг бариулж сургасны дараа эхэлдэг.

Шалган нэвтрүүлэгч объект хамгаалах нохойг бэлтгэдэг. Энэ төрөлд хар тамхи тэсэрч далбарах бодис хориотой бараа бүтээгдэхүүнийг илрүүлэх зорилгоор нохдыг бэлтгэж сургадаг. Шалган нэвтрүүлэх объект хамгаалах болон эргүүлийн гэсэн 2 хэлбэрээр ашиглаж болно. Эдгээр

⁹⁸ Д. Батдаваа. Албаны нохой. –УБ., 2014. 63 дахь тал

ноходыг тус тусад нь оор оор арга барилаар сургадаг. Энэ хэлбэрийн ноходыг сургаж ашиглах нь объектын хамгаалалт болон хориотой бараа бүтээгдэхүүнүүдийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Эрэлч нохойн алба нь ЗХУ, Герман, Чехословак, Унгар улсаас сайн үүлдрийн ноход авч ЗХУ-Д 8 удаа, өөртөө 5 удаа сургууль, курс хийж суралцдаг байсан бол 1990 оноос хойш нохойгоо дотооддоо сурган бэлтгэх болсон байна. Үүний үрээр сургуультай нохдын тоо намэгдэж, дасгалжуулагч хөтлөгч нарын тоо өсөж, бүх 21 аймаг, нийслэлийн анги салбар бүрт эрэлч нохой үйлчлэх болжээ. 1994 онд 40-өөд, 1995 онд 60 нохойтой болж түүний 30-аад нь мэргэжлийн үүргээ биелүүлэх болсон байна.

Цэрэг Цагдаагийн Нохой бол, зарим газруудад К9 хүчин ч гэж хэлэгддэг бөгөөд энэ төрлийн ажлын ноход өндөр түвшинд сургагдаж бэлтгэгддэг бөгөөд ялангуяа тэдний өөрсдийн ажил болох цагдаа нарт тусламж дэмжлэг үзүүлэх мөн бусад хууль сахиулах ажлуудад бие бүрэлдэхүүн болон оролцдог.

Энэ ажилд гол төлөв ашиглагддаг үүлдэр нь бидний мэдэх алдарт Герман Овчарка хэдий ч одоо Бельгийн Малинойс-ууд энэ ажилдаа хамгийн алдартай, эрэлттэй болсон ажээ. Олон төрлийн гэмт хэргийн ба алан хядах ажиллагаануудад санаатай, зориудын шинж чанартайгаар маш олон цэрэг, цагдаагийн ноход хүнд гэмтэх цаашлаад алагдах нь энэ хэцүү нийгэмд болон ялангуяа дайн байлдааны халуун цэг дээр алба хааж, ашиглагдаж буй нохдын дунд энгийн үзэгдэл төдийхөн юм.

Бидний сайн мэдэх Герман Овчарка болон Бельгийн Малинойс гэсэн гаргасан амжилт, алдар нар, гавьяа шагналаараа аль хэдийнээ хүн төрөлхтөнд танигдсан алдартай ноход олон газар нутаг, улсуудад нийтлэг, Цэрэг Цагдаагийн байгууллагад ихээр ашиглагддаг учраас их олдоцтой байдаг. Гэхдээ л цэрэг цагдаагийн зориулалтаар ашиглагддаг ноход гэсэн жагсаалтад эднээс гадна л гэхэд Датч Хоньч гэгддэг Голланд Овчарка, алдар нэртэй маш олон нохдыг экспортолж гаргадаг.

Герман улсаас угсаа гарал бүхий хамгаалагч Роттвойлер, Урчгэр Боксер, уран баримал Доберман, том Шнаузер гэх мэт ноход Америкийн нэгдсэн улсын төлөөлөл болсон Питбуллтерриер, Стаффордшир Терриер гэх нохдын үүлдэрүүд багтдаг ажээ.⁹⁹

Нохойг үүргээр нь тодорхойлон ангилбал:

Хайгуулын болон аврах ажиллагааны: Энэ ажилд оролцдог нохой алга болсон хүмүүс болон бусад зүйлсийн байршлыг тодорхойлох, олоход ашиглагддаг. Дэлхийн хамгийн алдартай мөрч нохойн үйлдэр болох Блүүдхоунд-ууд ихэвчлэн энэ даалгаварт ажилладаг.

Илрүүлэх-тэсрэх бөмбөг илрүүлэгч: Зарим төрлийн ноход хууль бус хортой бодис болон мансууруулах үйлчилгээтэй тамхи, мансууруулагч-уудыг шинжилж үнэрлан илрүүлэх ажил хийдэг. Ихэвчлэн улсуудын хил гааль, хилийн бус газруудад байршилж ажилладаг. Олон орнуудын онгоцны буудал дээр үнэрч Беагле үүлдрийн ноход цүнх, ачаа тээшийг шалгах ажлыг хийж, тухайн улсруу нэвтрүүлэх эрхийг албан бусаар олгож өгдөг гэхэд болох бөгөөд гэлээ ч тэдэнд зорчигчдод тааламжтай бус харагдахаар ширүүн төрх, ерөнхий байдал байхгүй харин ч байгалиас заяасан найрсаг хайр хүрмээр төрх байдалтай ноход юм.

Герман овчарка: Офицерүүдийг хамгаалах, эргүүлийн сургуулилттай нохой, тусгайлан заасан талбайг хянах, агаарын орчинд ажиллах, хүний байршил тогтоох, эрэлч, хорт бодисын байршилыг тогтоох, зэргээр сургаж бэлтгэдэг байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйл. Албаны нохой ашиглах¹⁰⁰ талаар тусгасан байдаг бөгөөд энэ хуулийн заалтад: Цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, авран хамгаалах зорилгоор албаны нохой ашиглаж болно.

Цагдаагийн алба хаагч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй, зэвсэглэсэн этгээд зугтаасан, довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг албаны нохой ашиглахыг

⁹⁹ Г.Батболд. Монголын нохойн түүх архелогийн судалга. –Уб., 2022. 25 дахь тал

¹⁰⁰ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

хориглоно. Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.

Нохойн сургагч нар дараах зарчмын баримтлан албаны нохойн сургалтыг зохион байгуулдаг. Үүнд:

- Нохой сургах онолын үндсийг судлах;
- Нохой сургалтыг арга барил сургалтын процессын дэс дарааг судлах;
- Шинжлах ухааны үүднээс авч үзвэл нохойд дэс дараатай үйлдэл хийлгэх замаар рефлекс суулгах үйл ажиллагаа юм. Мөн нохойн дасгал сургуулилтыг ерөнхий дасгал ба тусгай дасгал гэж ангилан авч үздэг.

Ерөнхий дасгал гэдэг нь: Нохойг дуулгавартай тэсвэртэй байлгах зарэгцүүлж авч явах суулгах хэвтүүлэх зогсоох өөр дээрээ дуудах эд зүйлс хайлгах зарэг дасгалууд юм.

Тусгай дасгал гэдэг нь: Мэргэжлийн буюу цагдаа нисэх гааль царгийн хэрэг ажилд онцгой байдал тагнуулын алба цирк тоглуулах хараагүй хүнийг хөтлөх гэсэн мэргэшсэн нохой бэлтгэх ойлголтыг хамааруулан ойлгодог.

Дотоодын цэргийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Тустай хэрэгслийн төрөл¹⁰¹-д Дотоодын цэргийн байгууллагын алба хаагч нь Нэг бүрийн; Олон хүнд нөлөөлөх; бусад гэсэн төрлийн тусгай хэрэгслийг ашиглах бөгөөд албаны нохойг бусад төрлийн тусгай хэрэгслийн төрөлд авч үзэж болох юм.

Дотоодын цэргийн үйл ажиллагаанд нисдэг тэрэг, тусгай зориулалтын хуягт тээвэрлэгч, хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон бусад тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, галт хэрэглэл,гэрэл, дууны хэрэгсэл, тусгай будагч, тэмдэглэгч хэрэгсэл болон бусад тусгай хэрэгсэл, албаны нохой ашиглаж болно гэж тусгасан нь албаны нохойг хамгаалалтад ашиглах үндэс болсон байна.

Дотоодын цэргийн тухай хуулийн 27 дугаар зүйлд албаны нохой ашиглах¹⁰² Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор албаны нохой ашиглаж болно. Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг холбогдох хуульд заасны дагуу тогтооно гэж хуульд тусгасан байна. Тухайлбал, “Объектыг түр ачаа тээшийг харгалзан хүргэх”¹⁰³ үед, мөн шаардлагатай тохиолдолд зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх ажиллагаанд албаны нохой ашиглаж болно гэж заасан байна.

- Улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, гадны халдлагаас хамгаалах, тогтоосон дэглэм журам сахиулах, объектын нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор харуул хамгаалалтад нохой ашигладаг.

- “Албаны нохой” гэж харуул хамгаалалтад ашиглах зорилгоор сонгож авсан, мал эмнэлэг, ариун цэврийн үзлэгт хамрагдсан, анги, салбар, салааны бүртгэлд авагдсан нохой байна.

- Улсын онц чухал объектын харуулын цэгүүд нь албаны нохойтой байна. Албаны нохойд “Дайр, барь, зогс, суу” зэрэг команд дохиог заавал сургасан байна.

- Ариун цэвэр, эруул ахуйн онцгой дэглэм сахиулах шаардлагатай лабораторд албаны нохой ашиглахыг хориглоно.

Нохойн байр: Албаны нохойг харуулын цэгт 3 метрээс илүүгүй зайд зориулалтын байр /нохой дотор нь чөлөөтэй эргэх боломжтой, наран талруу харсан хаалгатай, 85см өндөртэй байна.80см урттай 80см өргөнтэй 3см-ын зузаан модон банзаар хийсэн, дотор талыг нь дулаалсан, дээвэр нь гурвалжин нохойн байрны дотор талын хэвтэрийг элс, хайрга, керамзетээр давхарлан дулаалсан, хүрэн улаан өнгөөр будсан хаяаг шороогоор манасан/-д байрлуулна.

Гадаад улс оронд албаны нохой ашиглахдаа: Нохой бол цагдаа болон бусад хууль сахиулах ажилтнуудад туслах зорилгоор тусгайлан балтагдсан нохой юм. Тэдний үүрэг бол: мансуулах бодис, тасарч дэлбэрэх бодис хайх, сураггүй болсон хүмүүсийн байршлыг тогтоох, хэргийн газрын

¹⁰¹ Дотоодын цэргийн тухай хууль 2017 он <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12474>

¹⁰² Дотоодын цэргийн алба ажиллагааны дүрэм 2022 он <https://legalinfo.mn/mn/detail?lawId>

¹⁰³ Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт

нотлох баримтыг олох, цагдаагийн байгууллагын болсон хүмүүст халдах. Цагдаагийн ноход хэд хэдэн аман дохио, гарын дохиог санаж байх ёстой байдаг.

Австрали-Австралийн Холбооны цагдаа болон бусад хууль сахиулах байгууллагууд нисэх онгоцны буудлын үүрэг зэрэг аюулгүй байдлын тэргүүлэх чиглэлд К9 -ийг ашигладаг гэдгээрээ алдартай.

Бангладеш-Бангладешийн Хилийн цэргийн анги, Шуурхай ажиллагааны баталион, Дака хотын цагдаа нар хар тамхи, бөмбөгдөлтийн эсрэг кампанит ажилд туслах хэд хэдэн нохойн отрядыг ажиллуулдаг.

Бельги-Бельгийн нохой тэжээх бүлэг нь тус улсын холбооны цагдаагийн газрын нэг хэсэг юм. Энэ нь 35 нохойны багтай бөгөөд ихэнх нь Бельгийн Малиной юм. Зарим нохойг мансууруулах бодис, хүний үлдэгдэл, гормон эсвал галын хурдасгуурыг илрүүлэхэд сургадаг. Гуравны нэг орчим нь амьд хүмүүсийг олох, таних зорилгоор сургагдсан нохой юм. Эдгээр багууд ихэвчлэн нурсан барилгад дарагдсан хүмүүсийг олохын тулд газар хөдлөлтийн бусад ажиллуулдаг. Холбооны цагдаагийн тэсрэх бодис илрүүлэгч нохойг Холбооны цагдаагийн тасаг бэлддэг.¹⁰⁴

Монголын ЦСБ-ын эрэлч нохойн албыг дасгал сургууль бүхий нохойгоор хангах ажил чухал зорилт болж байжээ. Анх 1952 онд Монголд ажиллаж байсан ЗХУ-ын 54 дугаар трестээс 1 нохой авч Эрэлч нохойн алба гараагаа эхлэж байсан бол ЗХУ-аас 1957 онд -2, Чехословак Улсаас 1960 онд -3, БНАГУ-аас 1977 онд - 20, Дотооддоо 1961 онд -2, 1965 онд -1, 1968- онд 16, 1974 онд -10, 1981 онд - 10, 1985-12, 1987 онд -10, 1989-9, 1987 онд дотооддоо 15 нохойг сургаж балтгэж байжээ.

2014 оноос хэрэгжиж эхэлсэн эрх зүйн шинжлэлтийн хүрээнд шинчлэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 59 дугаар тушаалаар Сургалт дадлагын төвийг Сургалтын хэлтэс, Албаны нохой, морь сургалтын хэсэг гэсэн 3 нэгжтэй байгуулсан.

Мөн даргын 2015 оны Б/253 дугаар тушаалаар Албаны нохой, морь сургалтын хэсгийг тасаг болгон өргөтгөсөн бол Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 12-ны одрийн Б/180 дугаар тушаалаар Сургалтын төвийг Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтэс. Хээрийн сургалтын хэсэг гэсэн 4 нэгжтэй байхаар шинэчлэн батласан.

Хууль зүй Дотоод хэргийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 13 ны өдрийн А/55 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стратеги зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр бүтэц орон тоо шинэчлэн баталсантай холбогдон Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр 14-ний өдрийн А/24 дүгээр тушаалаар тус төвийн нэршлийг Цагдаа, Дотоодын цэргийн сургалтын төв болгон өөрчилж Захиргаа удирдлагын хэлтэс Сургалтын хэлтэс Албаны нохойн сургалтын хэлтэс, Хээрийн сургалтын хэлтэс гэсэн 4 нэгжтэй байхаар батлагдан үйл ажиллагаа явуулж байна.

Дүгнэлт. Өнөөдөр улсын онц чухал объектын хамгаалалтад албаны нохойг ашиглах явдал байгаа хэдий ч тусгай бэлтгэгдсэн нохой тэр болгон ашиглаж чадахгүй, тусгай нохойн хөтөч албан тушаал байхгүй, харуулчин ахлагч нар өөрсдөө нохой авчиран дур мэдэн ашиглах явдал цөөнгүй байгаа нь харагдаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сургалтын нэгдсэн төвийн Албаны нохойн сургалтын хэлтэс нь цагдийн байгууллагын алба үйл ажиллагаанд албаны нохойн хөтөч, албаны нохойн тусгай сургалтыг зохион байгуулдаг боловч улсын онц чухал объектын харуул, хамгаалалтад тусгайлан зориулж албаны нохойн хөтөч, болон албаны нохойг сургаж бэлтгэдэггүй байна.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дотоодын цэргийн байгууллагад мэргэжлийн нохой сургагч байхгүй байгааг анхаарч, албаны нохой сургагчтай болох тал дээр удирдлагын түвшинд ярилцаж, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

2. Объектын хамгаалалтад албаны нохой сургах тал дээр сургалт зохион байгуулах гадны улс оронтой туршлагага солилцож мэдлэг туршлага хуримтлуулах

¹⁰⁴ Роял Каннин. Герман хоньч нохой. –Уб., 2021. 15 дахь тал

3. Шалган нэвтрүүлэх объект хамгаалах нохойг тусад нь бэлтгэж ажиллуулах,
4. Албаны нохойд оногдож буй хоол хүнсний нормыг өгөх [өдрийн 10 мянга]
5. Нохойн байрийг хүйтний улиралд дулаалах
6. Амьтний эрхийг хамгаалах

Ашигласан материал

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. Дотоодын цэргийн тухай хууль
3. Д. Батдаваа. Албаны нохой. Уб., 2014.
4. Г.Батболд. Монголын нохойн түүх архелогийн судалгаа. Уб., 2022
5. Роял Каннин. Герман хоньч нохой. Уб., 2021
6. Төрийн мэдээлэл. 2017. №8
7. Төрийн мэдээлэл. 2017. №8
8. <https://legalinfo.mn>